



**ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ**

**ЦАЦ**

**СУРГАЛТ, СУДАЛГАА,  
АРГА ЗҮЙН УЛИРАЛ  
ТУТМЫН СЭТГҮҮЛ**

**2022 №23/46/**

- **С.Пүрэвдорж: Иргэний хамгаалалтыг үндэсний даван туулах чадвартай уялдуулах нь**
- **А.Ганбилэг: Үндэсний аюулгүй байдлыг хангахад хил хамгаалалтын системийн оролцоо**
- **Н.Энхбат: Агаарын цэрэг болон радиотехникийн анги, салбарын хөгжлийн чиг хандлага**
- **Ц.Бямба-Эрдэнэ, Э.Түвшин: Уйгарын архитектур ба уран барилгын чимэглэл**



**ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИАС ЭРХЛЭН ГАРГАВ**







# ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ

## СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

### Ерөнхий эрхлэгч:

Хурандаа Б.Өлзийхуяг ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэлийн асуудал хариуцсан дэд захирал, доктор (Sc.D), профессор

### Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Хурандаа Б.Мандахбаяр Эрдэм шинжилгээ, инновацын хэлтсийн дарга, доктор (Ph.D)

### Редакцийн гишүүд:

Хошууч Л.Одмаа ЦНДС-ийн Цэргийн холбоо, кибер аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)

Б.Баатарсүрэн БХЭШХ-ийн Батлан хамгаалахын дүн шинжилгээний төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Х.Орхончимэг БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

### Техник редакцийн гишүүд:

Д.Насанжаргал Дизайнер

### Редакцийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, БНМАУ-ын баатар Д.Нянтайсүрэнгийн гудамж, 16 дугаар хороо, Улаанхуаран

**Утас/факс:** 976 11 480172

**Шуудангийн хайрцаг:** 13300

**Веб хаяг:** [www.mndu.gov.mn](http://www.mndu.gov.mn)

**Цахим шуудан:** [tsats@mndu.gov.mn](mailto:tsats@mndu.gov.mn)

**Олон улсын индекс:** ISSN 2313-8076

**Эрхлэх байгууллага:** Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургууль

**Хэвлэх үйлдвэр:** ҮБХИС-ийн Хэвлэх үйлдвэр



## FOR INTELLECTUAL AND CREATIVE THINKING

---

### EDITORIAL BOARD

#### Editor-In-Chief

Colonel Ulziikhuyag.B Deputy Director for Research and social partnership Prof. (Sc.D)

#### Deputy Editor-In Chief

Colonel Mandakhbayar.B Chief of Division for Research and innovation, MNDU, Ph.D

#### Editorial Panel

Major Odmaa.L Senior Lecturer of Military Signaling and cyber security Department of Joint Military School, MNDU, Ph.D

Baatarsuren.B Research fellow, Center of Defense Analyses, Institute of Defense Studies, MNDU, Ph.D

Orkhonchimeg.Kh Research fellow, Center of Security and Defense Studies, Institute for Defense Studies, MNDU, Ph.D

#### Technical Editor

Nasanjargal.D Designer, Illustrator

#### Address:

Mongolian National Defense University  
Nyantaisuren Street, Bayanzurkh District, Ulaanbaatar, Mongolia,13300

**Phone:** 976 11 480177

**Fax:** 976 11 480172

**Mail box:** 13300

**Website:** [www.mndu.gov.mn](http://www.mndu.gov.mn)

**E-mail:** [news@mndu.gov.mn](mailto:news@mndu.gov.mn)

**ISSN:** 2313-8076

**Host:** Mongolian National Defense University

**Published by:** Defense Press



ҮНДЭСНИЙ БАТЛАН  
ХАМГААЛАХЫН  
ИХ СУРГУУЛИАС  
ЭРХЛЭН ГАРГАВ.

2022  
№23/46/

СУРГАЛТ,  
СУДАЛГАА, АРГА  
ЗҮЙН УЛИРАЛ  
ТУТМЫН  
СЭТГҮҮЛ

## ДУГААРЫН ТОВЧООН

### 1. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал

Ч.Сосорбарам: Үндэсний ой санамж ба үндэсний аюулгүй байдал .....	6
С.Пүрэвдорж: Иргэний хамгаалалтыг үндэсний даван туулах чадвартай уялдуулах нь .....	9
Х.Орхончимэг, С.Байгалмаа: Үндэсний аюулгүй байдалд үнэт зүйлсийн үзүүлэх нөлөөний тухайд .....	15
А.Ганбилэг: Үндэсний аюулгүй байдлыг хангахад хил хамгаалалтын системийн оролцоо .....	22

### 2. Батлан хамгаалах боловсрол, цэргийн сургалт

Н.Энхбат: Агаарын цэрэг болон радиотехникийн анги, салбарын хөгжлийн чиг хандлага .....	31
Б.Баатарсүрэн: ОХУ-ын Украин улсад явуулж буй Цэргийн Тусгай Ажиллагаа (ЦТА)-ны цэргийн сургалт бэлтгэлийн талаарх шинжилгээ .....	36

### 3. Судалгаа боловсруулалтын ажил

Д.Энхчимэг, Т.Мөнх-Оргил, Д.Нямхүү: Тогтворжуулах бодлогын онол загварчлал .....	41
Э.Ганзориг, Б.Баярцэцэг: Төмөр бетон араг бүтээцийн газар хөдлөлийн тэсвэрлэлтийг үнэлэх аргуудын судлагдсан байдлын харьцуулсан судалгаа .....	46
М.Индрабүд, П.Мөнхтөр: Авлигалд албан хаагчийн хувийн болон нийтийн сонирхлын зөрчил нөлөөлөх нь .....	56
Б.Банзрагч: Судалгааны их сургуулийн үндсэн үзүүлэлтүүдийг эргэцүүлэх нь .....	65

### 4. Цэргийн зэвсэглэл техник, инновац судлал

Т.Энхзаяа, Г.Нямхүү: Цэргийн радиостанцыг сонгоход анхаарах зарим чухал үзүүлэлтүүд .....	70
---	----

### 5. Шинжлэх ухаан судлал, дайны туршлага сургамж

Н.Наранхүү: БНМАУ-ын аюулгүй байдалд гадаад орчны үзүүлсэн нөлөө (1920-оод оны сүүлч 1930-аад он) .....	78
Ц.Бямба-Эрдэнэ, Э.Түвшин: Уйгарын архитектур ба уран барилгын чимэглэл .....	89
Т.Эрдэнэхишиг: Хүннү гүрний түүхэн нутаг дэвсгэр .....	97



## ҮНДЭСНИЙ ОЙ САНАМЖ БА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

**Ч.СОСОРБАРАМ** /Доктор (Ph.D), дэд профессор, бригадын генерал/

**Түлхүүр үг:** Ой санамж, аюулгүй байдал, соёл, төр

**Key words:** Memory, security, culture, state

Даяаршлын эрин зуунд ч гэсэн орчин үеийн улс орнууд үндэсний онцлог - адилтгалаа (national identities) өнгөрснөөс олж тодруулах зорилгоор ихээхэн хөрөнгө хүч зарцуулсаар байна. Үндэсний ой санамж бол ерөнхий ой санамжийн нэг тусгай хэлбэр бөгөөд чухамдаа хамтын ой санамж юм<sup>1</sup> гэж эрдэмтэд үздэг. Үндэсний ой санамж нь улс орны нэгдсэн (хамтын) адилтгалын түлхүүр бүрдүүлэгч юм<sup>2</sup>. Ерөнхийдөө дээрх ЯАБ-ын үзэл баримтлалын заалтууд болон манай судалгааны багийн эрдэмтдийн үндэсний ой санамжийн талаарх шинэ тодорхойлолтууд дээр дурдсан ойлголтууд болон өөр хоорондоо агуулгаараа шууд холбогдож байна.

Академич Ж.Болдбаатар “Үндэсний ой санамж нь уламжлал, шинэчлэлийн улбаанаас үр гарган түүх, хэл, соёлоо мэдэх, хайрлан хамгаалах, өвлөх, залгамжлах хэмээсэн цогц үзэл санаа болой” гэжээ.

Доктор Б.Даш-Ёндон “Философи шинжилгээний үүднээс үзсэн үндэсний ой санамж нь үндэстэн өөрийгөө ухамсарлахуйн түүх, шинж байдал, явц юм”, “Үндэсний ой санамж тухайн үндэстний түүхийн явцад бүрэлддэг бөгөөд уг үндэстний философи, үзэл суртал, шашин, ёс суртахуун, зан заншил, эрхийн ухамсарт нь шингэсэн байдаг. Үндэстэн өөрийгөө зөв ухамсарласан тэр дүр төрх нь үндэсний ой санамжийн “алтан хайрцаг”, тухайн үндэстэн ямагт “дотроо бодож

явах” ёстой тэр зүйл нь” юм гэсэн байна.

Доктор Н.Жалбажав “Ой санамжийг ерөнхийд нь бодгалийн (хувь хүний), хамтын буюу олонлогийн, улс үндэстний, хүн төрөлхтний нийтлэг ой санамж” хэмээн ангилан авч үзсэн байна.”

Тэр бээр “Хүн бол байгалийн зүйлээс гадна нийгмийн зүйл болохыг бид мэднэ. Ой санамжийг түүний онцлог, өвөрмөц болон нийтлэг шинж чанарыг судлаад хамтын ой санамжийн дээд түвшин нь улс үндэстний ой санамж, цаашилбал хүн төрөлхтний ой санамж болдог байна. Хүний олонлог хувьсаж хөгжсөөр улс, үндэстнүүд төлөвшин тэдгээрийн түүх, соёл, иргэншил, үнэт зүйлс нь бүрдэж бий болжээ.” гэсэн байна.

Хүн төрөлхтний түүх, мэдлэгийн сан хөмрөг, үнэт зүйлс улс үндэстний ой санамжийг бий болгогч үндэсний түүхээр дамжин бүрэлдэн тогтож, үеэс үед уламжлагдан хөгжиж, баяжиж байдаг ажээ.

Судлаачдын судалгаа болон тайлбар толь бичгүүдэд бичсэнээс үндэслээд “үндэсний ой санамж - national memory - национальное память” гэдэг ойлголт нь үндэсний “туршлага”, “соёл” гэсэн хоёр үндсэн хэсэг, агуулгаас бүрддэг<sup>3</sup> гэж дүгнэж байна.

- Үндэсний “туршлага” гэдэг ойлголтод төрийн түүх-хаадын түүх, төрийн бодлого-удирдлагын буюу төрийн албаны тогтолцоо, архив зэрэг

<sup>1</sup> James V. Wertsch National Memory and Where to Find It. DOI:10.1093/oso/ 9780190230814.003.0012

<sup>2</sup> subscribe or oxfordscholarship.com/page/190/faqs" page/58/ Christina Davis

<sup>3</sup> Ой санамж (оросоор память, англиар memory)-ыг байгаль, нийгмийн шинжлэх ухаанууд (тухайлбал, хүний анатоми, физиологи, сэтгэл зүй, мэдрэл судлал, социологи, антропологи, философи, логик) өөр өөрсдийн судалгааны объект болгон нарийвчлан судалдаг байна.

тээгчдээс бүрдэх учиртай бөгөөд түүнийг “төрийн ой санамж” гэж нэрлэж болох юм.

- Үндэсний “соёл” гэдэг ойлголт тухайн үндэсний нь соёл урлаг, бичиг, хувцас, дуу хөгжим, идээ ундаа, домог туульс, шашин, ургийн бичиг бичиг зэрэг биет болон биет бус тээгчдээс бүрддэг тухайн үндэсний онцлогийг харуулдаг бөгөөд “нийгмийн ой санамж” гэж нэрлэж болох юм.

Эд бүгд нийлээд “National identity” буюу үндэсний түүхэн онцлогийг илтгэн харуулдаг байна.

Ерөнхийдөө үндэсний “ой санамж” гэдэг нь агуулгаараа тухайн үндэстний онцлог, үндэсний ухамсар, оюуны дархлаа, үндэсний үнэт зүйлс зэрэг судлагдахуунуудын үндэс цөм болж, тэдгээрийг холбож өгдөг суурь ойлголт бололтой.

Улсын түүхийг янз бүрээр тайлбарлах нь иргэд олон янзаар мэдээлэл цуглуулж, өөрийнхөөрөө ойлгох боломжтой болгодог бөгөөд тэд түүхийн соёл, нийгэм, улс төрийн агуулгыг өөр, өөрийнхөөрөө ойлгодог. Францад үүнээс үүдэн янз бүрийн цөөнх, цагаачдын олон бүлгүүдийн онцлогийг харгалзаагүйгээс түүхийн үндэсний сургалтын хөтөлбөр хэрэгжиж чадаагүй байдаг. Францын Бүгд найрамдах улсын “эрх тэгш, эрх чөлөөт ахан дүүс” гэсэн үнэт зүйлс нь түүний колоничлолын түүхээс болж олигтой дэмжигддэггүй зөрчилтэй ойлголт байдаг.

Төрийн удирдлага, төрийн албаны тогтолцоо төлөвшөөгүй бол төрийн ой санамж охорхон байж, улс орноороо хүний үгээр буруу тийшээ будаа тээх, төр засаг шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлаж шийдвэр гаргадаггүй бол зорилго зорилт нь хэрэгждэггүй түр зуурын болж, эдийн засгаа сүйрүүлэх, мэдээллийн технологид суурилсан сангүй бол авиалгалд идэгдэх, иргэд төрөө дээдлэхгүй байж, нийгмийн

ёс суртахуун доройтох эрсдэл өндөр байдаг.

Үндэсний түүх нэгдмэл болж чадаагүй бол нийгмийн зөрчил, сөргөлдөөнийг дагуулдаг, шашны асуудлаа шийдээгүй улс үндэстэнд хүчирхийлэл тасардаггүй, дайн байлдаанд ч хүргэдэг жамтай.

Монголчууд түүхэн тодорхой шалтгаанаар өөрийн үндэсний ой санамжаа гээж, аливаа шинэ зүйлсийг шууд дуурайдаг, өөрийн ухаанаа уралдуулж нутагшуулдаггүй, бусдын үгээр явж ирсэн нь ямар алдаанд хүргэдэг болохыг бүгд л мэдэрч эхэлж байнуудаа гэх бодол нийгэмд бий боллоо.

Доктор С.Дулам “Бага хаадын туршилтад ороод эе эвийг хичээдэг эрхэм чанараа гээсэн, Манжийн туршилтад ороод зэрэг дэвийгүл тоодог эрхэм чанараа гээсэн, коммунизмын туршилтад ороод дээшээ хов зөөдөггүй эрхэм чанараа гээсэн? Нео-либериализмын туршилтад ороод эд хөрөнгөнд шунадаггүй эрхэм чанараа гээсээр байна” гэж товчхоноор онож хэлсэн байдаг.

Ж.Андерсон “Ихэнх тохиолдолд монголчууд том шийдвэр гаргахынхаа өмнө тооцоо судалгаа төдийлөн сайн хийдэггүй, эрсдэлээ тооцдоггүй. Тэгж байтал улс төрд гарсан өөрчлөлт бүх зүйлийг өөр тийш нь эргүүлчихдэг. Нэг Засгийн газар гараад л хөгжлийн чиглэлийг нэг тийш нь залдаг бол, дараагийн Засгийн газар нь чиглэлээ бүрэн өөрчилдөг. Тэгэхээр бодлогын орчин тогтвортой байх, том хэмжээний зээл, төслийг эхлүүлэхийнхээ өмнө эрсдэлийг сайн тооцох нь Монгол Улсад зайлшгүй шаардлагатай гэж би үздэг”<sup>4</sup>.

Аливаа үндэстэн өөрийн болон бусдын түүхийн сургамжаас байнга суралцаж, төрийн үйл ажиллагааны алдаа оноогоо дэнсэлсэн ой санамжтай байж, түүндээ түшиглэн үндэсний үнэт зүйлсээ тодорхойлж, нэг зорилго

<sup>4</sup> Монголчууд том шийдвэр гаргахын өмнө судалгаа хийдэггүй, эрсдэлээ тооцдоггүй Зууны мэдээ 2018 оны 7 сарын 18



алсын хараатай нэг үндэстэн байж, төр засаг нь бодитой мэдлэг, мэдээлэлд тулгуурлаж төрийн бодлого шийдвэрээ гаргадаг байж хөгждөг жамтай.

Үндэсний ой санамжийг сэргээснээр үндэсний ухамсар, бахархлаа шинээр тодорхойлж нь эх оронч хүмүүжлийн асуудлыг шинээр авч үзэх үндэс анхдагч хүчин зүйл нь болох юм. Ийм учраас л УАБ-ын үзэл баримтлалд:

“Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно” гэж заажээ.

Өнөөдөр бид монголчуудын өвөг дээдэс энэхүү түүх, соёлыг бидэнд

хэрхэн хадгалж, хөгжүүлж, өвлүүлж, үлдээсэн түүхэн сургамж, хаадын алдаа сургамжийн талаар судлах нь үндэсний ой санамжийг сэргээх үйл ажиллагааны суурь дэвсгэр болох төдийгүй үндэсний аюулгүй байдлыг хангах үндэс болох ёстой юм.

Эдгээрээс дүгнэхэд Монголын өнөөгийн бүх бэрхшээл, хямралын үндсийн үндэс нь засаглалын чадамж-төрийн ой санамж доройтсонтой холбоотой бөгөөд энэ нь манай зонхилох улс төрчдийн мэдэгдэл төдийгүй судалгааны төвүүд, бусад байгууллагын судалгаагаар нотлогдож байна.

Засаглалын чадамж нь төрийн ой санамжаар өөрөөр хэлбэл төр нь ямар түвшинд сэтгэдэг, шийдвэр гаргадаг нөхцөл боломжоор хамгийн гол нь төрийн түшээдийн мэдлэг чадвараар тодорхойлогдох учиртай.

#### Ашигласан материал:

1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.УБ.,2010. <https://legalinfo.mn/mn/detail/6163>
2. Б.Даш-Ёндон .Үндэстэн өөрийгөө ухамсарлахын учир. "Манай Монгол" сэтгүүл.№3 . 1999. т.274
3. James V.Wertsch National Memory and Where to Find It. DOI:10.1093/oso/9780190230814.003.0012
4. [subscribe or oxfordscholarship.com/page/190/faqs](https://www.oxfordscholarship.com/page/190/faqs) " page/58/ Christina Davis



## ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫГ ҮНДЭСНИЙ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРТАЙ УЯЛДУУЛАХ НЬ

**С.ПҮРЭВДОРЖ** /БХЭШХ-ийн Дайн, цэргийн урлаг судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор/

**Түлхүүр үг:** Даван туулах чадвар, иргэний хамгаалалт, аюул занал, систем, уялдуулах чиглэл

**Key words:** Ability to overcome, civil defense, threat, system, coordination

**Оршил.** Үндэсний даван туулах чадвар нь зөвхөн цэргийн хүч, чадавх төдийгүй иргэний нийгмийн байгууллагуудыг хамааруулж, цаашид иргэд, олон нийтийн өргөн дэмжлэг, оролцоонд тулгуурлан улс орныг батлан хамгаалах тухай нийтлэг ойлголтыг агуулж байна. Үүнийг зөвхөн хүчний нэгдсэн тогтолцоо хэмээн томъёолж нэрлээд зогсохгүй “бүх нийтийн, иргэний хамгаалалтын болон орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах тогтолцоо гэж”<sup>1</sup> үзэж байна. Тухайлбал, “улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах”<sup>2</sup> гэсэн Монгол Улсын үндсэн хуулийн заалт; “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн, халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана”<sup>3</sup> гэсэн үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалт; “Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа болно”<sup>4</sup> гэсэн Монгол Улсын батлан

хамгаалах бодлогын үндэс гэсэн хууль эрх зүйн заалттай нийцэж байгаа юм.

**Үндсэн хэсэг.** Өнөө үед аюул заналын хэлбэр, агуулга өөрчлөгдөж, зарим уламжлалт аюул алсгагдаж, зарим шинэ аюул бий болж, тэр нь нэн тулгамдсан асуудлыг босгон ирж, хамгаалалтын хэлбэр, агуулгыг мөн өргөжүүлэн өөрчлөхийг нөхцөлдүүлж байна.

Аюул заналын шинэ хэлбэрт олон улсын терроризмын, үй олноор хөнөөх зэвсгийн хяналтгүй тархалт, тухайлбал биологийн халдвар, мэдээллийн аюул, дотоодын самуун, үймээн болон өнгөт хувьсгал зэргийг дурдаж болох байна.

Аюул байгаа цагт хамгаалалт зайлшгүй. Өнөө үеийн дайн, байлдаанд оролцогчдын дийлэнх олонх нь зэвсэглэсэн иргэд, амь үрэгдэгсдийн дийлэнх олонхыг энгийн иргэд эзэлдэг болжээ. Ш.Паламдорж нарын “Хүч тэнцвэргүй дайн, байлдаан”<sup>5</sup> (судалгаа, шинжилгээ)-ний бүтээлд дайн, зэвсэгт мөргөлдөөн дэх хүчний хувьд хүч хэрэгслээр дутмаг талын ажиллагаа нь цэргийн хүчийг ашиглахаас илүүтэй цэргийн бус хэрэгсэл, цэрэг биш, зэвсэглэсэн иргэд, бүлэглэлийн тактикийг ашиглахад илүүтэй анхаарч байгааг тэмдэглэсэн байна. Тухайлбал, дайн, зэвсэгт мөргөлдөөн нь дайтагч улс, эвсэл, талуудын эдийн засгийн чадавх, технологийн хөгжил эрс ялгаатай, талуудын цэргийн хүч, хэрэгсэл нь хоорондоо олон дахин

<sup>1</sup> Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх үзэл баримтлал. УБ., 2021 он. – 236 х; ЗХЖШ-аас орчуулан гаргасан гарын авлага., т-9;

<sup>2</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин найм дугаар зүйл. 2.6 заалт;

<sup>3</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 1.1.2. заалт;

<sup>4</sup> Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын батлан хамгаалах бодогын үндэс. 2.2. заалт;

<sup>5</sup> Хүч тэнцвэргүй дайн, байлдаан. УБ., 2018 он. – 186 х., т. 18-20;



зөрүүтэй, нэг тал нь асар хүчирхэг, нөгөө тал нь тун ядмаг тохиолдолд; дайтагч улс, эвсэл, талуудын хүч хэрэгсэл, сул тал нь арга буюу өөрийн нөхцөл, бүх ард түмний дэмжлэг, сэтгэл зүйн хат, оюун санаа, ухамсар дахь үнэнч болон туйлширсан үзлээр давуутай байдлыг үүсгэсэн тохиолдолд явагдах болжээ.

Түүнчлэн хүч тэнцвэргүй байдал зөвхөн цэргийн хүрээнд ч биш, үндэсний аюулгүй байдлын хүрээнд ч оршиж байгаа учир, хүч сул тал өөрийн давуу талыг оновчтой ашиглах, орон зай, цаг хугацааг эзэмдэх, эсрэг талынхаа эмзэг газрыг мэдэрч, цохилт өгөх, санаачилгыг олж авах, материаллаг талын дутагдлыг оюун санаа, ухамсрын давуутай талаараа арилгах ажиллагаанд шилжиж байна. Тэр нь сул талын ард түмэн, цэрэг дайчдын оюун санааны их чадварт оршиж байна хэмээн үзэж болохоор байгаа юм. Энэ хүч тэнцвэргүй дайны онол, арга зүй нь Монгол Улс гадны хүч давамгай түрэмгийлэлд өртөхөд хүрвэл ач тусаа өгнө хэмээн үзэж байна.

Ер нь дайн, зэвсэгт мөргөлдөөний үед тэмцэл явуулж, ялалт байгуулахад хангалттай хэмжээний хүч хэрэгсэл байж энгийн иргэдийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах сонирхлыг харуулах нь хамгийн чухал юм.

Ийм нөхцөл байдал олон улсын хэмжээнд өргөн дэлгэр болоод байхад манай улс дэлхийн их гүрнүүдийн хүрээлэлд буй тааламжтай байдалд дулдуйдан "иргэний хамгаалалт"-ын асуудлын төрийн болон нутгийн захиргааны төв байгууллагуудын дунд орхигдуулсан байдалтай байна.

Ш.Паламдорж нарын "Цэргийн нэр томьёоны тайлбар толь" бүтээлд "Иргэний хамгаалалтын байгууллага нь зэвсэгт мөргөлдөөн болон томоохон гамшгийн үед ард иргэдээ авран хамгаалах, шаардлагатай тусламжийг үзүүлэх боломжийн хэрээр иргэний зориулалттай объектод учрах хохирлыг хязгаарлах ажиллагааг

зохион байгуулах зорилготой<sup>6</sup>" гэж томъёолсон байна.

1920-оод оноос эхлэн Иргэний хамгаалалтын асуудал, түүний төлөвлөгөө хэлэлцэгдэж эхэлсэн бөгөөд дайны болон бөмбөг дэлбэрэх аюул нэмэгдэж байгаатай уялдуулан 1930-аад оны үед бие даасан улс орнуудад боловсруулагдаж, олон зуун зэвсэг гарч ирсний дараа дэлхийн хэмжээнд түгэн тархсан байна.

Дэлхийн II дайн дууссаны дараа иргэний хамгаалалтад онцлох хандлага, өөрчлөлт гарч дайсгнахаас хамгаалахаас гамшгаас хамгаалах чиглэлд шилжсэн байна.

"Иргэний хамгаалалт гэдэг нь хүн амыг хамгаалах, улс ардын аж ахуйн тогтвортой ажиллагааг хангах, дайсны цөмийн болон бусад цохилтод өртсөн хот, объектууд, цацраг идэвхт хордуулалт, үерийн аюул бүхий бүсэд аврах, сэргээн босгох ажил явуулах зорилгоор тайван цагт буюу дайны үед зохион байгуулж явуулдаг нийтийн чанартай батлан хамгаалах арга хэмжээний систем мөн"<sup>7</sup> хэмээн Д.Гомбосүрэн нарын "Монгол Улсын иргэний хамгаалалт" гэсэн бүтээлд тодорхойлжээ.

Эндээс харахад, "Иргэний хамгаалалт" гэсэн ойлголтыг осол, байгалийн гамшиг, иргэний болон цэрэг зэвсэгт нөлөөлөх үед хүн ам, байгаль орчин, эд хөрөнгийг хамгаалахтай холбоотой бүхий л хүмүүнлэгийн үйл ажиллагааны нэгдсэн дүн гэж үзэж болохоор юм. Энэхүү үйл ажиллагааны агуулга нь энхийг сахиулах, дайтах үед онцгой байдлын иргэний хүчин, арга хэрэгсэл, арга замаар онцгой нөхцөлд амь нас, эд хөрөнгө, байгаль орчноо аврах явдал.

Дайн, зэвсэгт мөргөлдөөний үеэр иргэдийг хамгаалах нь хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн чухал ажил болж ирсэн. Судлаачдын тооцоолж буйгаар дэлхий дээр сүүлийн хагас мянган жилийн хугацаанд 15 мянга орчим

<sup>6</sup> Ш.Паламдорж нарын "Цэргийн нэр томьёоны тайлбар толь". УБ. 2014 он. х-701;

<sup>7</sup> Д.Гомбосүрэн нарын "Монгол Улсын иргэний хамгаалалт". УБ. 1999 он. х-276., т-24;



дайн гарч, түүний улмаас гурван тэрбум гаруй хүн амь үрэгджээ. Бүх түүхийн туршид хүн төрөлхтөн зэвсэгт мөргөлдөөнгүйгээр ердөө 292 жил амьдарсан гэсэн мэдээ байна.

Иргэний хамгаалалт нь зэвсэгт мөргөлдөөний ёс зүйд онцгой байр суурь эзэлдэг бөгөөд дайчлан хамгаалахад туслах, түүнчлэн онцгой байдлын үед энхийг сахиулах ажиллагаа хамаардаг. Түүнчлэн иргэний хамгаалалт нь улсын нийт хүн ам, төрийн эрх мэдэл, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуын батлан хамгаалах чадавх, амин чухал үйл ажиллагааг хангахад оролцох хэлбэр юм.

Өнгөрсөн зууны болон өнөөгийн эхэн үеийн эмгэнэлтэй статистик мэдээллээс харахад дэлхий даяар цэргийн ажиллагааны үр дүнд бий болсон онцгой байдлын тоо хэмжээ, цар хүрээ нь террорист ажиллагаа, технологийн осол, сүйрэл гэх мэтээр нэмэгдэж байгааг харуулж байна. Энэ нь хүний амь нас, материаллаг болон соёлын үнэт зүйлийг алдахыг аль болох багасгахад шаардлагатай арга хэмжээ авахыг шаардаж байна.

Өнөө үед “Иргэний хамгаалалт” гэдэг нь улс орноо батлан хамгаалахад бэлтгэх, хүн ам, материаллаг болон соёлын үнэт зүйлийг цэргийн ажиллагааны явцад үүссэн аюулаас хамгаалах арга хэмжээний систем болж байна.

Иргэний хамгаалалтын систем:

1. Хүн амын хамгаалалтыг хангах өдөр тутмын удирдлагын байгууллага;
2. Иргэний хамгаалалтын даалгаврыг биелүүлэхэд чиглэсэн хүч, хэрэгсэл;
3. Онцгой байдлын үед олгосон санхүү, эмнэлгийн болон материаллаг-техник хэрэгслийн нөөц;
4. Холбооны систем, сэрэмжлүүлэг, удирдлага, мэдээллийн дэмжлэгээс бүрдэнэ.

Иргэний хамгаалалтыг зохион байгуулах, явуулах нь төрийн чухал үүрэг, батлан хамгаалахын бүтцийн

бүрэлдэхүүн хэсэг бөгөөд улсын аюулгүй байдлыг хангах явдал болж байна.

Ер нь хүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн нэлээд үр дүнтэй хууль тогтоомж, зохицуулалтын тогтолцоотой байх нь чухал. Орчин үеийн хүч, хэрэгслийг бэлтгэх, ашиглах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх нь хүн амын хамгаалалтад ордог. Цацрагийн аюул, хими, биологийн хамгаалалтыг сайжруулахын тулд хувийн хамгаалалтын болон эмнэлгийн хамгаалалтын хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, цаг тухайд нь сэргээх явдал.

Эндээс харахад, иргэний хамгаалалтын хамгийн чухал ажил бол эдийн засгийн чухал байгууламжуудын үйл ажиллагааны тогтвортой байдлыг нэмэгдүүлэх явдал болж байна. Онц байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, онцгой нөхцөл байдлыг хөгжүүлэх, хүн амын дунд алдагдлыг бууруулах, эдийн засагт материаллаг хохирол учруулахааргүй сайн систем ажиллуулах шаардлагатай.

Химийн, биологийн болон бусад төрлийн зэвсэг хэрэглэх аюул нэмэгдэж байгаа өнөө үед иргэний хамгаалалтын удирдлага терроризмтой тэмцэх зорилгоор иргэний хамгаалалтын нөөцийг ашиглах, хяналтын сүлжээ, лабораторийн хяналтыг боловсронгуй болоход анхаарах хэрэгтэй.

Иргэний хамгаалалтыг үндсэн гурван үе шатанд нь ангилан авч үзье. Үүнд:

1. Сургалт: - хамгаалах байр, нөөцийг бий болгох, мэргэжилтэн, жирийн иргэдийг сургах, сэрэмжлүүлэх, харилцаа холбооны системийг бий болгох;
2. Хариу арга хэмжээ: - аюул заналхийлж буй тохиолдолд яаралтай сэрэмжлүүлэг, нүүлгэн шилжүүлэх, халдваргүйжүүлэх, эмнэлгийн тусламж үзүүлэх;
3. Нөхөн сэргээн босгох зэрэг болно.

Иргэний хамгаалалтыг зохион байгуулахад улс орнууд өөр өөр арга



хэрэглэдэг. Жишээлбэл, ОХУ-д иргэний хамгаалалтын нэгдсэн системийг цэргийн мөргөлдөөн, байгалийн гамшиг, эсвэл хүн төрөлхтний гамшгийн үед ашигладаг. Германд дайны болон гамшгийн үед гэсэн хоёр тусдаа систем үйлчилдэг. АНУ-ын хувьд эсрэгээрээ олон жилийн турш 2001 оны 9 дүгээр сарын 11-ний террорист халдлагын дараа үндэсний аюулгүй байдлын систем (эх орны аюулгүй байдал) болон гамшгийн үед хариу арга хэмжээ авах систем (онцгой байдлын менежмент) болгон хуваагдсан нэг тогтолцоотой болжээ.

Иргэний хамгаалалт гэдэг нь батлан хамгаалахад бэлтгэх, ОХУ-ын нутаг дэвсгэр дэх хүн ам, материаллаг болон соёлын үнэт зүйлийг хамгаалах эсвэл эдгээр үйл ажиллагааны үр дүнд үүсэх аюулаас, түүнчлэн байгалийн болон онцгой байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээний систем<sup>8</sup> болж байна. Тухайлбал, Чернобылийн атомын цахилгаан станцын дэлбэрэлт, Арменийн болсон газар хөдлөлтийн үр дагаврыг арилгах, Башкортостан дахь хийн хоолойд гарсан ослын үед, Арзамас дахь дэлбэрэлт болон бусад газарт Иргэний хамгаалалт, түүний хүчин, эд хөрөнгө идэвхтэй оролцож, аврах ажиллагаа явуулсан байдаг.

**Иргэний хамгаалалтын чиглэлээр гүйцэтгэх үндсэн ажил, арга хэмжээ<sup>9</sup>:**

1. Цэргийн ажиллагааны явцад буюу түүний улмаас үүсэх аюулаас хамгаалах арга замыг хүн амд сурган дадлагажуулах;

2. Дайсагналыг бий болгох эсвэл үйл ажиллагааны явцад гарч болзошгүй аюулын талаар олон нийтэд сэрэмжлүүлэх;

3. Хүн ам, материаллаг болон соёлын үнэт зүйлийг аюулгүй бүсэд нүүлгэн шилжүүлэх;

4. Хүн амыг хамгаалах байр, хувийн хамгаалалтын хэрэгслээр хангах;

5. Гэрлийн өнгөлөн далдлах болон

бусад төрлийн өнгөлөн далдлах үйл ажиллагаа явуулах;

6. Цэргийн ажиллагааны үеэр буюу эдгээр үйл ажиллагааны үр дүнд хүн амд аюул учрах, түүнчлэн байгалийн ба онцгой байдлын үед аврах ажиллагаа явуулах;

7. Цэргийн ажиллагааны үеэр эсвэл эдгээр үйл ажиллагааны үр дүнд нэрвэгдсэн хүн амд үзүүлэх тусламж;

8. Байлдааны ажиллагааны явцад болон түүнээс гарах үед үүссэн гал түймэртэй тэмцэх;

9. Цацраг, хими, биологийн болон бусад бохирдолд өртсөн газрыг илрүүлэх, тодорхойлох;

10. Дайны үед шаардлагатай хүч хэрэгслийн ажиллагааг яаралтай сэргээх;

11. Дайны үед цогцсыг яаралтай булшлах;

12. Иргэний хамгаалалтын хүч, хэрэгслийн байнгын бэлэн байдлыг хангахад чиглэгдэнэ.

Төрийг иргэний хамгаалалтад бэлтгэх нь энхийг сахиулах ажиллагааны үеэр зэвсэг, цэргийн техник хэрэгсэл, хүн амыг цэргийн ажиллагааны улмаас үүсэх аюулаас хамгаалах арга хэрэгслийг боловсруулж, харгалзан авч үздэг. Тухайлбал, ОХУ-ын нутаг дэвсгэр буюу түүний бие даасан нутаг дэвсгэрдэх иргэний хамгаалалт нь дайн зарласан, дайны ажиллагаа эхэлсэн эсвэл ОХУ-ын Ерөнхийлөгч ОХУ-ын нутаг дэвсгэрт буюу тусдаа нутаг дэвсгэрт байлдааны дэглэмийг нэвтрүүлсэн үеэс эхэлнэ. ОХУ-д иргэний хамгаалалтыг ОХУ-ын Засгийн газар удирддаг. Иргэний хамгаалалтын салбар дахь төрийн бодлогыг ОХУ-ын Ерөнхийлөгчийн Иргэний хамгаалалтын салбарт тулгарч буй асуудлыг шийдвэрлэх эрх бүхий холбооны гүйцэтгэх байгууллага - Иргэний хамгаалалт, онцгой байдал, гамшгийн менежментийн яам (ОХУ-ын ЭМЕРКОМ) ажиллаж байна.

Иргэний батлан хамгаалах хүчин - Иргэний хамгаалалтын салбарт

<sup>8</sup> "Иргэний хамгаалалтын тухай" Холбооны хууль. 1998 он. д. 28-ФЗ;

<sup>9</sup> <https://skoreacar.ru/mn/nedvizhimost/zadachi-grazhdanskoi-oborony-i-celi-osnovnye-zadachi-grazhdanskoi-oborony/>



тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор тусгайлан зохион байгуулагдсан цэргийн анги, иргэний хамгаалалтын хүч, түүнчлэн онцгой байдлын аврах анги, аврах алба ордог.

Иргэний хамгаалалтын хүчний үндсэн ажил:

- хүн ам, материаллаг болон соёлын үнэт зүйлийг аюулгүй бүсэд нүүлгэн шилжүүлэх;
- дайтах ажиллагаа, эсвэл эдгээр үйл ажиллагааны үр дүнд хүн амд аюул учирсан тохиолдолд онцгой байдлын аврах ажиллагаа явуулах;
- байлдааны ажиллагааны явцад болон түүнээс гарах үед гарсан гал түймэртэй тэмцэх;
- цацраг, хими, биологийн болон бусад бохирдолд өртсөн газрыг илрүүлэх, тодорхойлох;
- хүн ам, тоног төхөөрөмж, барилга байгууламж, нутаг дэвсгэрийг халдваргүйжүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авах;
- цэргийн ажиллагаа, эдгээр үйл ажиллагааны үр дүнд өртсөн хэсэгт дэглэмийг сэргээх, засвар үйлчилгээ хийх гэх мэт.

Орчинд үед иргэний хамгаалалтын зорилго нь хүн амыг хамгаалах, нийгмийн шаардлагатай үйлчилгээг тасралтгүй авах нөхцөл боломжийг бүрдүүлэх, зэвсэгт мөргөлдөөнөөс учрах хохирлыг бууруулах, Зэвсэгт хүчний операцын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байна.

Иргэний хамгаалалт нь нийт иргэдэд цэрэг, эх оронч үзэл, ёс суртахуун-сэтгэл зүйн хатуужил төлөвшүүлэхийн зэрэгцээ хүн нэг бүрийн хувийн бэлтгэл (ус, хүнс, эм тариа, эрчим хүчний эх үүсгэвэр, г.м)-ийг сайтар хангуулахад тэдний оролцоо чадавхыг нэмэгдүүлж, улсыг батлан хамгаалахад шаардагдах хангалт, үйлчилгээ, тээвэр зохицуулалтад ирэх ачаалал, дарамтын эрсдэлийг багасгадаг байна.

Дайны байдлын хямралт үед төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг тухайн үед байгуулагдах

иргэний хамгаалалтын байгууллага, нэгжид дэмжих үүрэг гүйцэтгүүлэхээр татан оролцуулж болно.

Энэ тохиолдолд нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны, түүнчлэн аймаг, бүсийн олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг хүч нэмэгдүүлэн авран туслах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх байр, орон сууц болгон өөрчлөн зохион байгуулж, зарим чухал объектыг хамгаалалтын, түүнчлэн нийтийн хоргодох байр болгох, нүүлгэн шилжүүлэх чадавх бүхий бүлэг байгуулах аргаар өөрчлөн зохион байгуулж болдог байна.

Тайван цагт дээрх томилгоот байгууллага, иргэдийг хамгаалалтын чиглэлийн гүйцэтгэх үүрэгтэй нь уялдуулан сургаж, бэлтгэлийг хангуулах шаардлагатай. Түүнчлэн орон нутгийн цэрэг, батлан хамгаалах чиглэлийн туслах хүчин, сайн дурын байгууллага бүх нийтийн хориглон хамгаалах тогтолцоонд иргэний хамгаалалтын чухал үүргийг гүйцэтгэдэг. Энэхүү байгууллага, бүлэг эгнээндээ олон хүнийг нэгтгэдэг учир эх орноо батлан хамгаалах хүсэл, зориг, тэмүүллийг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой.

**Иргэний хамгаалалтын арга хэмжээг үндэсний даван туулах чадвартай уялдуулах үндсэн ажил, арга хэмжээнд:**

1. Дайн, зэвсэгт түрэмгийллийн үед хүн амыг олноор хөнөөх зэвсэг, арга хэрэгслээс хамгаалах (дэлбэрэлт, хүчтэй хорт бодисын ялгаруулалт, тахал өвчин гэх мэт) болон авран туслах ажиллагааг явуулах зэрэг цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2. Зэвсэгт мөргөлдөөнөөс учрах хор, хохирлоос урьдчилан сэргийлэх, арилгах чиглэлээр удирдлагын байгууллагын үйл ажиллагааг уялдуулах;

3. Эдийн засгийн байгууламж, үйлдвэрлэлийн тогтвортой байдал, тэдгээрийн хямралт байдлын үед үйл ажиллагааны хамгаалалтыг нэмэгдүүлэх;

4. Авран хамгаалах болон бусдад яаралтай тусламж үзүүлэх байгууллага,



нэгж, бүлгийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх;

5. Удирдах бие бүрэлдэхүүнд хамгаалалтын хүчний тусгай сургалт, дайн, зэвсэгт мөргөлдөөний үед хамгаалах арга хэмжээнд хүн амыг бүх нийтийн сургалтад хамруулж, дадлагажуулах;

6. Хүн амыг хамгаалах байрны хамгаалалтын байгууламжийн сан хуримтлуулах;

7. Хүн амыг хувийн хамгаалалтын хэрэгслээр хангах, хамгаалах хамгийн энгийн хэрэгслийг өөрсдөө үйлдвэрлэх чадамжид ажлыг зохион байгуулах;

8. Том хот, суурин болон зэргэлдээ суурин газруудаас хүн амыг нүүлгэн шилжүүлэх, аюулгүй бүсэд байрлуулах чадавх бүхий нэгж, бүлгийг сургаж дадлагажуулах;

9. Улс орон даяар хүн амыг хамгаалах хоргодох байр болон иргэний хамгаалалтын байгууламжийн ажил, арга хэмжээг эртнээс төлөвлөх, хэрэгжүүлэх;

10. Хүн амд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх байр, орон сууц болгон өөрчлөн зохион байгуулах, хоол хүнс, усан хангамж, усны хэрэглээний байгууламжийн төлөвлөлт, зарим чухал объектын хамгаалалтын төлөвлөгөөг тайван цагт боловсруулж туршилт судалгаа явуулж, хэрэгжилтийг хангах;

11. Эдийн засгийн, байгалийн болон бусад шинж чанар, нутаг дэвсгэрийн

онцлог шинж, онцгой байдлын бодит аюулын зэргийг харгалзан хүн амын ялгаатай хамгаалалтыг зохион байгуулах;

12. Хүн амыг хамгаалах арга хэмжээний цар хүрээ, агуулгыг тодорхойлоход шаардлагатай хүрэлцээ, хүч, хэрэгслийг хамгийн үр дүнтэй ашиглах зэрэг болно.

Эндээс дараах дүгнэлтийг хийж байна:

- Аюул байгаа цагт хамгаалалт зайлшгүй тул иргэний хамгаалалтын чиглэлийн үндсэн асуудлыг үндэсний даван туулах чадвартай уялдуулсан эрх зүйн орчин бий болгох;
- Иргэний хамгаалалтын үйл ажиллагааг санхүүжүүлэх, хэрэгжүүлэхэд тэргүүлэх чиглэлийг төрөөс тодорхойлох;
- Эрх бүхий байгууллагууд бие даасан бүрэлдэхүүн, иргэний хамгаалалтын байгууллагууд болон улсын энгийн хүн амьд аюулгүй байдлын үндсийг системтэй сургахад онцгой анхаарал хандуулах;
- Удирдах байгууллагууд, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, эдийн засгийн бусад салбарууд онцгой үеийн төлөвлөгөөний дагуу даван тэсвэрлэх ажиллагаанд хурдан шилжихэд бэлэн байх, тэсвэр тэвчээрийг бэхжүүлэх цогц арга хэмжээ авах зэрэг болно.

### Ашигласан материал:

1. Батлан хамгаалах стратеги. УБ., 2017 он.
2. Монгол Улсын Үндсэн хууль.
3. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.
4. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс.
5. Хүч тэнцвэргүй дайн, байлдаан. УБ., 2018 он.
6. Ш.Паламдорж нарын "Цэргийн нэр томъёоны тайлбар толь". УБ. 2014 он.
7. Д.Гомбосүрэн нарын "Монгол Улсын иргэний хамгаалалт". УБ. 1999 он.
8. "Иргэний хамгаалалтын тухай" ОХУ-ын Холбооны хууль. 1998 он.
9. <https://skoreacar.ru/mn/nedvizhimost/zadachi-grazhdanskoi-oborony-i-celi-osnovnye-zadachi-grazhdanskoi-oborony/>.



## ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨНИЙ ТУХАЙД

**Х.ОРХОНЧИМЭГ** /БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний төвийн ажилтан, доктор (Ph.D), дэд профессор/

**С.БАЙГАЛМАА** /ҮБХИС-ийн Нийгэм Хүмүүнлэгийн тэнхимийн багш, докторант/

**Түлхүүр үг:** Нийгэм, үнэт зүйл, үндэсний аюулгүй байдал, элемент

**Key words:** Society, values, national security, elements

Үндэсний үнэт зүйл нь үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд оюун санааны дархлааны үүрэг гүйцэтгэж байх учир түүнийг зөв тодорхойлж, олон нийт, ялангуяа хүүхэд залуучуудыг чиг баримжаагаа олох арга замд нь чиглүүлэг болох чухал шаардлага тулгарч байна. Иймд энэхүү өгүүлэлд үндэсний үнэт зүйлсийн үндэсний аюулгүй байдалд үзүүлэх нөлөөний тухайд тодруулахыг зорилоо.

Хүн амьдралдаа чиг баримтлал болгодог үнэт зүйлгүй бол нийгэм хэмээх томоохон системийг нийтлэг зорилгоор удирдан чиглүүлэх боломжгүй болж, нэгдсэн дэг журам ч үгүй, хүн бүр дур зоргоороо авирласан эмх цэгцгүй байдал үүсэх билээ<sup>1</sup>.

Үнэт зүйл хэмээхийг философи, социологи, антропологи, психологи, аксиологи, соёл судлал, ёс зүй зэрэг нийгэм, хүмүүнлэгийн ухаанууд өөр өөрийн судлах зүйлийн онцлогтой холбоотойгоор авч үзсэн байдаг. Тухайлбал, сонгодог философи болон үнэт зүйлийг судалдаг шинжлэх ухаан буюу аксиологийн онолд субъектээс объектод хандсан харилцаа, түүнээс үүдэж үүссэн хэм хэмжээт үйлийн цогцыг үнэт зүйл гэж үздэг. Энэ нь хүмүүний мэдрэмж, хэрэгцээнд тулгуурласан амьдралыг чиглүүлэх, идэвхжүүлэх, утга төгөлдөр болгож хөтлөх хүч мөн бөгөөд энэ нь үнэт зүйл юм<sup>2</sup>. Социологийн шинжлэх ухаанд

үнэт зүйл гэдэг бол

1. Нийгмийн субъект (хувь хүн, нийгмийн бүлэг, нийгэм бүхэлдээ)-д төлөвшиж тогтсон эрхэмлэн хүндэтгэдэг үзэл бодол, итгэл үнэмшлийн цогц,

2. Бодит үйл явдлыг үнэлж цэгнэх шалгуур

3. Хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааны утга учрыг тодорхойлох хүчин зүйл

4. Нийгмийн харилцан үйлчлэлийн зохицуулагч<sup>3</sup>, ёс зүйд хэвшүүлэх хэм хэмжээ, мөрдөх учиртай нийтлэг жишиг гэж үзэх, сэтгэл зүйд хүмүүсийн итгэл үнэмшил, мотивацийн зорилго, эрмэлзэл гэж үзэх, соёл судлалд соёлуудын хэв шинжийг тодорхойлогч хүчин зүйлсийн нэг гэж үзэх хандлага давамгайлж байдаг<sup>4</sup>.

Нэр томъёоны тухайд, судлаачид англи хэлний "value", орос хэлний "ценность" хэмээх үгсийг үнэт зүйл хэмээн орчуулсан нь төдийлөн оновчтой бус, харин үнэлэмж гэвэл утгыг илүү илэрхийлнэ хэмээгээд, үнэлэмж нь сайн муу, сайхан муухай, үнэн худал гэх мэт хоёр туйл руу тэмүүлж эерэг сөрөг аль аль талыг агуулдаг бол үнэт зүйл нь зөвхөн сайн, сайхан, зөв зүйтэй гэсэн эерэг үнэлэмж шингэсэн байдаг хэмээн их төлөв санал нэгджээ.

1990-ээд оноос хойших нийгмийн амьдралын өөрчлөлтийг даган бидний үнэт зүйл, үнэлэмж янз бүрийн сэдэв

<sup>1</sup> Монголчуудын үнэт зүйлсийг Шварцийн аргачлалаар тодорхойлсон нь. Удирдлагын академи. УБ., 2017.т.12

<sup>2</sup> Монголын соёл урлаг судлал. УБ., 2019.т.33

<sup>3</sup> "Монголчуудын үнэт зүйл" судалгааны тайлан. СУИС. УБ., 2019.т.13

<sup>4</sup> Монголчуудын үнэт зүйлсийг Шварцийн аргачлалаар тодорхойлсон нь. Удирдлагын академи. УБ., 2017.т.11



бүхий социологийн судалгаануудад тодорхой хэмжээгээр туссаар ирсэн. Тухайлбал, ШУА-ийн ФСЭХ-ээс 1999 онд хийсэн нэгэн судалгаанд “Дараах зүйлсийн аль нэгийг тохиолдлоор юм уу эсвэл аз таарч авах бол алийг нь Та сонгох вэ?” гэсэн асуултад их хэмжээний мөнгө (25.0%), ажил мэргэжил (19.9%), тохилог орон сууц (15.0%), ид шид (9.9%), гадаад хэл (9.6%), автомашин (5.4%), эрх мэдэл, албан тушаал (3.8%), бусад (1.4%) гэж хариулжээ. Энэ судалгааны тайланд судлаачид хүмүүсийн үнэт зүйлсийн тоонд материаллаг зүйл голлох байр суурьтай, амьдралын түвшин доогуур байгаа ч үнэт зүйлийн өөрчлөлтийн хурд удаан хоёрдмол шинжтэйн дээр уламжлалт үнэт зүйлсийн тогтолцоо зонхилсон хэвээр буй”<sup>5</sup> гэжээ.

2013 онд Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод Монголчуудын эрхэмлэн дээдлэх зүйлсийг дор дурдсанаар заажээ: Монгол Улсын Үндсэн хуулийг баримтлах; шударга амьдарч ажиллах, нийгмээ эвсэг, найрсаг байлгах; бие хүн, нийгмийн хөгжил дэвшлийг өөрсдийн гараар бусадтай хамтран бүтээн байгуулах; эх оронч үзэл нь улс орноо хөгжүүлснээр тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хамгаалан бэхжүүлэх зарчим дээр тогтох зэрэг болно”<sup>6</sup> гэжээ.

2015 онд СЭЗДС-ийн багш судлаачид “Монголчуудын үндэсний үнэт зүйлийн судалгаа” хийсэн бөгөөд Value survey module 2013 Hofstede аргачлалаар Монголчуудын үнэт зүйлийг 6 хэмжүүрээр тооцож гаргахад гэр бүлийн хүрээнд хамтач боловч ажлын орчинд илүү бодгальч шинжтэй, урт хугацааны хандлага бага, тодорхойгүй зүйлээс зугтах түвшин бага, эрх мэдлийн ялгаа заагийг хүлээн зөвшөөрөх хандлага ялимгүй өндөр, баригдмалаас илүү

чөлөөт нь давамгайлсан болохыг тодорхойлжээ<sup>7</sup>.

2017 онд Удирдлагын академийн багш судлаачид “Монголчуудын үнэт зүйлсийг Шварцийн аргачлалаар тодорхойлох нь” сэдэвт ажил хийсэн бөгөөд тэд 56 үнэт зүйлийг 10 бүлэгт нэгтгэсэн Шварцийн аргачлалыг ашиглажээ. Судалгааны үр дүнд монголчуудын үнэт зүйл дараах байдлаар эрэмбэлэгджээ. Үүнд: “Бусдад санаа тавих” /%31,6/. Өөрөөр хэлбэл, монгол хүний шударга зан, чин үнэнч нөхөрлөл, үнэнч байдал, хариуцлагатай байдал, хайр халамж, уучлах сэтгэл, тусч байдал, оюун санаа, уужуу ухааныг дийлэнхээрээ эрхэмлэн үздэг байна. Дараагийнх нь “Эрх мэдэл-амжилт” /%7,6/. Нийгмийн байр суурь, удирдах эрх мэдэл, эд баялаг нөлөөтэй байх, нийгэмд танигдсан байдал, амжилттай байдал, нэр хүндээ хамгаалах, ухаалаг байдал, чадвар чадавх зэргийг эрхэмлэдэг байна. Гуравдугаарт “Аюулгүй байх” /%6,43/. Эрүүл мэнд, нийгмийн дэг журам, гэр бүлийн амар жимэр байдал, холбоо хамаарлаа мэдэх, харилцаа холбоо, үндэсний аюулгүй байдал, цэвэрч нямбай байдал, универсализм-нийгмийн шударга ёс, энх тайван, байгаль орчноо хамгаалах, эрх тэгш байдлыг”<sup>8</sup> эрхэмлэсэн байна.

2018 онд мөн Удирдлагын академийн багш судлаачид Засгийн газрын хэрэг эрхлэх газар, төрийн албаны зөвлөлийн захиалгаар “Төрийн албаны үнэт зүйл”-ийн судалгаа хийсэн байна.

2019 онд СУИС-ийн багш судлаачид “Монголчуудын үнэт зүйл” хэмээх үнэт зүйлсийн үндэсний өв, соёл, уламжлалын талыг нь онцолсон томоохон судалгааны ажил гүйцэтгэсэн. “Таны эрхэмлэн дээдэлдэг зүйл юу вэ?” гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 25,3 хувь нь

<sup>5</sup> Нийгмийн шинэчлэл: амьдралын хэв маягийн өөрчлөлт. ШУА-ийн ФСЭХ. УБ., 2001.т. 111

<sup>6</sup> “Монголчуудын үнэт зүйл” судалгааны тайлан. СУИС. УБ., 2019.т.14

<sup>7</sup> “Монголчуудын үндэсний үнэт зүйл” судалгааны тайлан. СЭЗДС. УБ., 2015.т.2

<sup>8</sup> Монголчуудын үнэт зүйлсийг Шварцийн аргачлалаар тодорхойлсон нь. Удирдлагын академи. УБ., 2017.т.42

эрүүл мэнд, 22,8 хувь нь гэр бүл, үр хүүхэд, 12,8 хувь нь мэдлэг боловсрол, 9,2 хувь нь эх орон гэж хариулжээ. Энэ нь хувь хүний үнэт зүйлийг тодруулсан байх бөгөөд нийгмийн үнэт зүйл хувь хүний үнэт зүйлтэй хамааралтай зүй тогтлоор, мөн хүсүүштэй чухалд тооцууштай юмаа гэж үзэж байгаа үүднээс авч үзвэл эрүүл мэнд, боловсрол, гэр бүлийн асуудал өнөөдөр манай нийгэмд анхаарал татаж байгаагийн нотолгоо байж болох талтай. Мөн "Та юунд их санаа зовдог вэ?" гэсэн асуултад байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт /14,4 хувь/, үндэсний аюулгүй байдал /13,2 хувь/, ядуурал /12,8 хувь/, ажилгүйдэл /11,9 хувь/, авилга /10,4 хувь/, ёс суртахууны доройтол /10,1 хувь/ хэмээн, "Та эх орныхоо ирээдүйд итгэлтэй байна уу?" гэхэд тийм ч итгэлтэй биш /47,2 хувь/, итгэлгүй байна /%15,8/ хэмээн хариулжээ. Энэ бүхэн биднийг нэгтгэх, итгэлтэй амьдрах үнэт зүйлгүй, зүйрлэвэл далайд сэлүүргүй яваа мэт байдлыг илтгэж байгаа харамсмаар дүр зураг ажээ.

Дээрх үнэт зүйлсийн талаарх судалгаанууд нь монголчуудын үнэт зүйлсийг тал бүрээс нь тодорхойлж буй оролдлогууд бөгөөд энэ бүхнийг судлах шалтгаан нь бид 1990 оноос нийгмийн өөр тогтолцоонд шилжсэнээр өмнөх нийгмийн үнэт зүйлийн баримжаалал үгүй болж ардчилал, зах зээлийн тогтолцоонд нийцэхүйц үнэт зүйлийг үндэсний хэмжээнд хангалттай түвшинд хараахан төлөвшүүлж чадаагүй, (Манай улсад ардчиллын үнэт зүйл хэр зэрэг төлөвшиж байна? гэхэд хариуцлага хүлээх байдал, шударга үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилт, тайлагнах ёс, иргэдийн оролцоо зэрэг ардчиллын үнэт зүйлүүдийг судалгаанд оролцсон 10 хүн тутмын 6-4 нь хангалтгүй гэж үнэлсэн<sup>9</sup> өөрийн гэх үнэт зүйл тодорхойгүй байгаад оршино. Учир нь аливаа нийгэмд нийтээр хүлээн зөвшөөрсөн, дагаж

мөрдвөл зохих нийгмийн зан үйлийн хэм хэмжээ, үнэт зүйлийн чиг баримжааг нийгмийн гишүүдэд эзэмшүүлэхгүйгээр ямар ч нийгмийн систем тогтвортой, хэвийн хөгжиж чадахгүй гэж нийгэм судлаачид үздэг. Нөгөө талаас хүн нийгэмд үйлчилж байгаа эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээ, нийтээр хүлээн зөвшөөрч дагадаг үнэт зүйл, эрхэмнэлийг амьдрал, үйл ажиллагаандаа баримтлахгүйгээр нийгмийн нарийн төвөгтэй харилцаанд орж чадахгүй.

Орчин үеийн нийгмийн хөгжлийн олон талт өөрчлөлтүүд нь биднийг тааварлахын аргагүй шинэ нөхцөл байдалд оруулж, улмаар үнэт зүйлсийн чиг баримжааг өөрчилж байгааг зүй ёсны үйл явц гэж үзэж болох юм. Учир нь үнэт зүйлийн тогтолцоо өөрөө тогтвортойн зэрэгцээ хөдөлгөөнт шинжтэй. "Түүхэн тодорхой цаг хугацаанаас хамаарч, бас тухайн тив дэлхий, байгаль газарзүйн орчин, нийгэм, үндэстэн, угсаатны бүлгийн өөрсдийнх нь үнэлэмжээс хамаарч үнэт зүйлийн тогтолцоо харьцангуй шинжтэй бүрдсэн байдаг"<sup>10</sup>.

Нийгмийн давхраажилтын янз бүрийн шалгуураар бий болсон социаль бүлэг давхраанууд, тэдний олон зүйл ашиг сонирхол, олон ургалч үзэл зэрэг нь үнэт зүйлсийн хандлага, чиг баримжааг өөрчилж, энэ талаар тодорхойлоход төвөгтэй болгож байгаа хэдий ч нийгэм, нийгмийн төрөл бүрийн бүлгүүдэд нийтээрээ бий болгосон, нийтээрээ хүлээн зөвшөөрдөг, нийтээрээ бахархдаг, нийтээрээ амьдрал, үйл ажиллагааны чиг баримжааг болгодог, дагаж мөрддөг, эрхэмлэн дээдэлдэг үнэт зүйл байна.

Үнэт зүйлс гэдэг ойлголтыг бид үнэлэгч субъектийн хувьд объектын (үнэлүүлж буй юмс үзэгдэл гэсэн утгаар нь) нийгмийн, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн ач холбогдол гэсэн утгаар нь тааруулж хэрэглэж буй билээ. Өөрөөр хэлбэл үнэт зүйлс хэмээх

<sup>9</sup> "Монголчуудын үнэт зүйл" судалгааны тайлан. СУИС. УБ., 2019.т.95

<sup>10</sup> Круглова.Л.К. Культурология. Санкт-Петербург. 2008. стр. 77-78



философийн болон соёлын ойлголт нь үнэ цэнтэй биет тодорхой юмсыг бус харин абстракт (хийсвэрлэсэн) сэтгэлгээний үүднээс тухайн юмс, үзэгдэл (жишээ нь түүх, бахархал, эх оронч үзэл хүмүүжил гэх мэт)-ийн үнэт чанар, ач холбогдлыг илэрхийлж буй юм<sup>11</sup>.

Аливаа үндэстний үнэт зүйл нийгмийн хөгжлийн түүхэн урт удаан хугацааны туршид тухайн улс үндэстний онцлог, туулж өнгөрүүлсэн түүх, ой санамж, оршин амьдарч буй газар нутаг, байгаль цаг агаарын нөхцөл зэрэгт тулгуурлан үүсэх аж. Иймд үндэстний үнэт зүйлс нь тухайн үндэстний санаа бодол, итгэл үнэмшил, үйлдэл, хүсэл, зорилго, тэмүүллийн илэрхийлэл байдаг учраас тэдний хөгжил дэвшилд болон ирээдүйг бүтээхэд нь тусалдаг.

Өнөөдөр гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн бидний нийгмийн харилцаа, үнэт зүйлс ихээхэн өөрчлөгдөж баян ядуу, хот хөдөө, цаашлаад улс төрийн үзэл бодол, нийгмийн гарал байдал, шашин шүтлэг зэргээрээ ялгаа зааг гаргах болжээ. Энэ нь яваандаа үнэт зүйлсийг бүдгэрүүлж, нийгмийн оюун санаа, эв нэгдэлд эрсдэл үүсгэж болзошгүй юм.

Үндэсний үнэт зүйл нь үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд, хүүхэд залуучуудыг чиг баримжаагаа олоход чухал хөшүүрэг болох юм.

Өнөөдөр хөгжингүй орнуудад бүх түвшиндээ төрийн аливаа шийдвэр нийгэмд авч ирэх үр дагавар, ялангуяа нийгэмд бий болгож, төлөвшүүлж байгаа эсвэл төлөвшүүлэхийг зорьж байгаа нийтийн үнэт зүйлд төвлөрөх ёстой гэж үзэж, үнэт зүйлээр удирдах тухай ярьдаг болжээ. Нийтлэг үнэт зүйлээр үндэстнээ удирдаж хөгжлийн өндөр түвшинд хүрч чадсан Сингапур

зэрэг олон орнууд бий<sup>12</sup>.

Аливаа улс орон өөрсдийн “нэн тэргүүний эрх ашгийг хэрхэн хараалснаас ихээхэн хамааралтайгаар үндэсний үнэт зүйл нь тодорхой болж”<sup>13</sup>, үүнийгээ нийтээр хүлээн зөвшөөрч эрхэмлэснээр үндэстэн, угсаатны хэв шинж, төлөвшлийг буй болгодог байна. Тухайлбал, америкчууд “хувь хүнийг”, япончууд “бүлэг багийг”, Шведүүд “нийгмийг” тус тус эрх ашгийн нэгдүгээрт оруулж чухалчилдаг. Үүний үр дүнд америк хүнд өөрийгөө илэрхийлэх ур чадвар, би-гийн хандлага их, япон хүнд баг, хамт олны шийдвэр, нийтийн хөдөлмөр, зарчим хүчтэй<sup>14</sup> Швед хүнд байгальд ээлтэй, нийгмийн тэгш хүртээмжтэй үйлчилгээ амьдралын баталгаа болж хоорондын харилцаа хамаарал, би-гийн хандлага давамгайлахгүй, нийтийн хэв шинж илүү төлөвшдөг байна. Ингэж үндэсний тэргүүн эрх ашигт нийцсэн үнэт зүйл ард иргэдийн сэтгэл ханамж, аз жаргалыг бий болгодог. Үнэт зүйл нь хүний зан төлөв, хандлагыг тодорхойлох, тайлбарлахад чухал ойлголт, хүний амьдрал, түүхийн холбоо хамааралд чухал үүрэгтэй ба хүнд эхлээд гэр бүлээс дараа нь цэцэрлэг, сургуулиас нь төлөвшдөг байна<sup>15</sup>.

Үнэт зүйлийг ойлгуулах, төлөвшүүлэхэд нийгэмшлийн агентууд гэр бүл, сургууль, байгууллага хамт олон зэрэг, ялангуяа гэр бүлийн үзүүлэх нөлөө хамгийн их байдаг. Учир нь гэр бүлд олж авсан суурь хүмүүжил төлөвшил нийгмийн харилцааны уг үндэс болдог.

Үндэсний үнэт зүйл ба үндэсний аюулгүй байдал бол нарийн уялдаа холбоотой асуудал юм. Улс орон, үндэсний үнэт зүйлээ тодорхойлсноор, түүндээ тулгуурласан нийгмээ

<sup>11</sup> Н.Жалбажав. Ч.Сосорбарам. Үндэсний үнэт зүйл, ой санамжийг сэргээх нь эх оронч үндэсний үзлийг дээдлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны үндсэн зарчим. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хүн амын оюун дархлааны асуудал сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2020. т.45

<sup>12</sup> Мөн тэнд т.46

<sup>13</sup> Сүрэнчимэг Д. Байгууллагын соёл ба үнэт зүйл. Монголчуудын үнэт зүйл цуврал лекц. СУИС. 2018.05.18.

<sup>14</sup> Нобелийн шагналтнуудын айлдвар. Ред. Гомбосүрэн Ц. УБ., 2010.т.346

<sup>15</sup> "Монголчуудын үндэсний үнэт зүйл" судалгааны тайлан. УБ., 2015.т.29

нэгдэн нягтруулах аливаа бодлого, шийдвэр гаргаснаар үр дүнгээ өгч, цаашлаад энэ нь улс орон хөгжлийн зөв замаа сонгоход баримжаа болдог. Хүн төрөлхтөний түүхэнд янз бүрийн хүчин зүйлүүдээс шалтгаалж, үндэсний ухамсар, сэтгэхүй, үнэт зүйлс өөрчлөгдөж, үндэстэн нэгдмэл байх нөхцөл сарниж, улмаар үндэсний аюулгүй байдал алдагдан бусдын эрхшээлд орж, улс үндсээрээ устсан гашуун түүх олон бий. Үндэсний үнэт зүйл нь нэг төрлийн "хамгаалах" үүргийг гүйцэтгэж, улс үндэстний оюуны дархлаа болдог.

Түүхэн ой санамж бүдгэрснээс ард түмэн нэгдэн нягтрах үйл явц саармагжиж, үүнээс үүдэн нийгмийн ёс суртахуун, үнэт зүйлсийн чиг баримжаа өөрчлөгдөж, үндэсний аюулгүй байдлыг сулруулахад хүргэдэг<sup>16</sup>. Иймд үндэсний онцлогийг илэрхийлсэн үнэт зүйлийг тодорхойлж, бэхжүүлэх нь төрийн үүрэг юм. Энэ талаар төрийн бодлого, үйл ажиллагаанд хэрхэн туссаныг тодруулж үзье.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ"<sup>17</sup> гэжээ.

Үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах дотоод таатай нөхцөл бүрдсэн байх нь соёл иргэншлийн шинж чанартай нягт уялдаатай байдаг. Тиймээс ч "... монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн" гэж Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заажээ. Учир нь Монгол Улсын Үндсэн Хуулийн 7.1-д "Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна" гэж тунхагласан юм. Монгол

улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.6-д "Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн" гэсэн байдаг. Мөн 1.2.1-д "Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх, эх оронч, үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно." гэж заасан байдаг.

"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод монголын үндэсний үнэт зүйлсийг "Хүн ёс, хүн чанар, хууль ёс, мэдлэг боловсрол, ёс суртахуун, тэгш байдал, шударга ёс, эрх чөлөө, эв эе, эрдэм, эв дүй, иргэдийн оролцоо, нийтэд ил тод байх, эрхэмлэх шүтээн, бишрэл, итгэл үнэмшил, эрүүл мэнд, хариуцлагатай байдал, бүтээлч чанар, өөртөө итгэлтэй байдал зэрэг хувь хүний болон нийгмийн үнэт зүйлсийг олноор дурдаж болох боловч тусгаар тогтнол бүхий эх орон, газар нутаг, тэнд оршин суугч монгол хүн, үндэстний дахин давтагдашгүй шинж чанарыг хадгалах нүүдлийн ахуй, түүнээс урган гарсан түүх, соёлын дурсгал, урлагийн бүтээл, орчин үетэй хөл нийлүүлэн хөгжих уламжлал, шинэчлэлийн төгс зохицолгүйгээр дээрх бүгд ухвар мөчид болох юм. нөгөөтээгүүр хувь хүний болон нийгмийн түвшний үнэт зүйлс нь үндэсний онцлогтой нягт уялдаж, эх орны эрх ашиг, монгол хүний онцлог, нүүдлийн ахуй, түүх, соёл, урлагийн бүтээлдээ уламжлал, шинэчлэлийн тэнцвэрт харьцаанд шингэн сүлэлдэж үндэсний ижилсэл-ийг бүтээх учиртай" гэж тодорхойлжээ<sup>18</sup>.

Сүүлийн жилүүдэд бидний,

<sup>16</sup> Х.Орхончимэг. Үндэсний ой санамж ба батлан хамгаалах боловсрол. Үндэсний ой санамжийг сэргээн тодорхойлох нь сэдэвт эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийн эмхэтгэл. УБ., 2021. т.46

<sup>17</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010.

<sup>18</sup> Алсын хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал. УБ., 2019 он. т.90



ялангуяа өсвөр залуу үеийнхний эх оронч үзэл, эх орноороо бахархах бахархал ихээхэн өөрчлөгдсөн нь даяаршил, мэдээллийн хөгжил, техник, технологийн дэвшлийн хурдац хүн төрөлхтний ахуй амьдрал, нийгмийн харилцаанд эерэг, сөрөг ихээхэн нөлөө үзүүлснээс болжээ. Эдүгээ бид ардчилал, зах зээлийн тогтолцоонд нийцэхүйц үнэт зүйлийг үндэсний хэмжээнд хангалттай түвшинд төлөвшүүлж чадаагүй байна, өөрийн гэх үнэт зүйл тодорхойгүй байна. Үүний шалтгааныг судлаачид


1. Соёлын хэт хожимдол өөрөөр хэлбэл хөгжил дэвшлийг хангахдаа материаллаг болон материаллаг бус соёлыг аль алиныг төлөвшүүлэх хэрэгтэй байдаг. Гэтэл бодит байдал дээр материаллаг тал түрүүлж өөрчлөгдөж, материаллаг бус зүйлс хоцорч үлддэг. Үүнийг соёлын чиглэлээр судалгаа хийдэг судлаачид соёлын хожимдол (cultural lag) хэмээн тодорхойлдог байна.
2. Соёлын түрэмгийлэл (cultural imperialism),
3. Бие хүний үнэт зүйлийн тодорхойгүй байдал<sup>18</sup> хэмээн үзжээ.

Улс үндэстэн үнэт зүйлээ тодорхойлон, хадгалан үлдэж чадсан цагт л урт удаан хугацаанд оршин тогтнох боломжтой тул үндэсний үнэт зүйлс, оюун санааны дархлаагаа хамгаалах нь чухал ач холбогдолтой юм.

Үндэсний үнэт зүйл нь үндэсний ой санамж дээр тулгуурлаж, үндэсний өвөрмөц байдлыг илэрхийлж, түүнийг тээж, мөн төрийн үйл ажиллагааны чиг баримжаа болдог. Иймд Үндэсний үнэт зүйлс нь доорх 3 холбоо бүхий зүй тогтлоор эргэх холбоонд ордог байна. (1 дүгээр зураг)



Үндэсний үнэт зүйлс нь төрийн бодлого, үндэсний өвөрмөц шинж, нийгмийн тогтвортой байдал, үндэсний ой санамж гэсэн дөрвөн хэлбэрийн агуулгын бүрдүүлэгч элементийн хэсэг болж үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд нөлөө үзүүлдэг. (2 дугаар зураг).



Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд үндэсний үнэт зүйлс нь дээр дурдсан дөрвөн хэлбэрийн агуулгыг бүрдүүлэгч чухал элемент болох тул эдгээрийн хамаарлыг чухалчлан авч үзэх шаардлагатай юм. Аюулгүй байдлын онолын үүднээс төрийн бодлого, үндэсний өвөрмөц шинж, нийгмийн тогтвортой байдал, үндэсний ой санамжийн агуулгыг бүрдүүлэгч чухал элемент учраас үндэсний үнэт зүйл нь үндсэндээ улс орнуудын оршин тогтнох үндэс болно гэсэн үг.

Эдгээрийг эцэст нь дүгнэхэд Үндэсний аюулгүй байдалд нөлөө үзүүлдэг олон хүчин зүйлүүд байх агаад тэдгээрийн нэг нь үндэсний үнэт зүйл болохыг тодорхойлохыг хичээлээ. Аливаа үндэстний үнэт зүйл нийгмийн хөгжлийн түүхэн урт удаан хугацааны туршид тухайн улс үндэстний онцлог, туулж өнгөрүүлсэн түүх, ой санамж, төрийн бодлого, нийгмийн тогтвортой байдлыг бүрдүүлэгч чухал элемент болж үндэсний аюулгүй байдалд нөлөө үзүүлдэг байна.

Нийгэм, улс төр, эдийн засгийн өөрчлөлтийг дагаад, мөн орчин үеийн технологийн хөгжлөөс үүдэн нийгмийн харилцаа, үнэт зүйлс

<sup>18</sup> Монголчуудын үндэсний үнэт зүйлийн судалгааны тайлан. СЭЗДС. УБ., 2015.т.4-5



ихээхэн өөрчлөгдөж байна. Системийн хандлагын үүднээс авч үзвэл энэ нь нийгмийг тогтворжуулагч үндсэн элементүүд эмх замбараагүй байдалд орвол систем хямрах аюултай. Иймд

онолын зүй тогтлоор элементүүдийн тогтвортой байдлыг хангах шаардлага нь эдгээрийн холбоо хамаарлыг судлах, тодорхойлох чухал ач холбогдолтойг харуулж байна.

### Ашигласан материал:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010.
2. Алсын хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал. УБ., 2019 он. т.90
3. Н.Жалбажав. Ч.Сосорбарам. Үндэсний үнэт зүйл, ой санамжийг сэргээх нь эх оронч үндэсний үзлийг дээдлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны үндсэн зарчим. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хүн амын оюун дархлааны асуудал сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2020. т.46
4. Монголчуудын үндэсний үнэт зүйлийн судалгааны тайлан. СЭЗДС. УБ., 2015
5. Монголчуудын үнэт зүйлсийг Шварцийн аргачлалаар тодорхойлсон нь. Удирдлагын академи. УБ., 2017.
6. Монголын соёл урлаг судлал. УБ., 2019.
7. "Монголчуудын үнэт зүйл" судалгааны тайлан. СУИС. УБ., 2019
8. Монголчуудын үнэт зүйлсийг Шварцийн аргачлалаар тодорхойлсон нь. Удирдлагын академи. УБ., 2017
9. "Монголчуудын үнэт зүйл" судалгааны тайлан. СУИС. УБ., 2019
10. "Монголчуудын үндэсний үнэт зүйл" судалгааны тайлан. СЭЗДС. УБ., 2015
11. Монголчуудын үнэт зүйлсийг Шварцийн аргачлалаар тодорхойлсон нь. Удирдлагын академи. УБ., 2017
12. "Монголчуудын үнэт зүйл" судалгааны тайлан. СУИС. УБ., 2019
13. "Монголчуудын үндэсний үнэт зүйл" судалгааны тайлан. УБ., 2015
14. Нийгмийн шинэчлэл: амьдралын хэв маягийн өөрчлөлт. ШУА-ийн ФСЭХ. УБ., 2001
15. Нобелийн шагналтнуудын айлдвар. Ред. Гомбосүрэн Ц. УБ., 2010
16. Круглова.Л.К. Культурология. Санкт-Петербург. 2008
17. Х.Орхончимэг. Үндэсний ой санамж ба батлан хамгаалах боловсрол. Үндэсний ой санамжийг сэргээн тодорхойлох нь сэдэвт эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийн эмхэтгэл. УБ., 2021
18. Сүрэнчимэг Д. Байгууллагын соёл ба үнэт зүйл. Монголчуудын үнэт зүйл цуврал лекц. СУИС. 2018.05.18.

## ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ХИЛ ХАМГААЛАЛТЫН СИСТЕМИЙН ОРОЛЦОО

**А.ГАНБИЛЭГ** /Хил судлалын хүрээлэнгийн хилийн аюулгүй байдал судлалын төвийн дарга, докторант/

**Түлхүүр үг:** Систем, хил хамгаалалтын систем, зүй тогтол, шатлан захирагдах

**Key words:** System, border protection system, regularity, rule of thumb

**Товч агуулга:** Энэхүү өгүүлэлд Үндэсний аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлыг хангах системд хил хамгаалалтын системийн оролцоо, түүнтэй холбогдох арга зүйн үндэс, хил хамгаалалт нь систем болох талаар тодорхойлж авч үзлээ.

**Үндсэн агуулга.** Аюулгүй байдал судлалын “аюулгүй байдал” гэсэн хамгийн ерөнхий суурь ухагдахуун<sup>1</sup> олон үйл явцад хэрэглэгддэг бөгөөд мөн чанарын хувьд нэг талаас, аюулгүй байдлын зөвхөн тодорхой тохиолдолд байдаг онцгой шинжийг агуулахын зэрэгцээ нөгөө талаас, төрөл бүрийн салбарт энэ ухагдахууныг ашиглах боломжийг нөхцөлдүүлж, харилцан хамаарал бүхий гурван төлөв байдлыг илэрхийлж байна. Үүнд:

1. аюулаас ангид, өөрөөр хэлбэл аюул байхгүй байдал;
2. аюулаас хамгаалагдсан байдал;
3. хөгжлийн нөхцөл бүрдүүлсэн байдал.

Эдгээрийг хэл шинжлэлийн философи утга талаас өгсөн тодорхойлолтуудын өнцгөөс тайлбарлавал: нэг талаас “аюулгүй-аюул байхгүй, айж эмээх, сандрах түгшүүргүй; аюулгүй байдал-осол, түгшүүргүй байх төлөв”<sup>2</sup> гэж аюул байхгүй, аюулгүй байдал баталгаатай хангагдсан нөхцөлийг илэрхийлсэн бол нөгөө

талаас “аюулгүй байдал-аюул байхгүй, бүтэн байлгах, найдвартай байдал”<sup>3</sup> гэж аюул байхгүй, хамгаалагдсан байдал, хөгжлийн нөхцөл бүрдүүлсэн байдал зэрэг өөрөөр хэлбэл, “аюул”, “хамгаалалт”, “хөгжил” гэсэн түгээмэл нийтэд хамааралтай ойлголтын аль алиныг нь багтаасан харьцангуй илүү өргөн цогц хүрээгээр илэрхийлэгдэж байна.

Тиймээс аюулгүй байдал судлалын суурь ойлголтыг үндсэн ухагдахуун талаас нь хэл шинжлэлийн үүднээс, харин түүний хэрэглээний ойлголтын агуулгыг үзэгдэл, үйл явдал, үр дүнгийн гаргалгааны өнцгөөс авч үзэх шаардлагатай юм.

Үндэсний аюулгүй байдал гэдэг ойлголтын хувьд дээр авч үзсэн хэл шинжлэлийн эхний тайлбар ухагдахуун хүрэлцээгүй юм. Бодит амьдрал дээр үндэсний аюулгүй байдлын хувьд янз бүрийн шинж чанар бүхий аюул занал байсан, байна, байсаар байх болно. Тиймээс “үндэсний аюулгүй байдал” гэдэг ухагдахууныг хэл шинжлэлийн хоёр дахь тайлбар гаргалгааны харилцан хамаарал бүхий гурвалсан утгыг агуулсан цогц өргөн ойлголтоор авч үзэх ёстой юм. Өөрөөр хэлбэл, “үндэсний аюулгүй байдал” гэдэг ойлголт нь **үнэмлэхүй** биш, зөвхөн харьцангуй утга санааг илэрхийлсэн

<sup>1</sup> Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Т-Х., ШУА., -УБ., 2008, 2650 х., т.2269. “Ухагдахуун-ухахад өртөх юм, мэдэгдэхүүн, хэрэг бодосын мөн чанарын ерөнхий онцлогийг тусгадаг сэтгэхүйн хэлбэр; ухагдахууны багтаамж-ухагдахууны агуулгад хамаарах шинж бүхий юмсын олонлог; логикийн ухагдахуун-тухайн ангийн юмс, үзэгдлийг тэдгээрийн ерөнхий, нийтлэг өвөрмөц шинжээр нь нэгтгэж дүгнэсэн санаа; философийн ухагдахуун-юмс, үзэгдлийн гол шинж, холбоо харилцааг тусгасан сэтгэхүйн хэлбэр; хэлний ухагдахуун-үгийн ахуй амьдралтай холбоотой хүний сэрэлд буух ойлголт; ойлголт ухагдахуун-юмс үзэгдлийн талаарх ерөнхий төсөөлөл, мэдэгдэхүүн”;

<sup>2</sup> Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. А-Г., ШУА., -УБ., 2008, 594 х., т.176;


<sup>3</sup> Далийн тайлбар тольд байгаа ухагдахуун. Энд “бүтэн байлгах” гэдгийг хамгаалагдсан байдал, найдвартай байдал гэдгийг тогтвортой хөгжлийн ойлголттой дүйцүүлэн гаргалгаа хийсэн болно;



ойлголт юм. Иймд аюулгүй байдлын ерөнхий онолын үүднээс “аюулгүй байдал-олон улсын, улс үндэстний, хамт олны, түүгээр ч барахгүй хувь хүний хэмжээнд түгээмэл хэрэглэгддэг ажил, амьдралын амгалан тайван орчин нөхцөлийн тухай ерөнхий ойлголт”<sup>4</sup> гэсэн тодорхойлолттой санал нийлж болох бөгөөд ийм нөхцөл хангагдсан түшингээр үндэсний аюулгүй байдлын түвшин тодорхойлогдоно гэж үзэх хэрэгтэй юм.

“Үндэсний аюулгүй байдал” систем болон түүнийг хангах системийн ойлголтын агуулгыг шинжлэх ухааны танин мэдэхүйн болон системийн хандлагын өнцгөөс нэгд, онол арга зүйн тайлбар гаргалгаа хийж; хоёрт, үүн дээрээ тулгуурлан үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтад ойлголтуудыг хэрхэн тодорхойлсныг авч үзье.

Үндэсний аюулгүй байдлыг түүнд учирч болох аюул заналын эх үүсвэрийн оршиж байгаа байрлал болон улс хоорондын нутаг дэвсгэрийн хил хязгаартай уялдуулан дотоод ба гадаад аюулгүй байдал гэж ангилдаг байна. Ийм ангилал нь үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг шийдвэрлэх аливаа үзэл баримтлалын хандлагыг нарийн тодорхой ангилахад үлэмж ашиг тустай байхын зэрэгцээ дотоод болон гадаад аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр, арга зам хоорондоо тэс өөр байдагтай холбоотой юм. Түүнчлэн дотоод, гадаад аюулгүй байдал нь харилцан хамааралтай бие биедээ нөлөөлдөг зүй тогтолтой байна. Үндэсний аюулгүй байдлын ерөнхий бүдүүвчийг 1 дүгээр зураг дээр харууллаа.



1.1. дүгээр зураг. Үндэсний аюулгүй байдлыг аюулын эх сурвалжаас хамаарч ангилах нь<sup>5</sup>

Үндэсний аюулгүй байдлын энэ онолын ойлголтоос түүний систем болон түүнийг хангах үйл ажиллагааны системийг дараах математик бичлэгүүдээр илэрхийлж болно<sup>6</sup>.

**Үндэсний аюулгүй байдлын систем:**

$$\Sigma S_{\text{yab}} : \{ \{ S_d \}, \{ S_r \} \} \quad (1.1)$$

Энд,  $\Sigma S_{\text{yab}}$  - Үндэсний аюулгүй байдлын систем;

$\{ S_d \}$  - Дотоод аюулгүй байдлын систем /үндэсний аюулгүй байдлын системийн дэд систем/;

$\{ S_r \}$  - Гадаад аюулгүй байдлын систем /үндэсний аюулгүй байдлын системийн дэд систем/;

$\{ \{ S_d \}, \{ S_r \} \}$  - Дотоод болон гадаад аюулгүй байдлын системүүд, тэдгээрийн хоорондын хамаарлыг тооцсон үр дүнгийн төлөв байдлын цогц.

**Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны систем:**

$$\Sigma S_{\text{yabx}} : F(\{ \{ X_{S_d} \}, \{ X_{S_r} \}, \{ X_{S_d}, X_{S_r} \} \}) \quad (1.2)$$

Энд,  $\Sigma S_{\text{yabx}}$  - Үндэсний аюулгүй байдлыг хангах систем;

$\{ X_{S_d} \}$  - Дотоод аюулгүй байдлыг хангах системийг бүрдүүлэгч элементүүдийн харилцан хамаарлын цогц;

$\{ X_{S_r} \}$  - Гадаад аюулгүй байдлыг хангах системийг бүрдүүлэгч элементүүдийн харилцан хамаарлын цогц;

$\{ X_{S_d}, X_{S_r} \}$  - Дотоод, гадаад аюулгүй байдлыг хангах системүүдийн хоорондын харилцан хамаарлын цогц;

$F(\{ \{ X_{S_d} \}, \{ X_{S_r} \}, \{ X_{S_d}, X_{S_r} \} \})$  - Үндэсний аюулгүй байдлыг хангах системийн дотоод ба гадаад аюулгүй байдлыг хангах системийн элементүүд хоорондын болон хоёр системийн хоорондын харилцан хамаарлыг тооцох үйл ажиллагааны цогцын үр дүнгийн функц.

Үндэсний аюулгүй байдлын систем болон түүнийг хангах системийн

<sup>4</sup> Цэргийн нэр томъёоны тайлбар толь. -УБ., Соёмбо принтинг, 2014. 702 х., т.56. ISBN 978-99973-7021-1;

<sup>5</sup> Паламдорж Ш. Үндэсний аюулгүй байдалд шинжилгээ хийх судалгааны онол, арга зүйн асуудалд. Монгол Улсын аюулгүй байдал: онол арга зүйн шинжилгээ. -УБ., :Соёмбо принтинг, 2019. 216х., т.57, ISBN:978-99978-68-08-4;

<sup>6</sup> Үржин О. "Үндэсний аюулгүй байдал" нэр томъёоны ойлголтыг цэгцлэх асуудалд. -//Аюулгүй байдал батлан хамгаалах судлал. -УБ., 2018., т.5., ISSN 2220-9115;



математик илэрхийллээс үндэсний аюулгүй байдлын системийн төлөв байдал нь түүнийг хангах системийн үйл ажиллагааны үр дүнгийн функцээр тодорхойлогдож байгааг харж болно. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлын системийн төлөв байдал түүнийг хангах системийн үйл ажиллагааны үр дүнгээс хамаарах зүй тогтолтой байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах системийг үндэсний аюулгүй байдлын системээс ялгаж ойлгох хэрэгтэй. Хэрэв үндэсний аюулгүй байдлын систем гэж ашиг сонирхлууд хийгээд, аюул заналын харилцан хамаарлыг тусгасан бүтэц бүхий систем бол үндэсний аюулгүй байдлыг хангах систем гэж үндэсний аюулгүй байдлыг хангах (үндэсний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий субъектүүдийн систем) зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах байгууллага, газар, хүч, хэрэгсэл, эрх зүйн орчин бүхий зохион байгуулалтын систем юм<sup>7</sup>.

Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал, түүнд хил хамгаалахын оролцоо, үүргийн судалгааг аюулгүй байдлын судалгааны үндсэн арга болох системийн хандлагын үүднээс шинжлэх шаардлагатай юм.

Иймд үндэсний аюулгүй байдлыг хангах системийн ерөнхий математик бичлэг дээр тулгуурлан энэхүү систем дэх хил хамгаалахын оролцоог тодорхойлох арга зүйг авч үзье.

Аюулгүй байдлын системийн ерөнхий математик бичлэгийг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд бүрдүүлсэн системийн жишээн дээр бичье<sup>8</sup>.

$$\sum_{\text{YAB}} : \{E_S, \{X_S\}, F(\{X_S\})\} \quad (1.3)$$

Энд,  $\sum_{\text{YAB}}$  - Үндэсний аюулгүй байдлын системийн тэмдэглэгээ;

$\{E_S\}$  - Үндэсний аюулгүй байдлын системийн элементүүдийн цогц

(оршин тогтнохуйн аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, хүний аюулгүй байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал гэсэн 6 элемент);

$\{X_S\}$  - Үндэсний аюулгүй байдлын системийг бүрдүүлэгч 6 элементүүдийн харилцан хамаарлын цогц;

$F(\{X_S\})$  - Үндэсний аюулгүй байдлын системийн элементүүдийн харилцан хамаарлыг хэрхэн тооцоноос хамаарах үр дүнгийн функц.

Системийн хандлагаар үндэсний аюулгүй байдлыг хангах систем дэх үндэсний язгуур эрх ашгийг хамгаалан бэхжүүлэх хил хамгаалахын гүйцэтгэх үүрэг, оролцоог дараах арга зүйгээр тодорхойлж болох юм. Үүний тулд:

Хил хамгаалах бодлого, үйл ажиллагааны системийн үндэсний аюулгүй байдлыг хангахад гүйцэтгэх үүргийг  $S_{XX}$  гэж тэмдэглэе.

Үндэсний язгуур эрх ашгийн хангагдсан байдлаар хэмжигдэх үндэсний аюулгүй байдлын системийн хангагдсан байдлын бүтэмжийн үзүүлэлтийг  $W_{\text{YAB}}(\sum S_{\text{YAB}})$  гэж тэмдэглэе.

Үндэсний язгуур эрх ашгийг хангах үүднээс үндэсний аюулгүй байдлыг хангах системийн бүрэлдэхүүн элементүүдийн хамаарлыг тооцон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үрдүнгийн функц  $F(\{X_S\})$  нь хил хамгаалахын үүргийн  $S_{XX}$ -ын оролцоотой ( $S_{XX+}$ ) ба оролцоогүй ( $S_{XX-}$ ) хэрэгжсэн байж болно гэж үзье. Ийм нөхцөл тавигдах үед  $W_{\text{YAB}}(\sum S_{\text{YAB}}) = W_{\text{YAB}}(F(\{X_S\}), S_{XX+})$  эсвэл

$$W_{\text{YAB}}(\sum S_{\text{YAB}}) = W_{\text{YAB}}(F(\{X_S\}), S_{XX-}) \text{ байж болно.}$$

Ийм тохиолдлуудаас үндэсний аюулгүй байдлыг хангахад хил хамгаалахын үүргийн бүтэмжийн үзүүлэлт  $W_{XX}(S_{XX})$  нь  $W_{\text{YAB}}(\sum S_{\text{YAB}})$ -ийн өөрчлөлтөөр тодорхойлогдож болно<sup>9</sup>.

<sup>7</sup> Прохожев А.А. Общая теория национальной безопасности. -М., 2002. с.24-25;

<sup>8</sup> Үржин О., Эрдэнэчимэг Б. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудалтай батлан хамгаалах бодлогыг уялдуулах онол, арга зүй. -//“Монгол Улсын аюулгүй байдлын орчин-батлан хамгаалах бодлого”/ Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл/. -УБ., ҮБХИС., 2017, т.17;

<sup>9</sup> Үржин О. Судалгаа шинжилгээнд тогтолцооны хандлагыг хэрэглэх, бүтэмжийн үзүүлэлтийг сонгох арга зүй. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал. -УБ., БХЭШХ., 2014., х.143, т.55, ISBN:978-99978-848-9-3;

Үүнийг дараах илэрхийллээр харуулж болно.

$$W_{\gamma\alpha\beta}(S_{xx}) = W_{\gamma\alpha\beta}(F(\{X_s\}, S_{xx}+) - W_{\gamma\alpha\beta}(F(\{X_s\}, S_{xx}-)) \quad (1.4)$$

(1.4) илэрхийллээс үндэсний аюулгүй байдлыг хангахад хил хамгаалах оролцооны хувь ( $Q_{xx}$ ) –ийг дараах томъёоллоор илэрхийлж болно.

$$Q_{xx} = \frac{W_{\gamma\alpha\beta}(F(\{X_s\}, S_{xx}+) - W_{\gamma\alpha\beta}(F(\{X_s\}, S_{xx}-))}{W_{\gamma\alpha\beta}(F(\{X_s\}, S_{xx}+)}, \quad (1.5)$$

Ерөнхий арга зүйгээ ийнхүү тодорхойлсны үндсэн дээр үндэсний аюулгүй байдлыг хангах систем дэх хил хамгаалахын оролцоог түүний гүйцэтгэх үүргээр нь илэрхийлэн тодорхойлох боломжийг бүрдүүлж байгаа юм.

Тиймээс ч эрх зүйн үндсэн тулгуур баримт бичгүүд болох үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үндэсний аюулгүй байдлын үндэсний язгуур ашиг сонирхол, түүнийг хангахтай холбоотой болон Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хилийн аюулгүй байдлыг хангах хил хамгаалахын үүрэгтэй холбоо бүхий зарим чухал заалтуудыг харьцуулан шинжлэх боломж нээгдэж байна.

Ийм өнцгөөс шинжилгээг явуулахдаа: нэгд, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дэх үндэсний аюулгүй байдлын мөн чанар, түүний хангах нөхцөл, баримтлах зарчмуудыг авч үзэх; хоёрт, Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичиг дэх бодлогын гол заалтуудыг нэгд авч үзсэн үзэл баримтлал дэх заалтуудтай харьцуулсан гаргалгаа, дүгнэлтийн үндэслэлийг гаргах болно.

**Нэг.** Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал<sup>10</sup>: “Монгол Улсын үндэсний язгуур эрх ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын

халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.”; “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн.”; “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах нь үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөл мөн.”; “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн.” гэж үндэсний аюулгүй байдлын мөн чанар, түүнийг хангах нөхцөлүүдийн үндсийг томъёолсон бол Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчмуудад<sup>11</sup>: эх оронч үндэсний үзлийг дээдлэх зарчмыг “Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно.”; төр, иргэний хамтын ажиллагаа зарчмыг “Үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн анхдагч үүрэг мөн. Иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарна.”; аюулгүй байдлын бодлого цогц байх зарчмыг “Монгол Улсын “оршин тогтнохуйн аюулгүй байдал”, “эдийн засгийн аюулгүй байдал”, хүний

<sup>10</sup> Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. –//Төрийн мэдээлэл. –УБ., 2010. №36 /657/ т.1482;

<sup>11</sup> Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. –//Төрийн мэдээлэл. –УБ., 2010. №36 /657/ т.1483;



аюулгүй байдал”, “хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”, “мэдээллийн аюулгүй байдал” харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна.”; мэдлэгт суурилах зарчмыг “Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна.”; бодитой хандах зарчмыг “Болзошгүй аюул, сорилтыг бодитой тодорхойлж, тэдгээрийг гэтлэн давахад хязгаарлагдмал нөөц боломжийг үр дүнтэй дайчилна.”; даяаршлын хүчин зүйлийг харгалзах зарчмыг “Даяаршил улс үндэстний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас гадаад нөөц боломжийг ашиглан үндэсний ашиг сонирхлоо хамгаалж бататгах боломж олгож байна.” гэж агуулгыг нь үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах бодлого үйл ажиллагааг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглүүлэн тодорхойлсон байна.

**Хоёр.** Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичиг<sup>12</sup>:

1. “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд улсын дотоод, гадаад аюулгүй байдлын орчин нь хил хамгаалах зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох болно” гэж хил хамгаалахын үүрэг, оролцоо нь үзэл баримтлалын үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдаж байх зүй тогтолтойг баталсан.
2. “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын зорилго нь ... байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг

хангахад чиглэнэ.” гэж хил хамгаалах нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан оршин тогтнохуйн аюулгүй байдлыг болон үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөлийг баталгаажуулах үндсэн үүрэг хүлээдэг болохыг илэрхийлсэн.

3. “Хил хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн.” гэж хил хамгаалахын оролцоо нь үзэл баримтлалын оршин тогтнохуйн аюулгүй байдлыг баталгаажуулах үүднээс “аюулгүй байдлын бодлого цогц байх” зарчмыг хэрэгжүүлэх, зохицуулах үүрэгтэй байх, мөн бүх зарчмууд хил хамгаалах бодлого, үйл ажиллагаанд мөрдөгдөх ёстойг харуулсан.
4. “Монгол Улсын аюулгүй байдлыг хангах, хил хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалыг үндэс болгон улс төр дипломатын аргыг урьтал болгох бөгөөд улсын хил дээр хүч хэрэглэхээс аль болох зайлсхийх, ..” гэсэн заалт нь үзэл баримтлалын “мэдлэгт суурилах”, “бодитой хандах” зарчмууд үндэсний аюулгүй байдлыг хангах хил хамгаалах оролцоонд чухал ач холбогдолтой болохыг илтгэж байна.

<sup>12</sup> Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. Заалт 1.1 ба 1.3, Монгол Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар тогтоолын хавсралт.

5. “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг мөн.”, “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд үндэслэсэн улсын хил, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын талаарх Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болсон залгамж чанартай тулгуур баримт бичиг мөн” гэсэн заалтуудыг хил хамгаалах бодлогын эрх зүйн чиглэлд оруулсан нь үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт шатлан захирагдахын зарчмын дагуу үндсэн хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Батлан хамгаалах бодлого, Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндсийн холбогдох заалтууд дээр тулгуурлан боловсруулагдах ёстойг үзүүлж байна.

Энэ бүх харьцуулалтаас үндэсний аюулгүй байдлыг хангах систем дэх хил хамгаалахын оролцоо, үүргийн талаар дараах хамаарлуудыг үндэслэж болох байна. Үүнд:

**Нэгдүгээрт**, хил хамгаалах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлыг болон үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөлийг баталгаажуулах үндсэн үүрэг хүлээдэг нь хэрэв үндэсний аюулгүй байдлыг хангахад оршин тогтнохуйн аюулгүй байдал болон үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөлийн баталгаажуулалт магадлалын онолын үүднээс 0,5 ба түүнээс их байх ёстой гэж үзвэл үндэсний аюулгүй байдлыг хангахад хил хамгаалахын гүйцэтгэх үүргийн бүтэмж  $W_{xx}(S_{xx}) \geq 0,5$  байх шаардлагатай.

Хэрэв энэ тохиолдолд үндэсний аюулгүй байдлын системийн хангагдсан байдлын түвшний бүтэмжийг 0,7-гоос багагүй байлгана гэж үзвэл түүнийг хангахад хил хамгаалахын оролцооны хувь хамгийн багаар тооцоход 28,5 хувь байх жишээтэй.

**Хоёрдугаарт**, хил хамгаалах үйл ажиллагааны үр дүн үндэсний аюулгүй байдлыг хангах системийн танин мэдэхүйн, өөрөөр хэлбэл бидний (1.3) илэрхийллээр томъёоллыг нь харуулсан системийн үр дүнгийн функц  $F(\{X_S\})$ -ийн  $\{X_S\}$  хамааралд хил хамгаалахын үүрэг, оролцоог хангах арга хэмжээнүүдийг хэрхэн тооцооноос хамаарах бөгөөд тэр нь түүний үр дүнд шууд нөлөөлөх зүй тогтолтой байна. Үүний тулд үндэсний аюулгүй байдлын “аюулгүй байдлын бодлого цогц байх” зарчмыг хэрэгжүүлэхэд хил хамгаалах голлох, зохицуулах үүрэгтэй байхыг мөрдсөнөөр  $F(\{X_S\}) \rightarrow W_{\text{габ}}(F(\{X_S\}), S_{xx} +)$  байх нөхцөлийг бүрдүүлж болох юм. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлыг хангах системийн үр дүнгийн функцийн утга нь үндэсний аюулгүй байдлын системийн хил хамгаалахын үүргийн оролцоотойгоор хангагдах бүтэмжийн үзүүлэлт рүү тэмүүлж байх болно.

#### **Хил хамгаалалтын систем**

Дээрхэд үндэслэн “Хил хамгаалалтын систем нь хилийн аюулгүй байдлыг хангах харилцан уялдаа бүхий үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцсэн үйл ажиллагааны нэгдмэл цогц” хэмээн тодорхойлогдоно.

Улсын хил гэсэн ойлголтыг “Монгол Улсын нутаг дэвсгэрийн зах хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил гэнэ. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна<sup>13</sup>.” гэж хуульчилсан байдаг. Энэ тодорхойлолтыг системийн хандлагын

<sup>13</sup> “Монгол Улсын хилийн тухай” Монгол Улсын хууль /Шинэчилсэн найруулга/. -//Төрийн мэдээлэл. –УБ., 2017. №06/963/ т.150;



өнцгөөс шинжилбэл улсын хил гурван бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн хоорондын хамаарлаас тогтсон бүтцийн систем болохыг харж болно. Үүнийг математикаар илэрхийлбэл<sup>14</sup>:

$$\sum S_{yx} \{ \Gamma X_x; A_x; \Gamma X_x; \{ X_{\Gamma X_x, A_x, \Gamma X_x} \} \}, \quad (1.6)$$

Энд,  $\sum S_{yx}$  - улсын хил систем болохыг харуулсан тэмдэглэгээ;

$\Gamma X_x$  - газрын гадаргуун хил;

$A_x$  - агаарын хил;

$\Gamma X_x$  - газрын хэвлийн хил;


$\{ X_{\Gamma X_x, A_x, \Gamma X_x} \}$  - газрын гадаргуун, агаарын, газрын хэвлийн хилийн харилцан хамаарлын цогц.

“Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ<sup>15</sup>” гэсэн хуулийн тодорхойлолтыг математик томъёололтой харьцуулан задлан шинжилбэл энэ ойлголт нь хил хамгаалалтын системийн зөвхөн нэг элементийн, өөрөөр хэлбэл газрын гадаргуу, усны мандлын хил хамгаалалтын асуудлыг хамарсан байна. Энэ нь шатлан захирагдахын хуультай зөрчилдөж хил хамгаалалтын цогц ойлголтыг хялбарчлан агуулгыг нь бүрэн гаргаж чадахгүйд хүргэжээ.

Энд газрын хэвлийн хилийг

хамгаалах ойлголт орхигдсон байгааг цаашид анхаарч нарийвчлан хуульчлах шаардлагатай.

Улсын хил хамгаалалтын систем буюу цогц байдлын зургаар илэрхийлбэл дараах байдалтай байна<sup>16</sup>.



1.2 дугаар зураг. Улсын хилийн системийн зураглал

Тиймээс ч улсын хил хамгаалалт зөвхөн газрын гадаргуун хилийн шугамын уртаар хязгаарлагдах бус, харин түүнээс эгц дээш болон доош үргэлжилсэн босоо хавтгайн талбайн хүрээнд яригдана<sup>17</sup>.

$$S_{yx} = L_{\Gamma X_x} * H_{yx}, \quad (1.7)$$

Энд,  $S_{yx}$  - улсын хил хамгаалалтын талбай, км<sup>2</sup>;

$L_{\Gamma X_x}$  - газрын гадаргуун хилийн урт, км;  
 $H_{yx}$  - хилийн хамгаалалтын өндөр, км.

$$H_{yx} = h_{A_x} + g_{\Gamma X_x}, \quad (1.8)$$

Энд,  $h_{A_x}$  - агаарын хилийн өндөр, км;  
 $g_{\Gamma X_x}$  - газрын хэвлийн хилийн гүн, км.

Улсын хилийн систем болон түүний хамгаалалтын талаар эрдэмтэн судлаач Б.Даш-Ёндон дараах үзэл бодлыг илэрхийлсэн байдаг<sup>18</sup>.

Өнөө үед Монгол Улс маань гурван хилийн дотор оршин буй амой.

а) Уламжлалт ойлголтоос гаднах гуравдах хил нь газрын хэвлийн хил болой. Газрын хэвлийн

<sup>14</sup> Үржин О. Үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс хилийн аюулгүй байдлыг шинжлэх нь. // Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам/ Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл/. –УБ., 2018., т.40;

<sup>15</sup> "Монгол Улсын хилийн тухай" Монгол Улсын хууль /Шинэчилсэн найруулга/. –//Төрийн мэдээлэл. –УБ., 2017. №06 /963/ т.150;

<sup>16</sup> Үржин О. Үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс хилийн аюулгүй байдлыг шинжлэх нь. // Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам/ Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл/. –УБ., 2018., т.40;

<sup>17</sup> Мөн тэнд

<sup>18</sup> Даш-Ёндон Б. Монголын хөгжлийн философи /асуудал, аргачлал, ашиг тус/. –УБ., 2017, 190 х., т. 44;

их баялгаа ашиглах буюу уул уурхайг эрхлэх хэмээх нь манай нөхцөлд эл өвөрмөц хил хязгаарыг буй болгож байгаа юм. Энд буй ашигт малтмал бол манай улсын, манай бүх ард түмний өмч хөрөнгө мөн.

б) Газрын хөрсөн дээр нутаг дэвсгэрийн маань хил хязгаар буй.

в) Тэнгэр огторгуйд манай агаарын орон зайн хил хязгаар буй.

Сүүлийн хоёр нь, сахин хамгаалах утгаар, Монгол Улсын маань торгон бөгөөд дархан хил юм. Харин газрын хэвлийн торгон хилийг дархалж болохгүй ажгуу, яагаад гэвэл хөрсөн доорх баялгийг ямар нэгэн байдлаар гадаад, дотоодын оролцоотойгоор ашиглах нь гарцаагүй билээ.

Улсын хилийн энэхүү ойлголтын хүрээнд нутаг дэвсгэр нь дараах эзлэхүүн бүхий орон зайн хэмжээсээр илэрхийлэгдэнэ.

$$V_{\text{нд}_6} = S_{\text{нд}} \cdot H_{\text{нд}}, \quad (1.9)$$

Энд,

$V_{\text{нд}_6}$  - нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах орон зайн хэмжээс, км<sup>3</sup>;

$S_{\text{нд}}$  - нутаг дэвсгэрийн талбайн хэмжээ, км<sup>2</sup>;

$H_{\text{нд}} = h_{A_0} + g_{\text{ГХ}_2}$  - агаарын орон зайн өндөр ( $h_{A_0}$ ) болон газрын хэвлийн гүн ( $g_{\text{ГХ}_2}$ )-ий нийлбэрээр тодорхойлогдох нутаг дэвсгэрийн өндөр, км.

Агаарын орон зайн өндрийг авахдаа: “Үндэсний агаар мандлын орон зай гэж тухайн улсын хуурай болон усан газар нутгийн дээрх агаар мандлыг хэлнэ. 1919 оны Парисын Конвенцын дагуу улс орнууд өөрийн Үндэсний агаар мандлын орон зайг өөрийн газар нутгийн адилаар үзэж бүрэн эрхтэйгээр эзэгнэнэ. Үндэсний агаар мандлын хилийг хуурай болон усан газар нутгийн хилээс чанх дээш татсан шулуун шугамаар тогтооно. Энэ орон зайн дээд хязгаар нь “Сансар” хүрнэ” гэсэн олон улсын эрх зүйн зохицуулалт ба гүний ус, газрын баялгийн оршин буй гүний хэмжээг мөрдөх нь зүйтэй юм.

Хилийн тухай хуулиар баталгаажуулсан тодорхойлолтын агуулга, түүний систем болохыг харуулсан илэрхийлэл болон зургийн шинжилгээнээс дараах дүгнэлт хийж болох байна. Үүнд: нэгд, улсын хилийн шугамыг хил залгаа улстай хамтран зөвхөн газар орон (газрын гадаргуу, усны мандал) дээр л тодорхойлон тогтоох боломжтой байна; хоёрт. газрын гадаргуун хил өөрчлөгдөхөд агаарын болон газрын хэвлийн хил даган өөрчлөгдөх зүй тогтолтой байна; гуравт, улсын хилийн хамгаалалтын асуудал орон зайн хувьд газрын гадаргуу, агаар, газрын хэвлий гэсэн харилцан хамаарал бүхий гурван орчны хүрээнд шийдвэрлэгдэх үйл ажиллагааны систем байна.

Энэ гурван дүгнэлтэд тус бүрд нь товч тайлбар гаргалгаа хийх нь улсын хилийн хамгаалалтын системлэг хандлагад тустай байх болно.

#### **Нэгдүгээр дүгнэлтийн хувьд**

улсын хилийн шугамыг (газрын гадаргуун хилийг) хил залгаа улстай хамтран газар орон дээр дараах байдлаар тодорхойлон тогтоодог байна. Үүнд:

нэгд, а/ хуурай газарт тодорхой тэмдэгт, тогтвортой юмсыг хооронд нь холбосон шулуун шугамаар, эсхүл уул нурууны усны хагалбараар;

б/ гол, мөрөн, горхинд үндсэн урсгалын дундуур, нуурын эрэгт тулж ирсэн улсын хилийн шугамын хоёр үзүүрийг холбосон шулуун шугамаар;

в/ улсын хил дамнасан байгууламжид улсын хилийн шугам өнгөрч байгаагаар тустустодорхойлдог байна.;

хоёрт, тодорхойлсон хилийн шугамын талаар хил залгаа улстай олон улсын хилийн гэрээ байгуулж, түүнийг Улсын Их Хурал соёрхон баталдаг байна.

гуравт, хил залгаа улстай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу түүнтэй хамтран улсын хилийн шугам, хилийн тэмдгийн байршлыг газар дээр нь тогтоох ажлыг гүйцэтгэдэг байна.



**Хоёр дахь дүгнэлтийн хувьд** улсын хилийг газар орон дээр газрын гадаргуун хилийн шугамаар тогтоож, агаарын болон газрын хэвлийн хил нь түүнд харгалзан эгц дээш ба эгц доош тодорхойлогдох хамаарал нь газар орон дээр хилийн шугамыг өөрчлөн тогтоовол агаарын болон газрын хэвлийн хил мөн тэр хэмжээгээр өөрчлөгдөх зүй тогтолтойг харуулж байна.

**Гурав дахь дүгнэлтийн гаргалгааны хувьд:** улсын хил хамгаалалтын гол үүрэг нь үндсэн хуулийн "Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна.", үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын "Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд ... Монгол Улсын ... нутаг дэвсгэр, хил

хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал ... багтана", хилийн тухай хуулийн "Улсын хил халдашгүй дархан байна. Улсын хилийн халдашгүй дархан байдал нь улсын хилийн шугам хууль бусаар өөрчлөгдөхгүй, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ зөрчигдөхгүй байхаар хангагдана" гэсэн заалтуудын хэрэгжилтийг хангах явдал байна. УИХ-аар хуульчлан баталгаажуулсан "хилийн халдашгүй дархан байдал"-ын тодорхойлолтоос танин мэдэхүйн хувьд хилийн халдашгүй дархан байдал алдагдаж болох хоёр замыг харж болох байна. Үүнд эхнийх нь улсын хилийн шугам хууль бусаар өөрчлөгдөх; дараагийнх нь хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ зөрчигдөх явдал байна.

### Ашигласан материал:

1. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Т-Х., ШУА., -УБ., 2008, 2650 х., т.2269.
2. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. А-Г., ШУА., -УБ., 2008, 594 х., т.176;
3. Далийн тайлбар тольд байгаа ухагдахуун. Энд "бүтэн байлгах" гэдгийг хамгаалагдсан байдал, найдвартай байдал гэдгийг тогтвортой хөгжлийн ойлголттой дүйцүүлэн гаргалгаа хийсэн болно;
4. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. -УБ., :Соёмбо принтинг, 2014. 702 х., т.56. ISBN 978-99973-7021-1;
5. Паламдорж Ш. Үндэсний аюулгүй байдалд шинжилгээ хийх судалгааны онол, арга зүйн асуудалд. Монгол Улсын аюулгүй байдал: онол арга зүйн шинжилгээ. -УБ., :Соёмбо принтинг, 2019. 216х., т.57, ISBN:978-99978-68-08-4;
6. Үржин О. "Үндэсний аюулгүй байдал" нэр томъёоны ойлголтыг цэгцлэх асуудалд. -// Аюулгүй байдал батлан хамгаалах судлал. -УБ., 2018., т.5., ISSN 2220-9115;
7. Прохожев А.А. Общая теория национальной безопасности. -М., 2002. с.24-25;
8. "Үндэсний аюулгүй байдлын тухай" Монгол Улсын хууль. -УБ., 2001. <https://legalinfo.mn/mn/detail/18>;
9. Үржин О., Эрдэнэчимэг Б. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудалтай батлан хамгаалах бодлогыг уялдуулах онол, арга зүй. -// "Монгол Улсын аюулгүй байдлын орчин-батлан хамгаалах бодлого" / Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл/. -УБ., ҮБХИС., 2017, т.17;
10. Үржин О. Судалгаа шинжилгээнд тогтолцооны хандлагыг хэрэглэх, бүтэмжийн үзүүлэлтийг сонгох арга зүй. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал. -УБ., БХЭШХ., 2014., х.143, т.55, ISBN:978-99978-848-9-3;
11. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. -//Төрийн мэдээлэл. -УБ., 2010. №36 /657/ т.1482;
12. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. -//Төрийн мэдээлэл. -УБ., 2010. №36 /657/ т.1483;
13. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. Заалт 1.1 ба 1.3, Монгол Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар тогтоолын хавсралт.
14. "Монгол Улсын хилийн тухай" Монгол Улсын хууль /Шинэчилсэн найруулга/. -//Төрийн мэдээлэл. -УБ., 2017. №06 /963/ т.150;
15. Үржин О. Үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс хилийн аюулгүй байдлыг шинжлэх нь. -//Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам/ Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл/. -УБ., 2018., т.40;
16. Даш-Ёндон Б. Монголын хөгжлийн философи /асуудал, аргачлал, ашиг тус/. -УБ., 2017, 190 х., т. 44;



## АГААРЫН ЦЭРЭГ БОЛОН РАДИОТЕХНИКИЙН АНГИ, САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

**Н.ЭНХБАТ** /УБХИС-ийн АБДС-ийн багш, доктор (Ph.D), бэлтгэл хурандаа/

**Түлхүүр үг:** Агаарын орон зай, радиолокацийн станц, тоон систем, автоматжуулсан удирдлагын систем, нэгдсэн сүлжээ

**Key words:** Airspace, radar station, digital system, automated control system, integrated network

**Оршил.** Монгол Улсын агаарын хил, орон зайг найдвартай хянах, халхлах чадавх бүхий Агаарын цэргийг Зэвсэгт хүчний бүтцэд бие даан үүрэг гүйцэтгэхээр хуульчлагдсан.

Иймд Монгол Улсын өргөн уудам газар нутаг /1,5 сая гаруй хавтгай дөрвөлжин километр талбай бүхий газар нутаг, түүнээс эгц дээш 25 км хүртэлх агаарын орон зай/-ийг хамарсан агаарын хил, орон зайн аюулгүй байдлыг найдвартай хангах, бүс нутагт гарч болзошгүй аливаа сөрөг үйл ажиллагаанд шуурхай хариу арга хэмжээ авах үүрэг зориулалт бүхий Агаарын цэргийг хөгжүүлэх, түүний үндсэн чиглэлийн нэг болох агаарын орон зайн хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгох талаар асуудлыг хөндөн тавьж байна.

Радиотехникийн анги, салбаруудын ирээдүйн хөгжлийн чиг хандлага нь Монгол Улсын агаарын орон зайн хяналтын нэгдсэн тогтолцоонд тулгуурлана гэж харж байна.

Агаарын цэргийн хөгжил, түүний дотор радиотехникийн анги, салбаруудын хөгжлийн чиг хандлагыг бий болгох хууль, эрх зүйн орчин бүрдсэн гэж хэлж болох байна.

**Үндсэн хэсэг.** Цэргийн салбарын агаарын хил, агаарын зайн хяналтын системийг зохион байгуулахдаа нийт Монгол Улсын агаарын хил, агаарын зайн 95 хувь нь радиолокацийн хяналтад байхаар тооцож хүч хэрэгслийг байршуулсан байдаг.

Сүүлийн 5 жилийн статистик мэдээгээр агаарын зайн радиолокацийн хяналтын хэрэгслүүдийн техникийн үзүүлэлт 50-60 хүртэл хувиар

буурч, эвдрэл гэмтлийн давтамж жилд дунджаар 35-40 хувиар өссөн, тэдгээрийн үйлдвэрээс тогтоосон ашиглалтын нөөц аль хэдийнээ дууссан, чанар байдал нь байнга дордож байгаа билээ. Энэ шалтгаанаар Монгол Улсын агаарын хил, агаарын орон зайн радиолокацийн хяналт зохион байгуулсан түвшинтэй харьцуулбал 30 гаруй хувь буурсан тооцоо гарч байна.

Иймээс орчин үеийн техник технологийн шинэчлэлд тулгуурласан агаарын орон зайн нэгдсэн сүлжээ бий болгоход суурь техник, хэрэгсэл /радар буюу радиолокацын станц/-д технологийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм.

Хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохдоо үндсэн 3 түвшинд авч үзэх нь зүйтэй. Үүнд:

I. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий Командлагч, УИХ-ын түвшин;

II. Монгол Улсын Засгийн Газар, Батлан Хамгаалах Яамны түвшин;

III. Зэвсэгт хүчний Агаарын Цэргийн Командлал, анги, байгууллагын түвшин.

### I түвшин

Агаарын цэргийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох бодлогын баримт бичиг боловсруулж батлуулах нь нэн тэргүүний асуудал болж байна. Энэ баримт бичиг нь:

- Зэвсэгт хүчний Агаарын цэргийн хүч, хэрэгслээр Монгол Улсын агаарын хил, орон зайг хянах, нийслэл хот, улсын онц чухал объектыг агаараас халхлах тогтолцоо;
- Зэвсэгт хүчний Агаарын цэргийн хөгжлийн бодлого гэсэн нэрийн



хувилбаруудыг санал болгож байна.

Энэхүү баримт бичгийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаар уламжлан Улсын Их Хурлаар хууль болгон баталгаажуулах хэрэгтэй гэж төсөөлж байна.

Баримт бичгийн бүтцийг дараах байдлаар харж байна. Үүнд:

1. Үндэслэл;
2. Агуулга;
3. Зорилго, зорилт;
4. Монгол Улсын агаарын хил, агаарын орон зайн хяналтын тогтолцоо;
5. Нийслэл хот, улсын онц чухал /стратегийн ач холбогдол бүхий/ объектыг агаарын довтолгооноос хамгаалах /халхлах/ тогтолцоо;
6. Сөнөөгч авиацийн хүч, хэрэгслээр халхлалт зохион байгуулах тогтолцоо;
7. Пуужин эсэргүүцэн хамгаалах болон нисгэгчгүй нисэх хэрэгслээр халхлалт зохион байгуулах тогтолцоо;
8. Удирдлагын тогтолцоо;
9. Хүлээгдэж буй үр дүн;
10. Санхүүжилт, эрсдэлийн тооцоо гэсэн дэд хэсгүүдээс бүрдэж болох юм.

Энэ баримт бичгийн гол агуулга нь Зэвсэгт хүчний Агаарын цэрэг ямар хүч, хэрэгсэлтэй байж хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэх чадвартай байх вэ? гэдгийг тусгах хэрэгтэй гэж харж байна.

Орчин үеийн дайн, байлдаан, зэвсэгт тэмцлийн сургамжаас үүдсэн судалгааг харахад явуулж буй цэргийн ажиллагаанд оролцож буй хүч, хэрэгслийнхээ АНУ /НАТО-ийн бүлэглэл/ 5-10%, ОХУ 30%, БНХАУ 50 %-ийг тус тус алдах эсвэл уг хэмжээнд хүртэл хохирол амссан тохиолдолд тухайн ажиллагаанаас татгалзах эсвэл операци, байлдааны ажиллагааг дахин төлөвлөдөг болсон байна.

### II түвшин

Монгол Улсын Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний тухай, Улсын нисэхийн тухай, Агаарын орон зайг ашиглах тухай хуулиудын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх үндсэн байгууллага нь Зэвсэгт хүчний Агаарын Цэргийн

Командлал юм.

Агаарын Цэргийн Командлал нь Зэвсэгт хүчний Жанжин Штабаар уламжлан Батлан Хамгаалахын Сайдаар баталгаажуулсан “Агаарын цэргийг хөгжүүлэх хөтөлбөр” түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж Монгол Улсын Засгийн Газарт өргөн барьж хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн санал оруулж байна. Уг хөтөлбөр нь урт хугацааны /15-20 жил/ бөгөөд Улсын Их Хурлаар батлагдсан бодлогын баримт бичигт тулгуурласан Засгийн Газрын өөрчлөлтөөс үл хамааран хэрэгждэг байх нь чухал байна.

Аливаа зэвсэгт тэмцлийн хууль, зүй тогтолд “Өндөр зардлаар шаардлагатай үр ашигт хүрдэг” гэсэн заалтыг удирдлага болговоос Агаарын Цэргийн хөгжлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөт арга хэмжээг зоосны нүхээр харж ашиг, орлого олохоос илүү Монгол Улсын агаарын хил, агаарын орон зайн хяналт шаардлагын түвшинд байж, нийслэл хотыг агаарын довтолгооноос хамгаалж, халхлах, сөнөөгч онгоцны баталгаат халхлалт бий болох үндэс суурь тавигдана гэж харах нь чухал байна.

### ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР /Хувилбар/

Нэг. Нийтлэг үндэслэл;

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, хэрэгжүүлэх зарчим, зорилт;

Гурав. Хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжүүлэх хугацаа;

д/д	Эх үүсвэр	Санхүүжилт /сая төгрөг/			Тайлбар
		2021	2022	....	
1	Улсын төсөв				
2	Хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламжийн хөрөнгө				
3	Зэвсэгт хүчний хөгжлийн сан				
	Нийт				

Дөрөв. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ.



### ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /Хувилбар/

№	Зорилт	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	Хөрөнгийн эх үүсвэр, хэмжээ (сая.төг)
-р зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ						
1						
2						

### III түвшин

Энэ түвшинд 2 асуудлыг санал болгож байна. Үүнд:

1. Монгол Улсын агаарын хил, агаарын орон зайг хянах Үндэсний нэгдсэн сүлжээ байгуулах;

2. Агаарын Цэргийн Командлалын дэргэд цэргийн эрдэмтдийн зөвлөл байгуулах.

**I асуудал.** Энэ асуудлын хүрээнд УИХ, Засгийн Газрын түвшинд холбогдох баримт бичгүүдэд хангалттай тусгагдсан. Монгол Улсын агаарын орон зайн хяналтыг сайжруулах, Иргэний Нисэхийн Ерөнхий Газар, Батлан Хамгаалах салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх чиглэлээр Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 1.2.8-т “Агаарын навигацын үйлчилгээг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын бодлого, чиг хандлагад нийцүүлэх”, 3.10-т “Монгол Улсын агаарын орон зайн аюулгүй байдал, иргэний агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангахад иргэний нисэх ба батлан хамгаалах салбар хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөртэй байна”, 3.11-т “Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгүүдийн талаар улсын болон иргэний нисэхийн нислэгийн хөдөлгөөний мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээг бий болгоно” гэсэн заалт тусгагдсан байдаг.

Агаарын цэргийн эрдэмтдийн төлөөлөгч болох доктор /Ph.D/ Б.Эрдэнэбат, Б.Далайбаатар, Ц.Дунгармаа болон мэргэжилтнүүдийн төлөөлөлтэй хамтран “Агаарын цэргийн хөгжүүлэх стратеги” судалгааны ажлыг боловсруулж, 2018 онд БХЯ-ны

Шинжлэх Ухаан, Технологийн Зөвлөлд хүлээлгэн өгсөн. Уг төслийн ажилд Монгол Улсын агаарын хил, орон зайг хянах нэгдсэн тогтолцоог бий болгох гарц, гаргалгааг тусгаж өгсөн билээ. Уг төслийн ажилд тусгаснаар: Агаарын цэргийн хөгжлийн нэг үндсэн чиглэл нь Монгол Улсын агаарын хил, орон зайн хяналтын тогтолцоог төгөлдөржүүлэх явдал юм. Энэ хүрээнд Агаарын цэргийн удирдлагын автоматжуулсан нэгдсэн тогтолцоог бий болгож бүх шатны удирдах байруудыг автоматжуулах хэрэгслээр хангах, программ хангамжийг нэвтрүүлэх шаардлагатай байгаа юм. Үүнийг хэрэгжүүлэх дараах арга замуудыг харж байна.

**Нэгдүгээрт:** Агаарын цэргийн зэвсэглэл, техникийн шинэчлэл хийхэд 2,7-3,6 хилнайд төгрөг (2017 оны 11 сарын 07-ны өдрийн Монгол банкны валютын ханшаар тооцов.)-ийн хөрөнгө оруулах асуудлыг шийдвэрлүүлж агаарын орон зайн хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгох;

**Хоёрдугаарт:** ИНЕГ-ын нислэгийн хөдөлгөөнийг удирдах төвийн 1-2 ажлын байрыг Агаарын цэргийн удирдлагын төвд байрлуулах /60000-150000 ам.доллар/.

**Гуравдугаарт:** Монгол Улс, Оросын Холбооны Улсын Цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын “Алмаз-Антей” концернтай гэрээ байгуулж, “Монгол Улсын агаарын орон зайн хяналтын нэгдсэн сүлжээ” төслийг хэрэгжүүлэх.

Радиотехникийн анги, салбарын зэвсэглэл, техникийн шинэчлэлийг нэн даруй хийх чухлыг Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойн босгон дээр хийгдэж буй эрдэм шинжилгээний хуралд тэмдэглэж байна.




Агаарын Цэргийн зэвсэглэл, техникийн шинэчлэлийг өндөр өртөгтэй байдгийг анхаарч улс орны эрх ашгийн үүднээс асуудлыг шийдвэрлэхийг зөвлөж байна.

**II асуудал.** Монгол Улсын Засгийн Газар, төрийн захиргааны төв байгууллага болох яамнууд, хэрэгжүүлэгч агентлагийн төрийн албаны туршлагаас авч үзэхэд шинжлэх ухааны үндэслэлтэй баримт бичиг боловсруулах, урьдчилсан тооцоо, судалгаа гаргах, хэтийн үйл ажиллагааг төлөвлөх үйлсэд эрдэмтэн судлаачдын баг ажиллуулдаг болжээ.

Өнөөдрийн байдлаар судалж үзэхэд Агаарын Цэргийн хүрээнд нийт 9 эрдэмтэн /Б.Эрдэнэбат, Ч.Улаанхүү, Ч.Баттулга, Л.Болдбаатар, Т.Энхбат, Б.Далайбаатар, Н.Энхбат, Ч.Болдбаатар, Ц.Дунгармаа/ байгаагаас техникийн ухаанаар 3, цэргийн ухаанаар 6 байна. Эдгээрээс 4 нь ОХУ-ын цэргийн академи, их сургуульд эрдмийн зэрэг хамгаалсан бол 5 нь дотооддоо ҮБХИС-д эрдмийн зэрэг хамгаалжээ. Агаарын цэргийн эрдэмтдийн анхдагч болох хуучнаар ЗХУ-д дэд эрдэмтэн болж улмаар БНУУ-д шинжлэх ухааны доктор цол хамгаалсан хошууч генерал Ц.Генадийг энд хүндэтгэн тэмдэглэж байна.

Агаарын Цэргийн Командлалын эрдэмтдийн зөвлөл нь 11-13 хүнтэй байж байнгын ажиллагаатай 2-3 эрдэмтэн, судлаач командлалын дэргэд дараах бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг баримтлан ажиллана гэж харж байна.

**Агаарын Цэргийн дэргэдэх эрдэмтдийн зөвлөлийн бүтэц /Хувилбар/**



**Агаарын Цэргийн дэргэдэх эрдэмтдийн зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл**

1. Төрийн цэргийн бодлогын хүрээнд боловсруулагдах баримт бичигт мэргэжлийн дүгнэлт, урьдчилсан прогноз гаргахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
2. Батлан хамгаалах салбарын хүрээнд Агаарын цэргийн бодлогын баримт бичиг боловсруулахад санал, дүгнэлт гаргах;
3. Гадаад улс орнуудын Агаарын цэргийн зэвсэглэл, техникийн хөгжил, техник технологийн өөрчлөлтөд судалгаа хийх;
4. Агаарын Цэргийн Командлалын баримт бичиг боловсруулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
5. Агаарын Цэргийн урлагийг хөгжүүлэх, мэргэжилтэн бэлтгэх, сурган дадлагажуулах үйлсэд шаардлагатай дүрэм, заавар, ном, гарын авлага боловсруулахад оролцох, дэмжлэг үзүүлэх эдгээр болно.

Агаарын цэрэг, Радиотехникийн анги, байгууллагын хөгжлийн чиг хандлагын асуудлаар санал, зөвлөмж дэвшүүлсэн дээрх өгүүллээс дараах дүгнэлтийг гаргаж байна.

**ДҮГНЭЛТ**

1. Өндөр өртөг, зардлаар оршин тогтнодог тус төрлийн цэргийн онцлогтой уялдуулан Агаарын Цэргийн хөгжлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөт арга хэмжээг зоосны нүхээр харж ашиг, орлого олохоос илүү Монгол Улсын агаарын хил, агаарын орон зайн хяналт шаардлагын түвшинд байж, нийслэл хотыг агаарын довтолгооноос хамгаалж, халхлах, сөнөөгч онгоцны баталгаат халхлалт бий болох үндэс суурь тавигдана гэж харах нь зүйтэй байна.

2. ИНЕГ-ын нислэгийн хөдөлгөөнийг удирдах төвийн 1-2 ажлын байрыг Агаарын цэргийн удирдлагын төвд байрлуулах /60000-150000 ам.доллар/ ажлыг хэрэгжүүлснээр агаарын цэргийн



байдлын тухай мэдээллийг бодит цагаар боловсруулж, шийдвэр гаргах боломж бүрдэнэ.

3. Монгол Улс, Оросын Холбооны Улсын Цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын "Алмаз-Антей" концернтой гэрээ байгуулж "Монгол Улсын агаарын орон зайн хяналтын нэгдсэн сүлжээ" төслийг хэрэгжүүлснээр шинжлэх ухааны

үндэслэлтэй, ойрын 30 жилийн хугацаанд ашиглах боломжтой техник технологийн шинэчлэлд тулгуурласан техник, хэрэгсэлтэй болох юм.

Цэргийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх үүргийн хүрээнд Агаарын Цэргийн Командлал дэргэдээ Эрдэмтдийн зөвлөл байгуулан ажиллах нь зүйтэй юм.

#### **Ашигласан материал:**

1. Ц.Дашзэвэг, Ш.Паламдорж "Цэргийн нэр томъёоны тайлбар толь". БХЭШХ.УБ.,2014
2. "Агаарын цэргийг хөгжүүлэх стратеги" төслийн тайлан.ҮБХИС.УБ.,2007
3. Н.Энхбат "Агаарын Цэргийг хэрэглэх онол практикийн зарим асуудал". ҮБХИС.УБ.,2018



## ОХУ-ЫН УКРАЙН УЛСАД ЯВУУЛЖ БУЙ ЦЭРГИЙН ТУСГАЙ АЖИЛЛАГАА (ЦТА)-НЫ ЦЭРГИЙН СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ТАЛААРХ ШИНЖИЛГЭЭ

**Б.БААТАРСҮРЭН** /БХЭШХ-ийн БХДШТөвийн ЭШАА, доктор(Ph.D)/

**Түлхүүр үг:** ОХУ, Украин улс, цэргийн сургалт бэлтгэл, шинжилгээ

**Key words:** Russia, Ukraine, Military training, Analyze

**Оршил.** ОХУ-ын БХЯ-ны зүгээс цэргийн хүний нөөцийг бэлтгэх, дайчилгааны тогтолцоог шинэчлэх талаар олон ажлуудыг төлөвлөн явуулж байна. Цэргийн тойрог тус бүрийн хариуцлагын бүсэд байрлах энгийн их дээд сургуулийг түшиглэн явуулж буй цэргийн сургалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг сургах юм. Ингэснээр оросын байнгын арми, бэлтгэл хүчин, цэрэг-стратегийн болон батлан хамгаалах аж үйлдвэрт ажиллах, цэргийн хэргийн мэдлэгтэй хүний нөөц үлэмж хэмжээгээр өсөх тооцоо гарч байна<sup>1</sup>.

Харин тус улсын Украин улсад явуулж буй цэргийн тусгай ажиллагааны сургалт бэлтгэлийн талаар зөв эх сурвалжаас үнэн бодитой мэдээлэл олох боломж хомс байгаа тул энэ удаад Украин улсын Зэвсэгт хүчний энэхүү ажиллагаанд хэрхэн сургалт бэлтгэл ханган оролцож байгааг энэ өгүүллээр хөндөхийг зорилоо.

**Үндсэн хэсэг.** ОХУ дайн эхлэхээс өмнө хөрш Беларусьтай хамтарсан цэргийн сургуулилт хийх шалтгаанаар 30 мянган цэрэг Беларусьт байрлуулсан байдаг. Тэр үедээ 100 мянган нэмэлт цэргүүдийг Украинтай залгасан хил дээрээ байршуулж, Беларусьт зөвхөн цэргээс гадна тусгай хүчний цэргүүд, сөнөөгч онгоц, пуужин, агаарын довтолгооноос хамгаалах систем зэрэг эд ангиудыг Украины хилийн ойролцоо байрлуулсны эцэст 2-р сарын 24-нд халдан довтолсон.

Дайн эхлэхэд Кремлийн зүгээс

дайралт биш цэргийн тусгай ажиллагаа учир шинэ цэргүүдийг байлдаанд оролцуулахгүй гэсэн байр суурьтай байсан бол 3-р сарын 9-ний өдөр шинэ цэргүүдийг байлдуулж зарим нь Украины Зэвсэгт хүчинд олзлогдсон байсан нь мэдэгдсэн. Үүнээс гадна 3-р сарын 31-ний өдөр нэмэлт 134 мянган шинэ цэрэг цэрэгт татагджээ.

Хэвлэлийн байгууллагуудын мэдээлснээр нэг удаад 100 шинэ цэргүүдийг хүчээр элсүүлж, Украинд байлдахаар явуулахад тэдний 4 нь амьд үлджээ. Өөр тохиолдолд Мариупольд байлдахаар явуулсан 135 шинэ цэрэг зэвсгээ газар тавьж байлдахгүй гэдгээ илэрхийлэхэд командлагч нар нь зоорьт хийж сүрдүүлж байсан нь бүртгэгдсэн байна. Үүнээс гадна бусад улсад цэргийн алба хаасан Оросын иргэншил хүлээн авсан иргэдийг цэргийн албанд татаж, үүрэг гүйцэтгэхийг татгалзсан иргэдийн иргэншлийг нь хасаж байгаа юм байна.

ОХУ-ын 2014 оны довтолгоонд Крым болон Донбассын зарим хэсгийг алдсаны дараа АНУ болон НАТО-гийн бусад орнууд Украины Зэвсэгт хүчнийг сургахад туслах ажилтнуудаа илгээсэн байдаг. Зарим судлаачдын хэлж байгаагаар Украины амжилт нь энэхүү байнгын бэлтгэл, сургалтын үр дүнг харуулж байна. Мөн олон тооны сайн дурын ажилтнууд Украины цэргүүдийг газар дээр нь сургахад тусалсаар байна. Тэдний ихэнх нь тэтгэвэр чөлөөнд гарсан ЦАХ байна.

Украинчуудын хувьд олон шинжээчид нь саяхныг болтол

<sup>1</sup> Статья 49. Предельный возраст пребывания на военной службе. 2. Для военнослужащих женского пола предельный возраст пребывания на военной службе устанавливается 45 лет.



Зөвлөлтийн сургаалын дарамтад орсон арми дээр анхаарлаа хандуулж ирсэн. Төрөл бүрийн нийтлэлүүд нь ЗХУ (хуучнаар)-ын туршлагаар гүнзгийрсэн Украины армийг дүрсэлсэн байдаг. 1990-ээд онд Украины армид хийсэн шинэчлэл мөн шинэчлэлийн дараа Украинчууд өөрсдөө гаргасан шийдвэрүүд нь 2014 онд сүйрэлд хүргэсэн гэж зарим шинжээчид үздэг. Учир нь 1991-2014 оны хооронд Украины армийн бүхий л хүчин чадал буурч, байлдааны хүчний хувьд бараг байхгүй болтол нь нөөцийг системтэйгээр дээрэмдэж байсан. 1991 онд Украины арми 800 000 орчим алба хаагч, олон мянган хуягт машин, танктай мөн 2500 цөмийн зэвсэгтэй, олон зуун онгоц, бөмбөгдөгч онгоцтой хүчирхэг агаарын хүчинтэй байлаа. Харин 1993 онд цөмийн зэвсгийг Их Британи, АНУ, ОХУ Украины нутаг дэвсгэрийн бүрэн эрхт байдлын баталгааны хариуд ОХУ-д өгсөн (1994 оны Будапешт меморандумаар албан ёсоор батлагдсан, одоо үнэ цэнгүй болсон). Цөмийн зэвсгийг устгасны дараа бусад зүйлс ч мөн адил илүүц мэт санагдсан. Агаарын цэргийн хүчин, ялангуяа бөмбөгдөгч онгоц, том арми, танк, агаарын довтолгооноос хамгаалах боловсронгуй систем гэх мэт. Мөн Украин эдийн засгийн хямралтай тулж, ДНБ нь бараг тал хувиар уналтад орсон. Ингээд л Зэвсэгт хүчнээс үлдсэн зүйл нь авлигад зарцуулагдсан. 2014 оны 3-р сард Украины арми дахь албан ёсны нийт цэрэг, офицеруудын тоо, техник хэрэгслийн хувьд "байлдааны бэлэн байдалтай" ердөө гурван бригад, 7000 цэрэг байсан байна<sup>2</sup>. Тухайлбал, 2016 онд 800 танкаас арваад нь ажиллагаатай, арваад нь жагсаалд ашиглагддаг байсан ба үлдсэн хэсгийг нь хээрийн дадлага сургуульд ашиглахын тулд эрс шинэчлэл хийх шаардлагатай байсны улмаас бүрэн бүтэн болгохын тулд сэлбэг хэрэгсэлд ашигладаг байжээ.

Мөн цэргийн болон тагнуулын

байгууллагуудыг Виктор Януковичийн удирдлаган дор Оросыг дэмжигч офицер, удирдагчид ажиллуулж, Оросын эсрэг ашиглах үед байлдааны хүчийг улам бүр багасгасан. Урвагчид урвасан нь 2014 онд Украины хувьд маш том асуудал болж, зарим нэг хэсэг нь шууд Орос руу урвасан байдаг<sup>3</sup>.

Дүгнэж хэлэхэд, 2014 оны 3-р сард Украины ашиглах боломжтой арми нь гурван бригадын 7000 орчим цэрэг, арваад танк, цөөхөн хэдэн нисэх онгоцноос бүрдсэн бөгөөд ихэнх нэгжүүд тулалдаж чадахгүй байсан бөгөөд тэдний олон удирдагчид тулалддаггүй буюу нөгөө талын төлөө тулалдаж байв. Украины армийн сул талыг Оросын тагнуул сайн мэддэг байсан бөгөөд тэр үед Кремль түрэмгийлэхээр шийдсэн нь энэ сул талыг мэдэж, барууныхан хөндлөнгөөс оролцохгүй гэсэн тооцоотой бөгөөд зөв мөрийтэй тоглоомын хослолд үндэслэсэн байв. Гэвч анхны ялагдал нь Украинд шууд сургамж авчирсан. Украины цэрэг, офицерууд бусдаас суралцаж, тусламж аван, туршлага, сургамж хуримтлуулж байсан бөгөөд үүнийгээ ашиглаж чадсан юм. 7000 орчим цэргийн алба хаагчаас бүрдсэн ЗХ-ээс 4, 5-р сар хүртэл арми хурдан өргөжин тэлж, хэдэн арван мянган Украинчууд цэрэгт татагдаж, дайчлагдан, сайн дураараа нэгдэж, тулалдсан. Энэ бүлэгт 40-50 насны Улаан армийн ахмад дайчид багтсан бөгөөд тэдний зарим нь Афганистанд ЗХУ-ын довтолгоонд оролцсон ахмад дайчид байв. Үүнд нийгмийн бүх давхаргын украинчуудын урам зоригтой төлөөлөл багтсан байдаг.

Украин улсын хувьд дээрхээс ямар сургамж аваад одоогийн байлдаанд хэрхэн оролцож байна вэ? гэсэн асуулыг дүгнэн үзвэл: Украин улс авсан сургамж нь Оросын их бууны хүрэн дэх задгай талбайд анги нэгтгэл цуглуулахгүй байх явдал байв. Тус улсын анги нэгтгэлүүд их бууны байнгын галын дор Оросын цэрэг, Оросын хөлсний цэргүүдтэй

<sup>2</sup> <https://foreignpolicy.com/2022/05/09/ukraine-military-2014-russia-us-training/>

<sup>3</sup> <https://www.axios.com/2022/05/05/pentagon-details-us-training-of-ukrainian-forces>



тулалдаж байсан. Тиймээс одоогийн Украйны Зэвсэгт хүчин цаасан дээрх хүчин чадлаа дүүргэж, өргөжин тэлэхийн хэрээр шинэлэг, идэвхтэй арга барилаар ажиллаж байна.

Мөн тус улс нь мэргэжлийн ҮАБЗ-ийг байгуулснаар тодорхой амжилтад хүрсэн гэж дүгнэж болохоор байна. Украйны нэгэн генерал хэлсэн үгэндээ: "Манай улсын Зэвсэгт хүчин АНУ-ын цэргийн хүчний үнэлгээ болон НАТО-гийн стандартад хараахан хүрч чадаагүй байгаа ч байлдааны талбарт амжилт гаргасан нь Украйны давуу тал... " болохыг тодотгосон байна<sup>4</sup>.

Оросууд халдан довтолж вий гэсэн болгоомжлолын улмаас Киев хотын захад иргэд өөрийгөө хамгаалах сургалтыг сайн дурынхан ба хуучин цэргийн алба хаагчидтай нэгдэн зохион байгуулж байна. Тэд зэвсэгтэй харьцах, анхны тусламж үзүүлэх арга барилд суралцан өөрсдийгөө болон хайртай хүмүүсээ хэрхэн хамгаалах тухай анхан шатны мэдлэг олж авч байна. Мөн Оросын довтолгоо хоёр дахь сардаа орж байхад Израйлийн хэсэг командлагч нар Украйны баруун нутгийн нэгэн нууц объектод Украйны энгийн иргэдийг сургаж байна гэсэн мэдээлэл байна. Тус сургалтын хөтөлбөр нь Израйлийн Засгийн газраас зөвшөөрөгдөөгүй ч улс төрийн дээд түвшний хүмүүс сургалтын талаар мэдэж байгаа ч нүдээ аниад өнгөрч байгаа ба энэ байгууламжийг Оросын тагнуулынхан илрүүлж магадгүй гэсэн болгоомжлолын улмаас яг хаана байгааг мэдээлээгүй байна. Дадлагажигчдад Украйны эрэгтэй, эмэгтэй энгийн иргэд багтаж байгаа бөгөөд тэдний ихэнх нь хэзээ ч цэргийн бэлтгэл хийж байгаагүй. Зарим нь өмнө нь цэргийн алба хааж байсан эсвэл хоббигоор буудаж байсан бага зэрэг туршлагатай хүмүүс байгаа аж. "Улс орон бүхэлдээ маш богино хугацаанд дайн хийхээр дахин зохион байгуулалтад орсон. Бид тэдний

өөрчлөгдөж байгааг харж байна" хэмээн хөтөлбөрийг хариуцаж байсан Израйлийн сургагч хэлжээ. Тэрээр Оросын цэргүүд довтолсон цагаас хойш Украйнд очиж тусламж үзүүлэх нь өөрийн үүрэг хариуцлага байсан гэдгээ онцлон тэмдэглэжээ<sup>5</sup>. Израйлийн зүгээс Украйнд ямар нэгэн цэргийн техник, тэр байтугай хамгаалалтын хэрэгслээр хангахаас татгалзаж буй ч Оросын армийг эсэргүүцэх зорилгоор идэвхтэй сургаж байгаа нь харагдаж байна. Мөн нэрээ нууцалсан албаны хүн "Бид бүгд Оросын хамгийн аймшигтай түрэмгийлэлд өртсөн Украйны иргэдийг дэмжиж, эв санааны нэгдэлтэй байна" гэсэн бол сургалтын хөтөлбөрт оролцсон Израйлчууд "Оросын түрэмгийлэл удахгүй дуусна гэдэгт итгэхгүй байна... Украйнд болж буй тулалдаан нь илүү том аюул заналхийлж байгааг харуулж байна... Бид зөвхөн Украйны төлөө бус өөрсдийнхөө төлөө тэмцэж байна... Хэрэв Украйн унавал ардчиллыг эсэргүүцэгчид толгойгоо өндийлгөж, энэ нь дэлхий даяарх хорлонт хүчнийг өдөөж, Путин тэдэнд туслахыг хүсэх болно" гэжээ<sup>6</sup>.

Канад улсын хувьд шуурхай ажиллагааны бригадыг хот доторх дайн, хээрийн тактик, байлдааны талбарын анагаах ухааны чиглэлээр сургасан байдаг. Украйны баруун хэсэгт болсон сургуулилт нь Канад, Их Британи, Румын, Калифорнийн Үндэсний гвардийн цэргүүд оролцсон сүүлийн жилүүдэд хийсэн олон сургуулилтүүдийн нэг байв. Энэ бол Украйны түргэн байрлах хүчин илүү том, илүү сайн тоноглогдсон түрэмгийлэгч армиас өөрсдийгөө хамгаалж, дэлхийг гайхшируулж байгаагийн нэг том шалтгаан гэж Украйнууд болон тэдний барууны зөвлөхүүд үзэж байна. Найман жил гаруй хугацаанд жил бүр 10 000-аас доошгүй цэрэг оролцуулсан хичээл, дадлага, сургуулилтаар НАТО болон

<sup>4</sup> 'No other option': Israeli ex-commandos said to secretly train Ukrainian civilians | The Times of Israel

<sup>5</sup> <https://www.nytimes.com/2021/12/26/world/europe/ukraine-russia-civilian-training.html>

<sup>6</sup> Мөн тэнд



түүний гишүүд Зөвлөлт маягийн хатуу командлалын хэв маягаас цэргүүдийг хөдөлж байхдаа сэтгэж чаддаг байдалд сургадаг барууны стандарт руу шилжихэд тусалсан гэж үзэж болно.

Үндэсний гвардын дэслэгч Андрей Кулиш Канад улсад талархаж байгаагаа онцлоод өөрийн зэвсэгт нөхдүүд нь "НАТО-той хийсэн сургуулилтаар сурсан арга барилаа ашиглаж байгаа нь гарцаагүй" гэжээ<sup>7</sup>. Цэргийн сургуулилын үеэр Украйны цэргийн алба хаагчид маш өргөн хүрээтэйгээр оролцож, НАТО-гийн найман орон оролцсон ч практик сургалтын ихэнх хэсгийг Украйны багш нар удирдан явуулж байгаа нь ажиглагдсан байна. Энэ нь Украйн улсын Зэвсэгт хүчин НАТО-гийн сургалтын стандарт, арга зүйг нутагшуулан олон жилийн турш үзүүлсэн дэмжлэг, тусламжийн үр дүнг ашигтайгаар хэрэгжүүлж байгаа туршлага юм гэж үзэж болохоор байна. НАТО-гийн Украйн дахь сургуулилт нь Барууны Ирак, Афганистанд явуулсан ажиллагаанаас илүү амжилттай байсан гэж зарим ажиглагчид үзжээ. Тухайлбал, зөвлөхүүд Украйны хүнд суртлаар дэмжигдэн хүлээн зөвшөөрөгдсөн үр ашиг муутай Засгийн газар нь авлига хээл хахуульд нэрвэгдсэн ч, харьцангуй эв нэгдэлтэй нийгэм, нэгдмэл төрийг бүрдүүлсэн хэвээр байгаа гэж үзсэн байна.

Сайн үйлсийн төлөө тууштай ажилладаг Украйны ТББ "Өөрийгөө Хамгаалах Сургалтын Төв (Self-Defense Training Center)-д улс орон даяар энгийн иргэд зэвсэг барьж, эх орноо хамгаалахаар зориг шулуудсан үед Америкийн цөөн ахмад дайчидтай хамтран энгийн иргэд болон сонсогч нарыг байлдааны ажиллагаанд сургахын тулд хөтөлбөр хэрэгжүүлж байна. Анхны сургагч багш нарын нэг болох Афганистанд хоёр ч удаа үүрэг гүйцэтгэсэн армийн ахмад Адриан Боненбергер "Тэнд бэлтгэл хийж байгаа бүх хүмүүс сайн дурын

ажилтан. Бидний хийж буй бүх зүйл бол барууны армийн илэрхийлсэн ардчилсан, тэгш эрхт зарчимд суурилсан хүмүүсийг сургах явдал юм" гэжээ. Стандарт сургалт нь 2-4 долоо хоног үргэлжилдэг бөгөөд гол зорилго нь "хамгаалах үндсэн тактик, анхны тусламж үзүүлэх, зэвсэгтэй харьцах, онох чадвар, байлдааны хохирогчдод тактикийн тусламж үзүүлэх, байлдааны сургуулилт, аман болон аман бус харилцаа холбоо, гардан болон хот суурин газрын байлдааны арга техникээс эхлэн манлайллын чадвар..."<sup>8</sup> зэргийг эзэмшүүлэхэд чиглэж байна. Тус хөтөлбөрийг судалсан сонсогчид нь энгийн иргэдээс бүрдсэн Нутаг дэвсгэрийн хамгаалалтын хүчинд элсэх эсвэл Украйны армид татагдан орох боломжтой юм байна.

### ДҮГНЭЛТ

1990-ээд оноос зэвсэг техник, хүний нөөцөө алдсан Украйн улсын Зэвсэгт хүчин 2014 оны ОХУ-ын довтолгооноос их олон зүйл дээр туршлагажин Зэвсэгт хүчиндээ эрс шинэчлэл хийж, НАТО-гийн стандартын сургалт, бэлтгэлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж иржээ. 2022 оны ОХУ-ын "Цэргийн тусгай ажиллагаа"-нд тэд барууны орнуудын зэвсэг техникийн дэмжлэгээс гадна ард түмний эв нэгдэл, нэгдмэл байдал, эх оронч сэтгэлгээгээр "Намайг дайнд дуудах үед би бэлэн байх болно" гэсэн зорилготойгоор эх орноо хамгаалж байна. НАТО-гийн стандартын хөтөлбөрөөс гадна Израйль, Канад зэрэг улсуудын дэмжлэгтэйгээр мөн ТББ-уудын оролцоотойгоор орон нутгийн хамгаалалтыг хөгжүүлж байна гэж үзэж болохоор байна. Учир нь эдгээр сургалт, бэлтгэл нь дайнд хэрхэн биеэ авч явах, зэвсэг хэрэглэх, тактикийн хувьд хэрхэн хөдлөх, бүлгийг хэрхэн удирдах, их буугаар буудах үед хэрхэн биеэ авч явах, тагнуул, отолт хийх, газрын навигаци, дайсны тээврийн хэрэгслийг таних, ОУ-ын хүмүүнлэгийн

<sup>7</sup> The Secret of Ukraine's Military Success: Years of NATO Training - WSJ

<sup>8</sup> Jeremy Krypt "Former U.S. special forces commandos are on the ground in Ukraine teaching guerrilla war tactics to civilians ready to repel invading forces from Russia", May 30, 2022.



эрх зүйн талаарх мэдлэг олгох зэрэг практик ур чадвар эзэмшүүлэхээс гадна хамгийн чухал зүйл болох сэтгэл зүйг бэлтгэн айдсыг бууруулж, байлдааны талбарт орохдоо юу хийхээ мэддэг чадвар, дадлыг олгож байна.

Украин улсын хувьд цэргийн алба хаагчид нь дайн эхэлтэл улсын баруун хэсэгт байрлах Лвив хотод бэлтгэл сургуулилтаа хангаж байсан. Харин тэднийг АНУ-ын Армийн үндэсний гвардын 53-р бригад энэ оны 1-р сар хүртэл бэлтгэсэн. 2014 оноос хойш тэд Украины нийт 23 мянган цэргийг бэлтгэсэн байна. Харин энэ оны 2-р сард ХБНГУ руу шилжин Украин цэргүүдийг янз бүрийн НАТО-гийн зэвсгүүдтэй танилцуулж бэлтгэж эхэлсэн.

Тэдний бэлтгэлд танкны эсрэг байлдах хэрэгсэл, арга барил, нэмээд хамгийн чухал нь чадвартай ахлагчдыг бүрдүүлэх зорилготой хөтөлбөрөөр хангажээ. АНУ-ын зүгээс чадварлаг ахлагчидтай байхад байлдааны үед шийдвэр гаргах чадвартай ажиллана гэдэгт итгэж байгаагаа илэрхийлсэн.

Их Британий Зэвсэгт хүчний хувиас эх орондоо цөөн хэмжээний Украин цэргүүдийг нууц байршилд бэлтгэж, Польш улсад бас Украин цэргүүд бэлтгэж байгаа юм байна. 2014 онд ОХУ Украины Крымийн хойгийг эзэлснээс шалтгаалан Их Британи улс цэргийн мэдлэг, зэвсэг тоноглол, бэлтгэлээр Украин цэргүүдийг хангаж одоог хүртэл 22 мянган цэрэг бэлтгэсэн

байна. Үүнээс гадна Их Британийн дэмжлэгээр 120 хоног бүр 10 мянган цэрэг бэлтгэх боломжтой сургуулилын үйл ажиллагаа эхлүүлэхээ мэдэгдсэн. Тиймээс Украины Зэвсэгт хүчний баруунаас авч буй дэмжлэг нь одоо 4 дэхь сардаа үргэлжилж буй энэхүү дайнд ялалт байгуулах магадлалыг нэмэгдүүлж байна.

АНУ-аас Украинд зөвхөн Зэвсэгт хүчний тусламжаар 20 тэрбум ам.доллар зарцуулж, өөр олон улсаас бүх төрлийн зэвсэг хэрэгсэл авснаар Украины зэвсэгт хүчин технологийн давуу тал, барууны дэмжлэгээр одоог хүртэл тэмцээр байна.

ОХУ-ын хувьд дайн эхлэхийн өмнөх өдөр буюу 2-р сарын 23-ны өдөр ОХУ-ын Арми 168 батальонтой байсан. Нэг батальон 800 орчим цэрэг, 50 орчим хуягт тээврийн хэрэгслүүдээс бүрддэг. Украины довтолгоонд ОХУ Армийнхаа 125 батальоныг идэвхжүүлсэн бол дайн эхэлснээс 3 сарын дараа 4100 тээврийн хэрэгсэл, 15 мянга орчим цэргийн амийг тасалж түүнээс хэд дахин их тооны цэргүүдийг гэмтээсэн гэдгийг мэдээлсэн. Энэ эрчээр алдагдал хүлээх юм бол бэлтгэл хангах төвөөсөө батальон бүрдүүлж байлдуулах хэрэг гарна. Хэрвээ тэгэх юм бол шинэ цэргүүд бэлтгэх мэргэжлийн хүмүүсээ алдаж, Зэвсэгт хүчнээ сэргээх чадвараа алдах магадлал өндөр байна.

### Ашигласан материал:

1. [https://www.army.mil/article/256277/us\\_troops\\_train\\_ukrainians\\_in\\_germany](https://www.army.mil/article/256277/us_troops_train_ukrainians_in_germany)
2. <https://www.nytimes.com/interactive/2022/05/20/upshot/ukraine-us-aid-size.html>
3. <https://www.gov.uk/government/news/uk-to-offer-major-training-programme-for-ukrainian-forces-as-prime-minister-hails-their-victorious-determination>
4. <https://www.forbes.com/sites/davidaxe/2022/05/28/to-replenish-its-army-in-ukraine-russia-plans-to-strip-its-training-units-it-can-only-do-this-once/?sh=6907eccda98f>
5. <https://www.cnbc.com/2022/02/10/russia-set-to-begin-massive-military-drills-with-belarus.html>
6. <https://www.dw.com/en/ukrainian-troops-get-training-in-germany/a-61682712>
7. <https://www.defense.gov/News/News-Stories/Article/Article/3020199/dod-leaders-say-training-ukrainian-forces-is-paying-dividends/>
8. <https://ge.usembassy.gov/russia-uses-conscript-soldiers-for-war-in-ukraine/>



## ТОГТВОРЖУУЛАХ БОДЛОГЫН ОНОЛ, ЗАГВАРЧЛАЛ

**Д.ЭНХЧИМЭГ** /ЭШИХ-ийн ЭШ-ний мэргэжилтэн, доктор (Ph.D), дэд профессор/  
**Т.МӨНХ-ОРГИЛ** /БХЭШХ-ийн ЭДОУСТ-ийн дарга, доктор (Ph.D), дэд хурандаа/  
**Д.НЯМХҮҮ** /ҮБХИС-ийн АБДС-ийн ЭЗМТ-ийн багш, докторант/

**Түлхүүр үг:** Бодлого, онол, загварчлал, шинжилгээ

**Key words:** Policy, theory, modeling and analysis


### Макро эдийн засгийн онолын түүхэн хувьсал

Дэлхийн эдийн засагт гарч буй өөрчлөлт, хувьслыг даган макро эдийн засгийн онол, сэтгэлгээний хөгжилд томоохон ахиц дэвшил гарсаар байна. Энэ чиглэлийн гол эх сурвалжаас дурьдвал Ж.Гали болон М.Гертлер /2007 он/, О.Бланчард /2009 он/, С.Фукак болон А.Паган /2009 он/ нар макро эдийн загварчлалын хөгжлийн процесст хувьсал, хувиран өөрчлөлт гарч байгааг онцолдог.

### Эдийн засгийн загварчлалын хөгжил, чиг хандлага

Загварчлал, шинжилгээ нь эдийн засгийг шинжлэх ухаан болгодог

хэмээн Д.Родрик (2015) “Эдийн засгийн дүрмүүд” номдоо онцолсон байдаг<sup>1</sup>. “Эдийн засаг нь нэг талаас эдийн засгийн үйл ажиллагааг ойлгох боломж олгодог нийгмийн ухааны салбар, нөгөө талаас нийгмийн шинжлэх ухааны судалгааны нэг арга зүй юм. Ялангуяа, эдийн засгийн загварчлал, статистик шинжилгээ нь эдийн засгийг нийгмийн шинжлэх ухааны салбарт хамаатуулах эмпирик арга зүй бөгөөд оновчтой шийдвэр гаргах суурь нөхцөлийг бүрдүүлж иржээ. Улс орнуудад яг ижил бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ч өөр өөр үр дүнд хүрч болох тул эдийн засгийн загвар нь тухайн зах зээл, нийгмийн



<sup>1</sup> Эдийн засгийн загварууд, тэдгээрийн онцлог шинжүүд, эдийн засгийн загварчлалын "шинжлэх ухаан", эдийн засгийн онол, загвар хоорондын уялдааны талаарх суурь ойлголтыг сонирхолтой хэлбэрээр Д.Родрик (2015) тайлбарласан.



нөхцөл байдал, байгаль орчин, цаг хугацааны аль үеийг хамаарч байгаа зэргээс шалтгаалан харилцан адилгүй байдаг. Иймд улс орны онцлогийг тусгасан, бодлогын шийдвэр гаргалтад туслах эмпирик загвар, аргачлалыг боловсруулж ашиглах нь тухайн эдийн засаг, нийгмийн амьдралыг ойлгох, түүнийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг бодитоор тодорхойлох боломж олгодог. Аливаа эдийн засгийн загвар нь шинжлэх ухаан “математик, статистик, эконометрик гэх мэт)-д суурилсан “хийсвэр” илэрхийлэл тул бодит байдалд бүрэн дүүрэн нийцэх, төгс үнэн төсөөлөл гаргах боломж хязгаарлагдмал боловч, бидэнд өнгөрсөн хугацааны ажиглалтад суурилан ирээдүйн талаарх харилцан нийцтэй “боломжит сайн” мэдээллийг гаргаж өгөхөд тусалдаг. Үүний зэрэгцээ загварууд нь өөрийн гэсэн онцлогтой, ялгаатай таамаглалуудад суурилдаг тул эдийн засгийн оношилгоо, бодлогын шинжилгээнд тэдгээрийг хослуулан ашиглах нь илүү чухал юм<sup>2</sup>.

### **Макро эдийн засгийн загварууд, тэдгээрийн онцлог**

Сүүлийн жилүүдэд макро эдийн засгийн шинжилгээнд өргөн ашиглагдаж байгаа загваруудыг суурь болгон ашигласан бөгөөд тэдгээрийн онцлог, түүхэн хөгжлийн талаар авч үзье. Вектор авторегресс (VAR) загвар нь макро эдийн засгийн судалгааны нэг чухал төсөөлөл гаргахад өргөн ашиглагдах арга болж хөгжин, бүтцийн шинжилгээ болсон.

К.Симс (1980) хуурмаг эсвэл буруу хязгаарлалттай загвар хөгжүүлэхээс зайлсхийхийн тулд бүх хувьсагчид нь эхний алхам дээр эндоген байх, аливаа хязгаарлалтгүй (VAR) загварыг санал болгосон. Ингэснээр “бодлого нь эдийн засагт нөлөөлөх, эргээд эдийн засаг нь бодлогод нөлөөлөх”

буцах холбоог оруулж загварчилсан тул бодлогын нөлөөг зөв тооцох боломж олгоно. Хязгаарлалтгүй VAR загварын классик эконометрик үнэлгээ нь нийцтэй бөгөөд үлдэгдэл нь нормаль тархалттай үед үр ашигтай үнэлгээ өгдөг. Бодлогын шинжилгээ нь энэ аргын хоёрдугаар үе шатанд хүчин зүйлсийн цочрол өөрчлөлтийг таних байдлаар хийгдэнэ. Энэ үүднээсээ VAR загварууд нь тоон өгөгдөлд байгаа мэдээллүүдийг нэгтгэх буюу хувьсагчдын хоорондын хамаарлыг гаргах, бодлогын шинжилгээ хийхэд тохиромжтой арга зүй юм гэдгийг К.Симс /1980/ анх гаргасан. VAR хандлагыг ашиглан бүтцийн шинжилгээ хийхийн тулд бүтцийн VAR (SVAR) загварыг санал болгодог. VAR нь тоон өгөгдөлд байгаа мэдээллийг нэгтгэх байдлаар үнэлж, үүний дараа SVAR нь хүчин зүйлсийн цочрол өөрчлөлтийг таних байдлаар тоон өгөгдөлд тайлбар өгөх боломж олгоно.

Шинэ Кейнсийн DSGE загварууд нь өнөөдрийн макро эдийн засгийн загварчлалын хөгжлийн гол илэрхийлэл болж байна. Загвар нь микро суурь бүтэцтэй, олон хүчин зүйлсийг оруулсан, мөчлөгийг тайлбарлах онол (мөн агентуудын оновчтой үйл хөдлөл болон рациональ хүлээлтэд суурилдаг)-д тулгуурладаг тул эдийн засагт гарч буй үзэгдлүүд (өсөлт, мөчлөг) болон мөнгөний, төсвийн болон макро зохистой бодлогын нөлөөг тайлбарлахад чухал юм. Нийт эрэлт нь богино хугацааны үйлдвэрлэлийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд мөчлөг сөрсөн төсвийн болон мөнгөний бодлого нь үйлдвэрлэлийн хэлбэлзлийг бууруулна гэсэн таамаглалд суурилдаг.

Өнөө үед NOEM парадигм нь нээлттэй эдийн засаг дахь бодлогын шинжилгээний онолын суурь болж байна. Нээлттэй эдийн засгийн загваруудад валютын ханш, худалдааны

<sup>2</sup> Загваруудыг сонгохдоо 1) судлах гэж буй асуудалтай загварын үндсэн таамаглалууд нь нийцтэй эсэх, 2) загвар доторх механизм нь бодит байдалтай нийцтэй эсэх, 3) загварын үр дүнг бодит байдалд шууд ашиглах боломжтой эсэх, 4) загвараас гарч буй үр дүнгүүд нь бодит тоон өгөгдөлтэй нийцтэй эсэх зэргийг харгалзах ёстой болно (Д.Родрик 2015).

нөхцөл, экспорт болон импорт, тэдгээрийн үнэ болон олон улсын санхүүгийн зах зээлийн параметруудийг тусгадаг (Т.Лубик болон Ф.Шорфэйд 2006). Эдгээр загвар нь гадаад, дотоод хүчин зүйлс болон валютын ханшны дотоод эдийн засагт үзүүлэх нөлөөг судлах, оновчтой макро бодлогыг тодорхойлох боломжийг олгодог.

Шинэ Кейнсийн DSGE хандлагад суурилсан, дэлхий дахинд бодлогын шинжилгээнд түгээмэл ашиглагдаж байгаа бүтцийн загвар бол CAP загвар юм. Энэ загварын суурь бүтэц нь ОУВС-ийн эдийн засагчид болох Берг болон бусад (2006) судлаачдын ажилд тулгуурласан бөгөөд урт хугацааны тэнцвэрийн динамик болон түүнээс зөрөх богино хугацааны мөчлөгийг загварчилдгаараа онцлогтой. Энэ төрлийн загварчлал нь мөнгөний бодлогын шинжилгээнд түлхүү ашиглагдахаас гадна эдийн засгийн тэнцвэрийн динамикийг тооцох боломжийг олгодог ач холбогдолтой юм. Эдийн засгийн тэнцвэрийн болон мөчлөгийн динамикийг хамтад нь загварчилдаг тул үндсэн үзүүлэлтүүдийг тэнцвэрийн болон мөчлөгийг загвараас шууд тооцож, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх боломжийг олгох давуу талтай юм.

Бодлого боловсруулагчид эдийн засаг хүчин зүйлсийн цочрол өөрчлөлтүүдэд хэрхэн хариу үйлдэл үзүүлж байгааг тайлбарлах, хэтийн төлөвийн талаарх төсөөлөл гаргахад эконометрик аргаар үнэлэгдсэн, нэрлэсэн болон бодит хувьсагчдын уян хатан бус байдлыг шингээсэн Шинэ Кейнсийн загваруудыг ашиглахад ихээхэн төвлөрч байна. DSGE хэлбэрийн бүтцийн загварууд нь цочрол өөрчлөлтүүдийг нэгэн зэрэг таних, эдгээр өөрчлөлтийн нөлөөг тооцох,

эдийн засгийн төсөөлөл гаргах зэрэгт харьцангуй давуу талтай. Эдийн засагт оролцогчдын одоогийн үйл хөдлөлд ирээдүйн талаарх төсөөлөл нөлөөлнө гэж үздэг нь эдгээр загварыг динамик болгохын зэрэгцээ агентуудын хүлээлт нь одоогийн макро эдийн засгийн төлөвт чухал үүрэг гүйцэтгэнэ гэсэн баримтыг оруулж өгдөг.

Хүчин зүйлсийн цочрол өөрчлөлтүүд нь эдийн засгийн хэлбэлзлийг тайлбарлахад чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ эдгээр өөрчлөлтийн нөлөөг судлах боломж олгодог. Түүнчлэн загварын ерөнхий тэнцвэрийн шинж чанар нь бодлогын арга хэмжээ болон агентын үйл хөдлөл хоорондын холбоог илэрхийлдэг. Учир нь зах зээл бүрийн хувьд нийлүүлэлт нь эрэлттэй тэнцэх хүртэл үнэ болон хүү нь өөрсдөө зохицуулалт хийнэ.

VAR болон DSGE загваруудыг хөгжиж буй, эрдэс түүхий эдээс хамааралтай орны хувьд хэрхэн хувирган ашиглаж болох талаар эргэцүүлсэн харьцангуй цөөн тооны судалгаа бий. Тухайлбал, Р.Латипов (2018) газрын тос экспортлогч жижиг эдийн засгийг загварчлахад VAR загварын ялгаатай хувилбаруудыг ашиглах боломжтойг дурдаад, ОХУ-ын хувьд VAR загварт газрын тосны үнэ, үйлдвэрлэлийг хэрхэн тусгаж болохыг санал болгож, тус загварын матриц илэрхийлэл ямар байх, түүний параметруудийг ямар эконометрик аргаар үнэлж болох талаар судалсан. Гэхдээ тэрээр загварын параметруудийг үнэлээгүйн дээр эмпирик шинжилгээг хийгээгүй.

Судлаачдын хувьд эмпирик шинжилгээнд ашиглагдахуйц DSGE загваруудыг хөгжүүлэх, тэр дундаа Шинэ нээлттэй эдийн засгийн макро эдийн засаг NOEM (New open economy macroeconomics)<sup>1</sup>-ийн парадигмд суурилсан DSGE загвар боловсруулахад

<sup>3</sup> Шинэ нээлттэй эдийн засгийн макро эдийн засаг NOEM парадигмыг анх М.Обстфелд болон К.Рогофф (1995) дэвшүүлсэн бөгөөд тэд хоёр улсын төгс бус өрсөлдөөнтэй, үнийн уян хатан бус байдалтай ерөнхий тэнцвэрийн загварыг авч үзсэн. Онолын болон эмпирик NOEM загваруудын хөгжлийн түүхэн замналыг П.Лэйн (2001), Т.Лубик болон Ф.Шорфэйд (2006) тусгайлан судалсан байдаг. Нээлттэй эдийн засгийн DSGE загваруудын сүүлийн үеийн хөгжлийг Л.Кристиано болон бусад (2011), М.Адолфсон болон бусад (2007, 2013) нарын ажлаас харах боломжтой.



ихээхэн анхаарч байна.

1990-ээд оны эхнээс NOEM нь ерөнхий тэнцвэрийн нээлттэй эдийн засгийн загваруудын хөгжилд чухал хувь нэмэр оруулж ирэв. Өнөө үед NOEM парадигм нь нээлттэй эдийн засаг дахь бодлогын шинжилгээний онолын суурь болж байна. Нээлттэй эдийн засгийн загваруудад валютын ханш, худалдааны нөхцөл, экспорт болон импорт, тэдгээрийн үнэ болон олон улсын санхүүгийн зах зээлийн параметруудийг тусгадаг (Т.Лубик болон Ф.Шорфэйд 2006). Эдгээр

загвар нь гадаад, дотоод хүчин зүйлс болон валютын ханшны дотоод эдийн засагт үзүүлэх нөлөөг судлах, оновчтой макро бодлогыг тодорхойлох боломжийг олгодог.

Эдгээр загварын аль хувилбарыг бусад орны төв банк, сангийн яам, олон улсын санхүүгийн байгууллагууд ашиглаж байгааг хүснэгт 1-д нэгтгэн харуулав. Хөгжингүй улс орнуудын төв банк, сангийн яам, олон улсын санхүүгийн байгууллагууд шинжилгээний зорилгоос хамаарч ялгаатай загваруудыг давхар хөгжүүлэн

Хүснэгт 1.

Макро эдийн засгийн загваруудыг ашиглаж буй байдал<sup>4</sup>

Загвар	Төв банк	Сангийн яам	Олон улсын санхүүгийн байгууллага
VAR загвар, түүний ялгаатай хэлбэрүүд	- Европын төв банк, Холбооны нөөцийн банк, Канад, Австрали, Шинэ Зеланд, Норвеги зэрэг хөгжингүй орнуудаас эхлээд хөгжиж буй орны төв банкууд (ОХУ, Монгол) хүртэл ашиглаж байна. -Бодлогын шилжих механизм, эмпирик баримт гаргахад өргөн ашиглаж байна. -Сүүлийн жилүүдэд FAVAR, Бейсийн VAR-ын ялгаатай хэлбэрүүд, бүтцийн цочрол өөрчлөлтийг тэмдгийн хязгаарлалт ашиглан таних хандлага нийтлэг болсон.	-Австрали, Чех, Дани, Швед, Финланд, Нидерланд, АНУ, Канад, Англи, Европын комисс, Япон, Норвеги зэрэг орнууд VAR загваруудыг төсөөлөл гаргах, бодлогын шинжилгээнд өргөн ашиглаж байна.	-Дэлхийн банк, ОУВС, АХБ болон Олон улсын төлбөр тооцооны банкууд судалгаа шинжилгээнд VAR загвар, түүний ялгаатай төрлүүдийг түгээмэл ашиглаж байна.
DSGE загвар	-Швед, Чех, Япон зэрэг орны төв банкууд DSGE загварт суурилан төсөөлөл бодлогын шинжилгээг хийдэг. -Бусад хөгжингүй орны (Австрали, Норвеги, Итали) болон эрчимтэй хөгжиж буй орны төв банкууд (ОХУ) DSGE загварыг туслах загвар болгон ашиглаж байна.	-Чех, Япон, Австрали, Испани зэрэг хөгжингүй орнуудын сангийн яам DSGE загварыг төсөөлөл гаргах, бодлогын хувилбар боловсруулахад ашигладаг.	-ОУВС-ийн хувьд бодлогын нэгдсэн тогтолцоо (IPF)-г хөгжүүлж, гишүүн орнуудад санал болгох хүрээнд DSGE загваруудыг хөгжүүлж байна. -Дэлхийн банк, Олон улсын төлбөр тооцооны банк, Азийн хөгжлийн банкны хувьд DSGE загварыг судалгаа, шинжилгээнд өргөн ашиглаж байна.
Шинэ Кейнсийн DSGE-т суурилсан бүтцийн болон GAP загварууд	-Ихэнх хөгжингүй орны төв банкууд (Австрали, Норвеги, Итали) онол, эмпирик нийцтэй байдлыг хослуулсан том хэмжээний бүтцийн загварыг үндсэн загвар болгон ашиглаж байна. -Эрчимтэй хөгжиж буй орнууд болон хөгжиж буй орнууд (Польш, Монгол) GAP загварыг ашиглаж байна.	-GAP хэлбэрийн загваруудад төсвийн секторыг задалж оруулдаггүй тул сангийн яаманд ашигладаггүй. -Бүтцийн загваруудад төсвийн секторыг тусгах боломжтой тул өргөн ашигладаг.	-Дэлхийн банк өөрийн гишүүн 181 орны загварыг багтаасан макро болон төсвийн бүтцийн загвар /MFMMod/ -ыг төсөөлөл гаргах, бодлогын шинжилгээ хийхэд ашиглаж байна. -ОУВС бүс нутгийн болон гишүүн орнуудын бодлогын төлөв, төсөөлөл гаргахдаа GAP хэлбэрийн загварыг өргөн ашигладаг.

<sup>4</sup> Д.Ган-Очир "Монголын эдийн засгийг тогтворжуулах бодлогын эрэлд" УБ 2022 он., 29х.



ашиглаж байна. Харин хөгжиж буй орны хувьд DSGE загварыг албан ёсоор бодлогын шинжилгээнд ашиглаж эхлээгүй боловч судалгаанууд эрчимтэй хийгдэж байна.

DSGE загварт суурилсан эмпирик шинжилгээ Ф.Шорфэйд (2000), Ф.Сметс болон Р.Воутерс (2003) нарын дараагаас эрчимжсэн бөгөөд 2008-2009 оны глобал санхүүгийн хямралын дараа макро эдийн засгийн шинжилгээний гол арга зүй болж төлөвшөөд байна. КОВИД-19 цар тахлаас үүдэн глобал эдийн засаг 2020 онд уналтад орж, эдийн засагчид болон бодлого боловсруулагчид 1) мөнгөний тоо хэмжээний тэлэлт хийх, 2) төсвийн тэлэлт, дэмжлэг болон 3) сөрөг хүүний бодлого гэсэн макро бодлогуудыг

дангаар болон хослуулан хэрэгжүүлж байна. Эдгээр хэрэгжиж буй бодлогын нөлөөг тооцох, төсөөлөл гаргах асуудал дээр Шинэ Кейнсийн DSGE загварыг суурь болгон ашигласаар иржээ. Энэ нь тус загварчлалын арга зүй нь дараагийн шинэ парадигмын үед ч шинжилгээ, судалгааны гол арга зүй хэвээр байхыг илтгэнэ.

Шинэ Кейнсийн DSGE хандлагад суурилсан, дэлхий дахинд бодлогын шинжилгээнд түгээмэл ашиглагдаж байгаа бүтцийн загвар бол CAP загвар юм. Энэ загварын суурь бүтэц нь ОУВС-ийн эдийн засагчид болох Берг болон бусад (2006) судлаачдын ажилд тулгуурласан бөгөөд урт хугацааны тэнцвэрийн динамик болон түүнээс зөрөх богино хугацааны мөчлөгийг

## Хүснэгт 2.

## Загваруудын давуу болон сул тал

Загвар	Давуу тал	Сул тал
Бейсийн том хэмжээний VAR загвар	<ul style="list-style-type: none"> <li>-Загварын системд олон хувьсагч оруулах, динамик хамаарлыг бүрэн тусгадаг.</li> <li>-Тоон өгөгдөлд байгаа мэдээлэлд суурилан эмпирик баримтууд гаргана.</li> <li>-Загварын тавил харьцангуй энгийн тул ашиглахад /харьцангуй/ хялбар.</li> <li>-Тоон өгөгдлийн динамик шинж чанарыг сайн тайлбарлах, төсөөлөл гаргах, симуляци шинжилгээ хийх боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-Макро эдийн засгийн онолын хамаарлыг тусгах боломж хязгаарлагдмал тул зарим тохиолдолд онолын хувьд нийцгүй үр дүн өгөх боломжтой.</li> <li>-Бодлогын хариу үйлдлийн дүрэм, оночтой хосолсон бодлогын талаар хангалттай мэдээлэл өгөхгүй.</li> <li>-Эдийн засгийн мөчлөг /стохастик бүрдэл-тренд, сул гишүүн/-т нөлөөлөгч хүчин зүйлсэд илүүтэй төвлөрдөг.</li> </ul>
Дунд хэмжээний DSGE загварт суурилсан Бүтцийн загвар (Бейсийн аргаар үнэлэгдсэн)	<ul style="list-style-type: none"> <li>-Макро эдийн засгийн онол, аргазүйд гарч буй хөгжил, дэвшлийг өөртөө шингээдэг.</li> <li>-Бодлогын шилжих механизмыг нарийвчлан судлах боломжийг олгоно.</li> <li>-Эдийн засгийн оновчтой хосолсон бодлогыг тодорхойлох боломжтой.</li> <li>-Загварын шинжилгээнд олон хувьсагчдыг түүвэрлэн оруулна.</li> <li>-Тоон өгөгдлийн динамик шинж чанарыг сайн тайлбарлах, төсөөлөл гаргах, симуляци шинжилгээ хийх боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-Онолын зарим хязгаарлалтаас үүдэн зарим эмпирик баримтыг давтан гаргахгүй байх магадлалтай.</li> <li>-Өндөр түвшний онолын мэдлэг, математик арга, магадлал, статистик, эконометрикийн мэдлэг шаардана.</li> <li>-Эдийн засгийн тогтвортой төлвийг тогтмол гэж таамагласан тул тэнцвэрийн динамикийг тооцдоггүй.</li> </ul>
Энгийн DSGE загварт суурилсан CAP загвар (Бейсийн аргаар үнэлэгдсэн)	<ul style="list-style-type: none"> <li>-Эдийн засгийн тэнцвэрийн болон мөчлөгийн динамикийг хамтад нь загварчилна.</li> <li>-Хувьсагчдын хоорондын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хамааралд суурилдаг тул нийтлэг ашиглагддаг.</li> <li>-Эдийн засгийн тэнцвэрийн динамикийг загвараас шууд тооцох боломжтой.</li> <li>-Тоон өгөгдлийн динамик шинж чанарыг сайн тайлбарлах, төсөөлөл гаргах, симуляци шинжилгээ хийх боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-Загварын системд онолын үндэслэлтэйгээр олон хувьсагч оруулах боломж хязгаарлагдмал.</li> <li>-Эмпирик баримт гаргах, оновчтой хосолсон бодлогын тал дээр дээрх хоёр загвараас хязгаарлагдмал.</li> <li>-Загварыг Бейсийн аргаар үнэлэх, загвар ашиглан тэнцвэрийн болон мөчлөгийн динамик тооцоход магадлал, статистик, эконометрикийн өндөр түвшинд мэдлэг шаардана.</li> </ul>



загварчилдгаараа онцлогтой. Энэ төрлийн загварчлал нь мөнгөний бодлогын шинжилгээнд түлхүү ашиглагдахаас гадна эдийн засгийн тэнцвэрийн динамикийг тооцох боломжийг олгодог ач холбогдолтой юм.

Энэхүү судалгаанд ашигладаг гурван загварын онцлогийг нэгтгэн хүснэгт 2-д харуулав. Эдгээр загварууд нь өөр өөрийн давуу болон сул талтай. Тухайлбал, Бейсийн том хэмжээний VAR загварын хувьд шаардлагатай бүх хувьсагчдыг загварын системд оруулж, нарийн “шүүлтүүр”-ээр оруулсны эцэст тухайн сонирхож буй хувьсагчид дахь нөлөөг тооцдог тул эмпирик баримт гаргах тал дээр илүү давуу талтай. Харин дунд хэмжээний DSGE-д суурилсан Бүтцийн загварын хувьд хувьсагчдын хоорондын хамаарлыг онолын түвшинд нарийн тусгадаг тул шилжих механизм судлах, бодлогын шинжилгээ хийхэд бусад загваруудаас илүү давуу талтай юм. CAP загварын хувьд эдийн засгийн тэнцвэрийн болон мөчлөгийн динамикийг хамтад нь загварчилдаг тул үндсэн үзүүлэлтүүдийг тэнцвэрийн болон мөчлөгийг загвараас шууд тооцож, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх боломжийг олгох давуу талтай юм.

### ДҮГНЭЛТ

Тухайн орны нийгэм эдийн засгийн ерөнхий хууль, онол арга зүйд суурилан тогтворжуулах бодлогын загварчлалын томъёолох нь чухал юм. Энд тухайн орны өвөрмөц онцлогийг шингээсэн орон зай, цаг хугацааны хувьсал өөрчлөлт, гаднын орчны нөлөөллийн тусламж бүхий цогц систем тул түүнийг судалж, шинжилж, удирдах зохистой бодлогыг тодорхойлоход “Системт хандлага”-ын аргыг ашиглах зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсэж байгаа юм. Учир нь эдийн засаг нь байнга хувьсан өөрчлөгдөж байдаг нарийн нийлмэл систем бөгөөд улам бүр стохастик

хэлбэр рүү орж байна.

Үндэсний эдийн засгийг гадаад орчны нөлөөн доор орших динамик, стохастик, ерөнхий тэнцвэртэй систем гэж үзэн харилцан шүтэлцээтэй загваруудыг өөрийн орны онцлогт тохируулан нутагшуулах шаардлага нэгэнтээ бий болжээ. Иймд орчин үеийн математик арга, загварчлал, статистик, эконометрик шинжилгээ, холбогдох программ хангамжийг өндөр түвшинд эзэмшиж байж эдийн засгийг тогтворжуулах бодлогын онол загварчлалыг хэрэглэж болгодог.

Үндэсний эдийн засгийг гадаад орчны нөлөөн доор орших динамик, стохастик, ерөнхий тэнцвэртэй систем гэж үзэн харилцан шүтэлцээтэй загваруудыг өөрийн орны онцлогт тохируулан нутагшуулах шаардлагатай. Өнөөдөр мөчлөг дагасан шокыг зөөлрүүлэх, гадаад зах зээлийн хямралыг даван туулах арга замыг хайж, тогтвортой хөгжлийг хангасан эдийн засгийн тэлэлтийг бий болгох, макро эдийн засгийн бодлогыг оновчтой хэрэгжүүлэх асуудлын шийдэл, гаргалгааг тусгахад дээрх онолын загварчлалуудыг ашиглах нь чухал болоод байгаа билээ.

Эдийн засгийн өндөр хэлбэлзэлтэй, түүнээс үүдэн санхүүжилтийн таатай орчин бүрдээгүй нөхцөлд хөгжлийн том зорилтуудыг шийдвэрлэх боломж хязгаарлагдмал юм. Иймд макро эдийн засгийг тогтворжуулах бодлогыг оновчтой тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлэх нь хөгжилд хөтлөх суурь нөхцөл болно.

Энэ үүднээс эдийн засгийн онцлог, өнөөгийн бодит нөхцөл байдлыг макро эдийн засгийн загварууд болох VAR загвар, DSGE-д суурилсан бүтцийн загвар болон GAP загварт тусгаж, эдийн засгийг тогтворжуулах бодлогын нөлөөг судлах, оновчтой хослолыг гаргаж ирэх шаардлагатай. Иймд загварууддаа Монгол Улсын эдийн засгийн онцлогуудыг эн тэргүүнд тусгах ёстой гэж үзэв.

**Ашигласан материал:**

1. Д.Ган-Очир "Монголын эдийн засгийг тогтворжуулах бодлогын эрэлд" УБ., 2022 он.
2. Д.Энхчимэг, Т.Мөнх-Оргил "Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга зам: онол, аргазүй, туршлага, шинжилгээ, боломж" УБ 2021 он.
3. Х.Хашчулуун "Их өгөгдлийг эдийн засгийн төлөвлөлтөд ашиглах нь" илтгэл УБ2021 он.
4. Р.Батмэнд "Монголын хөгжлийн бодлогын философи: улс төрийн эдийн засгийн ухаантай холбогдох нь" УБ2016 он.
5. Adolfson, M Laseen, S, Linde, and Villani "Bayesian estimation of an open economy DSGE model with incomplete pass-through", Journal of International Economics vol72, pp481-511.
6. Adolfson, M Laseen, S, Linde, and Villani, M2008 "Evaluating an estimated New Keynesian Small open model", Journal of International Economics vol 32, pp2960-2721.
7. МУИС Фредрих С.Мишкин, Стэнли Г.Изкинс "Санхүүгийн зах зээл ба байгууллагууд" орчуулгын ном., УБ2022 он.
8. Мөнгө баялаг сэтгүүл, Монгол банк УБ 2020-2021 он



## ТӨМӨР БЕТОН АРАГ БҮТЭЭЦИЙН ГАЗАР ХӨДЛӨЛИЙН ТЭСВЭРЛЭЛТИЙГ ҮНЭЛЭХ АРГУУДЫН СУДЛАГДСАН БАЙДЛЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

**Э.ГАНЗОРИГ** /ШУТИС, Барилга, архитектурын сургууль, Доктор (Ph.D), дэд профессор/  
**Д.БАЯРЦЭЦЭГ** /ШУТИС, Барилга, архитектурын сургууль, докторант/

**Түлхүүр үг:** Газар хөдлөлт, газар хөдлөлийн бичлэг, хариу спектр, дизайн спектр, хэвтээ түлхэх арга, аналитик тооцоо, динамикийн итгэлцүүр

**Key words:** Earthquake, seismic recording, response spectrum, design spectrum, push over method, analytical calculation, dynamics coefficient

### I. Удиртгал

Газар хөдлөлтөд тэсвэртэй барилга байгууламжийн тухай ойлголт хүн төрөлхтний иргэншлийн хөгжлийн бүхий л үед байсан хэдий ч инженерийн хийцтэй барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэршлийн тухай ойлголт 1900-аад оны эхэн үеэс (1906 оны Сан Францискогийн газар хөдлөлт) бий болсон гэж үздэг. Харин газар хөдлөлтөд тэсвэртэй барилгын төсөллөлт, түүний нормативыг анх 1920-иод оны дунд үеэс (1923 оны Кантогийн их газар хөдлөлт) Япончууд хэрэглэж эхэлсэн гэж үздэг байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад хүн амын төвлөрөл эрчимтэй явагдаж өнөөдрийн байдлаар нийт хүн амын 60 гаруй хувь нь хот, суурин газарт амьдарч байгаа тул болзошгүй газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг багасгах асуудалд анхаарах шаардлагатай нь харагдаж байна. Манай орны хот суурингийн 75 орчим хувь нь газар хөдлөлтийн идэвхтэй бүс нутагт, 12 сум суурин газар хөдлөлтийн 9.5-аас дээш магнитудтай бүс нутагт оршиж байдаг байна<sup>1</sup>.

Улаанбаатар хот газар хөдлөлтийн 7.5 баллын идэвхтэй бүсэд оршдог. Ингэхдээ нийслэл орчмын Авдар уул, Эмээлт, Гүнжийн ам, Хустайн нуруу, Мөнгөнморьт гэсэн зургаан бүс газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд тооцогддог ба хамгийн ойр нь 15-20км зайд, хол нь 212км зайд оршиж байна. Тус

газарт 6.5-8.5 баллын газар хөдлөх магадлалтай бөгөөд тухайн газруудад газар хөдлөхөд нийслэл хотод мэдрэгдэх хүч нь 5.5-7.5 балл юм.

Өнгөрсөн зуунд 6 болон түүнээс дээш магнитудын хүчтэй газар хөдлөлт 40 гаруй удаа тохиолдсон байна. Барилгын тэр дундаа манай улсын барилга байгууламжийн ихэнх хувийг эзэлдэг төмөр бетон араг бүтээцийн бат бэхийг газар хөдлөлтөд үнэлж тэсвэрлэлтийг мэдэх нь ялангуяа улс төр, нийгэм эдийн засгийн чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсад цутгамал төмөр бетон барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх одоогийн аргачлал харьцангуй дутагдалтай талтай байгаа тул сайжруулах шаардлагатай. Энэхүү судалгааны ажил нь барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх, сайжруулах асуудалд нөлөөлөх хүчин зүйлс болох биет туршилтын загвар байгуулж, туршилтын загвараас тоон загвар үүсгэж шугаман бус шинжилгээг хийх түүнээс үүдсэн харьцуулалт, нийлэлтийг сайжруулах, цаашид энэ чиглэлээр хийж болох ажлын талаар санал зөвлөмж боловсруулах зэрэг судалгааны ажлын нарийвчилсан зорилгод хөтлөх дараа дараагийн ажлын үндэс суурь нь болж өгөх юм.

### II. Судалгааны хэсэг

Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх ажлын хүрээнд Улаанбаатар

<sup>1</sup> Улаанбаатар хот орчмын хүчтэй газар хөдлөлтийн идэвхжилтийн бүсэд нарийвчилсан судалгаа хийх ажлын тайлан. УБ., 2013., хуудас 111-130;

хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс сэргийлэх чадавхыг бэхжүүлэх төсөл, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 157 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр 8221-ийн хүрээнд, НЗД-ын 2012 оны А/26 дугаар захирамжийн дагуу нийслэлийн барилга байгууламжийг газар хөдлөлт тэсвэрлэлтээр нь үнэлж, мэдээллийн санд бүртгэх ажил 2011 оноос эхлэн хийгдэж, барилгыг паспортжуулах ажлын хүрээнд 2011-2013 онд 328 орон сууцны барилгыг судлан, хэмжилт хийж, үнэлгээ гаргасан<sup>2</sup>.

Газар хөдлөлтийн бичил мужлал шинээр хийгдсэн бөгөөд энэ мужлалаар манай орны нийт нутгийн 80 орчим хувьд газар хөдлөлтийн одоо байгаа эрчим нэмэгдсэн байна.

Монгол орны хувьд газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд барилга барих норм дүрэм болон өндөр барилга барих норм дүрэмд оруулах хариу спектрийг тодорхойлох тогтсон арга зүйг бий болгох ажил нэн шаардлагатай байна. Үүнд:

- Манай орны барилгын норм дүрэмд орсон хариу спектр нь тухайн бүс нутгийн мэдээлэлд тулгуурлаагүй (шаардлага хангахгүй) байдлыг засварлах, нарийвчлах;
- Хариу спектрийн тооцоолол хийх нэгдсэн арга зүйтэй болох;
- Бүтээцийн тооцоо, түүний шинжилгээний олон улсад хэрэгжүүлж буй орчин үеийн тооцооны аргуудыг норм дүрэмд тодорхой тусгаж өгөх зэрэг асуудлууд багтана.

### II.1 Газар хөдлөлтийн бичлэг.

Газар хөдлөлтийн бичлэг барилга барих байршил бүрт байдаггүй. Гэвч зөвхөн газар хөдлөлтийн хамгийн их утгаар барилгын тооцоолол хийх нь учир дутагдалтай. Давтамжийн бүтэц маш чухал байдаг билээ. Хариу спектр-


(response spectrum) гэдэг нь төрөл бүрийн давтамжтай системийн хариу үйлдлийн хамгийн их амплитуд (хурд, хурдатгал, шилжилт) болон тухайн системийн давтамжийн хамаарлыг харуулсан спектр юм. Хариу спектрийг тооцоолоход түүнд нөлөөлөх гол хүчин зүйлс маш чухал байдаг. Үүнд: Газар хөдлөлтийн механизм, эпицентрийн зай, гипоцентрийн гүн, хөрсний нөхцөл, магнитуд, системийн замхралын коэффициент, системийн давтамж зэрэг орно.

Хариу спектрийг хоёр аргачлалаар тооцоолно.

а) Суурь үнэлгээний аргачлал - Тухайн судалгааны талбайд бичигдсэн эсвэл ойр орших хүчтэй газар хөдлөлтийн бичлэгээс хариу спектрийг тооцоолон гаргадаг.

б) Магадлалт үнэлгээний аргачлал - Нэгэн төрлийн аюулын спектр- (uniform hazard spectrum) ASCE-(American society of civil engineering)-т зааснаар:

### PSA, PSV, SD vs. PGD, PGV, PGA



1 дүгээр зураг. Хариу спектрийн шинж чанарын хурд болон давтамжийн хамаарлын график.

Суурь үнэлгээний аргачлал нь ерөнхийдөө хүчтэй газар хөдлөлтийн улмаас талбайд үүсэх хөрсний чичирхийллийг хөрсний оргил хурдатгал (PGA), хөрсний оргил хурд (PGV), шилжилт (PGD) болон спектрал респонс хурдатгал (Sa(T))-аар тодорхойлдог<sup>3</sup>.

Барилгын тооцоонд газар хөдлөл-


<sup>2</sup> Монгол орны газар хөдлөлтийн идэвхжил, аюулын үнэлгээний ба дэлхийн гүний тогтоцын судалгаа. УБ., 2011-2013., хуудас 95-98;

<sup>3</sup> Нарангарав Т., Барилгын нормд орох газар хөдлөлтийн хурдатгалын бичлэг сонгох аргачлалууд. УБ., 2022;




тийн дараах гурван төрлийн бичлэгийг хэрэглэж болдог. Үүнд:

- Зохиомол бичлэг (artificial waveforms);
- Загварчилсан хурдатгалын бичлэг (simulated accelerogram);
- Бодит бичлэг (natural recording);




2 дугаар зураг. 50 жилд 10 хувь хэтрэх магадлал бүхий чичирхийллийн үе болон хурдатгалаас хамаарсан хариу спектрийн график.

Хөрсний шинж чанараас хамаарч хариу спектрийн хэлбэр өөр өөр байна.



3 дугаар зураг. Нэгэн төрлийн аюулын спектрийн график

Нэгэн төрлийн хариу спектр нь магадлалт аргаар тооцоологдсон, хамгийн ойрын жижиг болон хол зайтай болсон газар хөдлөлтийн мэдээлэл тооцоонд орсон, уламжлалт суурь үнэлгээний аргаас илүү мэдээлэл агуулсан байдаг боловч дутагдалтай тал нь бүх нөхцлийг хангасан синтетик



үүсгэхэд тохиромжгүй байдаг<sup>4</sup>.

4 дүгээр зураг. 50 жилд 2 хувь хэтрэх магадлал бүхий чичирхийллийн үе болон хариу спектрийн хурдатгалаас хамаарсан дизайн спектрийн график.

4-р зураг буюу нэгэн төрлийн хөрсний хувьд:

$S_I$  - богино хугацаанд тухайн хэсэгт тодорхойлсон, 5 хувийн сааралттай үеийн хариу спектрийн хурдатгалын параметр.

$S_S$  - 1 секундын хугацаанд тухайн хэсэгт тодорхойлсон, 5 хувийн сааралттай үеийн хариу спектрийн хурдатгалын параметр.

$$\begin{aligned} S_{DI} &= 2 / 3 S_I \\ S_{DS} &= 2 / 3 S_S \end{aligned} \quad (1)$$

$S_{DI}$  - богино хугацаанд дизайн спектрийн хариу хурдатгалын параметр.

$S_{DS}$  - 1 секундын хугацаанд дизайн спектрийн хариу хурдатгалын параметр.

Хариу спектрээс гадна дизайн спектр (design spectrum) гэсэн ойлголт байдаг. Энэ хоёр спектр нь хоорондоо ижил биш бөгөөд хариу спектр нэгэн жигд бус байдаг бол дизайн спектр нь дундаж утгаар авч гөлгөр болгосон, эсвэл ямар нэгэн байдлаар хэд хэдэн хариу спектрээс нормчлон гарган авсан байдаг. Барилгын тооцоонд газар хөдлөлтийн бичлэг сонгоход тавигдах шаардлагууд олон улсын нормуудад дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

**AHV- (ASCE 7)<sup>5</sup>.**

<sup>4</sup> Дашжамц Д., Ул хөрсний динамик, сейсмологийн үндэс, геофизикийн судалгаа. УБ., 2021;

<sup>5</sup> Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал., БД 22-106-18;



- Хамгийн багадаа 3 бичлэг сонгох;
- Тухайн газар хөдлөлт ижил зай болон магнитудтай байх. 2 хэмжээст анализ хийхэд сонгож авсан бичлэгүүдийн дундаж спектр нь шаардлагатай бүх давтамжийн мужид нормын спектрээс доош ороогүй байх;
- Сонгон авсан спектрийг нормчлох, эсвэл спектрийг нь зорилтот спектртээ тааруулах;
- Спектрийг тааруулахдаа байгууламжийн давтамж 0.2T болон 2T утгад харгалзуулах;

#### **БНХАУ- (GB50011-2001).**

- Хамгийн багадаа 3 бичлэг сонгох;
- 50 жилд-бага зэргийн газар хөдлөлтөд байгууламж ямар нэг засваргүйгээр хэвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх;
- 475 жилд - дунд зэргийн газар хөдлөлтөд бага зэргийн засвартайгаар байгууламжийг ашиглах боломжтой байх;

#### **Евронорм- (EUROCODE 8).**

- Хамгийн багадаа 3 бичлэг сонгох;
- Барилга байгууламжийн чухал байдал болон тухайн нөхцөл байдлаас хамаарч геологи ба сейсмологийн судалгааг заавал хийсэн байх ёстой;
- Бичлэгийн хариу спектрийн 0.2T болон 2T тодорхойлох утга нь нормын спектрийн 1.3-с бага байж болохгүй гэх мэт заасан байна. Үүнийг Одон орон, геофизикийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаач Ч.Одонбаатар болон бусад судлаачдын судалгаа шинжилгээний ажлуудаас иш татан хураангуйлан оруулав <sup>6</sup>.

#### **II.2 Бүтээцийн газар хөдлөлтийн үнэлгээний аргачлал.**

Бүтээцийн тооцооны статик болон динамик аргууд байдаг ба тэдгээрийг дотор нь уламжлалт болон нарийвчилсан загвар гэж ангилж болно.

Шугаман харимхай шинжилгээ (Elastic analysis):

- Эквивалент статик хүчний арга буюу шугаман спектр арга (Бүх төрлийн бүтээцийн тооцоонд);
  - Хажуугийн хүчний арга (Lateral force design);
  - Хариу спектр арга буюу (Response Spectrum Method) (нэмэлт шаардлага);
  - Хугацааны турш шинжлэх арга (Time History Analysis) (онцгой хариуцлагатай болон өндөр >16 барилгууд);
  - Шугаман динамик шинжилгээ (Linear dynamic analysis);
- Байгууламжийн шугаман бус шинжилгээ (Inelastic analysis):

- Шугаман бус статик шинжилгээний арга буюу хэвтээ түлхэх арга (Push-Over);
- Шугаман бус динамик шинжилгээ (Nonlinear dynamic analysis);

Манай улсад газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэхэд хялбарчилсан болон нарийвчилсан аргачлалыг ашиглаж байна.

Барилгын газар хөдлөлт тэсвэрлэх чадварыг бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн  $I_s$  индексээр тоон утгаар илэрхийлнэ. Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн  $I_s$  индексийг хязгаарын индекс  $I_{so}$ -той харьцуулж тэсвэртэй эсэхийг тогтооно.

$$I_s \geq I_{so} \quad (2)$$

Энд:  $I_s$  - бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс;

$I_{so}$  - бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн хязгаарын индекс.

Олон улсад "Push-over" буюу хэвтээ түлхэх аргын шинжилгээ нь шинээр барих болон одоо байгаа барилгын бодит ажиллагааг шалгаж төсөллөх (ажиллагаанд үндэслэсэн төсөллөлт-performance based design) тооцооны аргачлал юм. Барилга байгууламжийн бүтээцийн систем дэх элементүүдэд газар хөдлөлтөөс үүсэх эвдрэлийн механизмыг шинжилдэг. Энэ шинжилгээнд бүтээцийн материалын налархай

<sup>6</sup> Одонбаатар Ч., Олон улсын норм дүрэмд газар хөдлөлийн бичлэг болон респонс спектрийг тооцоолох арга зүйн судалгаа. УБ., 2022;


чанарыг бодолцон тооцох бөгөөд тооцооны үр дүнгээр тухайн системийг үнэлнэ<sup>7</sup>.

Хэвтээ түлхэх шинжилгээгээр хариу даацын муруй (capacity spectrum) болон хариу спектр муруй (response spectrum) тэдгээрийн огтлолцлоос үүсэх төлөв байдлын цэг (performance point) мөн зангилааны төлөв байдлын үзүүлэлтүүд, бусад ойлголтуудыг судална.

Олон улсад "Pushover" шинжилгээг хийхийг шаарддаг Eurocode 8, FEMA 273, АТС-40 зэрэг норм дүрэм, аргачилсан зааврууд байна.

АТС-40-д тусгасан ойлголтуудыг товч дурьдвал:

- Capacity curve – Нийлбэр хэвтээ хүч  $V$  болон хэвтээ шилжилт 2-с хамаарсан график;
- Capacity spectrum - "Capacity curve"-н координатуудыг томъёогоор хувиргаад гаргасан график<sup>8</sup>.



5 дугаар зураг. Нийлбэр хэвтээ хүч болон оройн цэгүүдийн дундаж шилжилт 2-н хамаарлын график буюу чадавхын муруй болон координатуудыг томъёогоор хувиргасан график.

$$S_a = (V/W) / \alpha_1 \quad (3)$$

$$S_d = \Delta_{roof} / (PF_1 * \varphi_{1,roof})$$

Энэ арга нь нөгөөтээгүүр хүч - шилжилтийн харилцан хамаарал эсвэл барилга байгууламж болон түүний элементүүдийн "Capacity curve"-г тодорхойлоход ашигладаг нэмэлт статик тооцоо буюу барилга байгууламжийн компьютерийн загварыг тогтсон хэв маягаар хэвтээ хүчний үйлчлэлд тооцохыг хэлнэ. Өөрөөр хэлбэл барилга байгууламжийг

хязгаарын төлөв болон нурах төлөв байдалд хүртэл нь түлхэх, нийлбэр хөндлөн хүчний өсөлт бүр дэх хэвтээ шилжилтийн хамаарал зэргийг тодорхойлохыг хэлж байна.

"Robot structural analysis" программаар хэвтээ түлхэх шинжилгээг хийх ба түүнийг хийхэд дараах хязгаарлалтууд байна. Үүнд:

- Бусад шугаман бус төлөв байдлуудыг хамтад нь тодорхойлох боломжтой. Гэвч бүтээцийн шинж чанар дахь оролцоо нь "push-over" тооцооллын үед чухал биш байдаг;
- Налархай нугаснуудыг зөвхөн шилбэн төгсгөлөг элементэд олгодог. Хавтгай болон орон зайн төгсгөлөг элементүүдэд олгох боломжгүй;
- Налархай нугасыг бие даасан шугаман бус зангилаа шиг авч үзнэ. Ялгаатай чөлөөний зэргүүдийн хоорондын хамаарлыг бодолцдоггүй;
- Налархай нугасны байршлыг хэрэглэгч өөрөө зааж өгдөг;

"Robot structural analysis" программаар хэвтээ түлхэх шинжилгээ хийх дараалал.


- Барилга байгууламжийн тооцооны загварт налархай нугаснуудыг олгох;
- Налархай нугасанд шугаман бус хамаарал олгох (хүч-шилжилт эсвэл момент-өнцгийн эргэлт гэсэн диаграммаас);
- Барилга байгууламжийг хувийн хэлбэлзлээр задалж тооцон зонхилох хэлбэрийг тодорхойлох;
- Хэвтээ хүчний бүрдлийг тодорхойлох (Масс матрицын төрлөөс хамаарна);
- Хяналтын зангилааг тодорхойлж чиглэл болон зөвшөөрөгдөх шилжилтийн хэмжээг олгох;
- Шугаман бус тооцооны параметруудыг тодорхойлох;

<sup>7</sup> Одбаясах Б., Ганзориг Э., "Push-over" шинжилгээний талаарх ерөнхий ойлголт. УБ., 2016;

<sup>8</sup> Eurocode 8., Design of Structures for Earthquake Resistance — Part 1. General rules, seismic actions and rules for buildings. BS EN 1998-1:2004., Part 4;БД 22-106-18;



- Шугаман бус тооцоо хийж тэнцвэрийн төлөв байдлын муруй  $V=V(D)$ -г тодорхойлох;
- Даацын муруйг тодорхойлох  $S_{cap}=S_{cap}(S_d)$ ,  
Энд:  $S_{cap}$  – Хурдатгалын спектр,  $S_d$  – шилжилтийн спектр;
- Даацын хаших муруйг байгуулах;
- Төлөв байдлын цэгийг (Performance point)-г алхам алхмаар тооцоолж тодорхойлох;




6 дугаар зураг. Төмөр бетон араг бүтээцтэй барилгыг хэвтээ түлхэх (Pushover) шинжилгээгээр тооцох схем

### 11.3 Газар хөдлөлтийн эсэргүүцлийг тооцох нормууд. (аналитик тооцоо)

Их хэмжээний туршилтын болон онолын судалгааны үр дүнд үндэслэн дийлэнх орны газар хөдлөлийн ачаалалд барилгыг тооцох нормууд динамик аргын тооцооны үндсэн дээр эквивалент статик ачааллаар тооцоог гүйцэтгэж байна.

**ОХУ-ын норм:** Барилга байгууламжийг газар хөдлөлтийн ачаалалд тооцохдоо СНИП II-7-81 –ийг ашиглаж байгаа. Системийн хөдөлгөөн нь хувийн хэлбэлзлийн хэлбэрүүдээр дэлгэгдэнэ. Газар хөдлөлийн ачаалал нь хувийн хэлбэлзлийн хэлбэр тус бүрээр тодорхойлогдоно<sup>9</sup>.



7 дугаар зураг. Төвлөрсөн n тооны масс бүхий арагт бүтээцийн хэлбэлзлийн үндсэн хэлбэрүүд.

Газар хөдлөлийн бүрэн ачааллыг бүтээцийн харимхай хэв гажилт явагдах нөхцлийн төсөл дээр үндэслэн, системийн элементүүдийн эвдрэлийн янз бүрийн хэлбэр, нугас үүсэлт, байгууламжийн бүтээцлэлийн онцлог зэргийг тооцсон туршилтын коэффициентүүдийг оруулж дараах томъёогоор тодорхойлно.

$$S_{ik} = k_1 k_2 S_{oik} \quad (4)$$

$k_1=0,25$  – барилга байгууламжид зөвшөөрөгдөх хэмжээний эвдрэлийг тооцсон коэффициент;

$k_2$  – барилга, байгууламжийн бүтээцлэлийн онцлогийг тооцсон коэффициент;

$S_{oik}$  –  $m_k$  хэмжээтэй масст үйлчлэх барилгын хувийн хэлбэлзлийн  $i$  хэлбэрт харгалзах газар хөдлөлийн тооцооны ачаа;

**Олон улсын Евронорм- (EUROCODE 8).** Олон улсын ЕВРОКОД-8 нормын дагуу газар хөдлөлийн ачааллын тооцоонд хүчлэл нь гадаад хүчлэлээс илүү байх ёстой гэсэн нөхцөлд тулгуурлана. Эсэргүүцлийн хүчлэл нь тооцооны газар хөдлөлийн үйлчлэлээс үүдэн гарсан мөчлөгийн хэв гажилтыг бодолцсон байдаг. Тооцооны газар хөдлөлийн ачааллыг дараах томъёогоор тодорхойлно.

$$S = \frac{\alpha \beta \eta G}{k} \quad (5)$$

$\alpha, \beta, \eta$  -буурийн хөдөлгөөний дээд хурдатгалын нормчилсон түвшинг илэрхийлэх коэффициентууд;

G- байгууламжийн өөрийн жин;

$k = 1,5 \times 4$  – барилгын бүтээцлэлийн системийн ажлын онцлогийг бодолцсон коэффициент, төмөрбетон элементүүдийн харимхай бус ангиас хамаарах коэффициент;

**Японы норм:** Япон улсын нормоор бүтээцийн газар хөдлөлтийн тооцоо нь түүний аюулгүй байдлыг газар хөдлөлтийн явцад болон түүний дараа ашиглах боломжтой байх нөхцлийг хангах ёстой. Түүний хамт зөвхөн газар хөдлөлтийн хэвтээ байгуулагчийг авч

<sup>9</sup> Мөнх-Очир Г., Ганзориг., Хот суурин газрын газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ. магистрын зэрэг горилох бүтээл. УБ., 2018





шугаман бус шинжилгээ хийх (төгсгөлөг элементийн аргыг ашигласан Abacus, LIRA, Lira Sapr, SAP2000 программаар тооцож шинжлэх), үр дүнг харьцуулах,

нийлэлтийг сайжруулан дүгнэж, практикт нэвтрүүлэх, цаашид хийх ажлын талаар санал зөвлөмж гаргах ажлаа үргэлжлүүлэн үе шаттайгаар хийнэ.

### Ашигласан материал:

1. Улаанбаатар хот орчмын хүчтэй газар хөдлөлтийн идэвхжилтийн бүсэд нарийвчилсан судалгаа хийх ажлын тайлан. УБ., 2013., хуудас 111-130;
2. Монгол орны газар хөдлөлтийн идэвхжил, аюулын үнэлгээний ба дэлхийн гүний тогтоцын судалгаа. УБ., 2011-2013., хуудас 95-98;
3. Нарангарав Т., Барилгын нормд орох газар хөдлөлтийн хурдатгалын бичлэг сонгох аргачлалууд. УБ., 2022;
4. Дашжамц Д., Ул хөрсний динамик, сейсмологийн үндэс, геофизикийн судалгаа. УБ., 2021;
5. Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал., БД 22-106-18;
6. Одонбаатар Ч., Олон улсын норм дүрэмд газар хөдлөлийн бичлэг болон респонс спектрийг тооцоолох арга зүйн судалгаа. УБ., 2022;
7. Одбаясах Б., Ганзориг Э., Push-over шинжилгээний талаарх ерөнхий ойлголт. УБ., 2016;
8. Eurocode 8., Design of Structures for Earthquake Resistance — Part 1. General rules, seismic actions and rules for buildings. BS EN 1998-1:2004., Part 4;
9. Мөнх-Очир Г., Ганзориг Э., Хот суурин газрын газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ. магистрын зэрэг горилох бүтээл. УБ., 2018;
10. Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх., Барилгын норм ба дүрэм, БНБД 22.01.2020., УБ., 2020;
11. Ioannis P., GIANNPOULOS. Seismic Assessment of an RC Building according to FEMA 356 and Eurocode 8. 21-23/10/2009;
12. Ганзориг Э., бусад., Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх, Барилгын норм ба дүрэм. БНБД 22.01 – 2020\*/2020-ийн тайлбар. БД 22-101-20 /СТ 14/;
13. Базар Г., Газар хөдлөлтөд тэсвэртэй барилга. УБ., 2017;
14. Амосов А.А., Сеницын С.Б., Основы теории сейсмостойкости сооружений, Издательство Ассоциации Строительных ВУЗов. Москва., 2001;
15. Ганзориг Э., Улаанбаатар хотын газар хөдлөлийн эрсдэлийг үнэлэх нь эмхэтгэл. УБ., 1999;

## АВЛИГАЛД АЛБАН ХААГЧИЙН ХУВИЙН БОЛОН НИЙТИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

**М.ИНДРАБҮД** /ҮБХИС-ийн АБДС-ийн ЭЗМТ-ийн багш, докторант/  
**П.МӨНХТӨР** /ҮБХИС-ийн АБДС-ийн ЭЗМТ-ийн багш, докторант/

**Түлхүүр үг:** Нийтийн албан тушаалтан, авлига /хээл хахууль/, нийтийн болон хувийн ашиг сонирхол, эрх мэдлээ урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал

**Key words:** Public office worker, bribe, public and personal interest, abuse of power, conflict of interest, bureaucracy

**Оршил.** Дэлхийн улс орнуудын авлигатай тэмцэх байгууллагын тэргүүлэх чиглэл нь урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил байдаг. Авлигын эсрэг хуулийн 3 дүгээр зүйлийн 3.1.6-д “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гэж авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсоход чиглэгдсэн арга хэмжээний цогцолборыг хэлнэ” хэмээн заасан. 2016 онд Улсын Их Хурлын 51 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан бөгөөд уг хөтөлбөрийн нэг чухал зорилт бол шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх явдал бөгөөд энэ хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх зэрэг чиглэлээр авлигын эсрэг богино болон урт хугацааны, давтан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах гэх мэт олон арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Үндэсний хөтөлбөрт тусгагдсаны дагуу Авлигатай тэмцэх газар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгах чиглэлээр дотоод, гадаадын сайн туршлага, оновчтой шийдлийг сурталчлах, түгээх, нэвтрүүлэх ажлыг улам идэвхжүүлэн, энэ чиглэлээр иргэд, төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн

болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, шударга, ил тод, нээлттэй, хариуцлагатай, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ёс зүйтэй, мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэхэд олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх стратегийг баримтлан ажиллаж байна. Нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллаж, ард түмэнд үйлчлэх нь төр, засгийн газрын байгууллагын суурь зарчим, албан тушаалтны үндсэн үүрэг бөгөөд шударга, ил тод байдлыг хангах нь олон нийтийн итгэлийг бий болгоход чухал ач холбогдолтой гэж үздэг. Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй хэмээн хэн нэгнийг буруутгахыг урьтал болгохгүй тэдгээрийг зохицуулахыг чухалчлах, ялангуяа энэ талаар тодорхой бодлого боловсруулж хэрэгжүүлэх нь оновчтой шийдэл юм. Зохицуулаагүй ашиг сонирхлын зөрчил нь авлига болон бусад зөрчлийг үүсгэж болно. Иймд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлийг судалж, зохицуулах механизмыг тодорхой болгох, авилгаас сэргийлэх явдал нь өнөө цаг үед чухлаар тавигдаж байна.

**Судалгааны зорилго:** Авлигалд нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол зөрчил нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлоход оршино.

**ҮНДСЭН ХЭСЭГ.** Монгол улсын авлигын эсрэг хуульд зааснаар “Авлига” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох,

иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ<sup>1</sup>.

"Ашиг хонжоо" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг хэлнэ.

"Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах" гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг хэлнэ.

Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

1. Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
2. Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;
3. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;
4. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;
5. Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
6. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;
7. бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;
8. Эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;

9. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

Нийтийн ашиг сонирхлыг янз бүрээр авч үзэж болно. Либераль үзэл санааны үүднээс нийтийн ашиг сонирхол нь өмчтэй байх, үг хэлэх зэрэг хувь хүний суурь эрхүүдээс бүрддэг байхад утилитар үзлийн үүднээс үүнийг хамт олны сайн сайхан гэсэн утгаар авч үзэх ба сайн сайхан гэдгийг хамт олны бие даасан гишүүн бүрийн сэтгэл хангалуун байдал гэж үздэг. Хувь хүн өөрийн хүлээсэн үүргээ гүйцэтгэж, бусад хүмүүсийн өмнө хүлээсэн бусад үүрэг хариуцлагаа биелүүлэн нийтийн сайн сайхны төлөө зүй зохистойгоор үйлчилдэг бөгөөд мөн тодорхой үүрэг хүлээх шаардлагатай.

Нийтийн ашиг сонирхол нь хувь хүний ашиг сонирхол, эсхүл бүлгийн сонирхлоос ялгаатай хамт олны буюу ихэнхдээ төрийн ашиг сонирхлоос бүрдэж, байгууллагын цогц зорилготой уялддаг. Нийтийн ашиг сонирхол нь иргэншил, төр улсын үүрэг, орон нутгийн эрх ашгийн талаарх ойлголтуудтай үргэлж өрсөлдөж байдаг.

"Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар бичиг"-т "Нийтийн ашиг сонирхол гэдэг нь хувь хүмүүсийн тус тусын сонирхлын нийлбэр, эсхүл тухайн нэг бүлгийн сонирхол биш, харин нийт иргэдийн нийтлэг сонирхол юм гэж тодорхойлсон байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нийтийн ашиг сонирхол гэсэн нэр томъёог тодорхойлсон бөгөөд "нийтийн ашиг сонирхол" гэж "нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг" хэлнэ хэмээн тайлбарлажээ<sup>2</sup>.

Олон нийтийн итгэл гэдэг нь

<sup>1</sup> Монгол Улсын Авилгалын эсрэг хууль. 2006 он

<sup>2</sup> Авилгалтай тэмцэх газар. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь. гарын авалага. УБ., 2019



нийтийн ашиг сонирхлын төлөө тэгш, шударга үйлчилнэ гэж сонгогдсон төлөөлөгчдөдөө, томилогдсон албан тушаалтанд итгэх итгэл дээр иргэдийн хүлээлт суурилж байгааг хэлнэ. Улс төрчид өөрийнхөө, эсхүл хамаарал бүхий этгээд, нэгдмэл сонирхолтой этгээд, тодорхой бүлгийн төлөө үйлчилж байвал тэдгээрт итгэх иргэдийн нитгэл буурдаг. Засгийн газар олон нийтийн итгэлийг буцаан олж авахын тулд хөнгөн шуурхай, уян хатан ажиллагаатай болж, нийгэмд шударга ёсыг тогтоох үйл хэрэгтээ илүү идэвхтэй, шинэлэг байдлаар хандах шаардлагатай болж байна. Иргэд аливаа асуудалд зүгээр нэг ажиглагчийн байр сууринаас ханддаг байснаа больсны дээр төр, засаг өөрсдийнх нь төлөө ямар нэг юм хийж өгөхийг хүлээхээсээ илүү хүссэн зүйлийг нь хийж гүйцэтгэх боломж олгохыг хүсэх болсон байна.

Төр нь нийтийн ашиг сонирхлыг тодорхойлдог, яагаад гэвэл, хувь хүн, хамтын нийгэмлэгүүд өөрийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулдаг.

#### **Хувийн ашиг сонирхол.**

“Сонирхол” гэж хувь хүн, эсхүл бүлэгт нөлөөлж болох аливаа зүйлийг хэлдэг. “Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар бичиг”-т дурдсанаар “Хувийн ашиг сонирхол гэдэгт ажилтанд байж болох хувийн, мэргэжлийн, бизнесийн сонирхлоос гадна түүнтэй хувийн болон ажил төрлийн холбоотой хүмүүсийн сонирхлыг ойлгодог. Энд хамаатан садан, танил талыг нь хамруулж болно. Өөрөөр хэлбэл, хувийн ашиг сонирхол гэдэг нь тухайн ажилтанд ашиг хонжоо бий болгох, эсхүл хор хөнөөл учруулж болох хүмүүсийн, эсхүл бусдад ашиг хонжоотой, эсхүл давуутай бус байдал бий болгохыг зорьж байгаа тухайн ажилтны сонирхол юм. Ийм сонирхолд санхүүгийн бодит, эсхүл болзошгүй ашиг, алдагдал, өмч хөрөнгө, хувьцаа, төлөгдөөгүй зээл, эсхүл бэлэг сэлт, хангамж, үүний дотор ажил олгох, давхар ажил гүйцэтгэх явдал багтаж болно. Хувийн бусад сонирхол заавал

хөрөнгө мөнгөтэй холбоотой бус боловч тухайн ажилтны санаа бодол, шийдвэрийг өөрчилж болох хувийн болон гэр бүлийн харилцаа, спорт, соёлын үйл ажиллагаа мөн адил хамаарч болно” гэжээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “Хувийн ашиг сонирхол” гэж “Нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг” хэлнэ хэмээн тайлбарласан байна. Иймд ашиг сонирхлын зөрчлийг тайлбарлахын өмнө “Хамаарал бүхий этгээд”, “Нэгдмэл сонирхолтой этгээд”, “Ашгийн төлөө үйл ажиллагаа” зэрэг нэр томъёог ойлгох шаардлага гарч байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д “хамаарал бүхий этгээд” гэж “тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг”; тус хуулийн 3.1.6-д “нэгдмэл сонирхолтой этгээд” гэж “тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ” гэж, харин “ашгийн төлөө үйл ажиллагаа” гэж “Компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй зэрэг аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагааг” хэлнэ хэмээн тус тус тодорхойлсон.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар: “нийтийн ашиг сонирхол” гэж “нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг



сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг хэлнэ”

“Хувийн ашиг сонирхол” гэж “нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг хэлнэ.

**Нийтийн алба, албан хаагч.**

Хамгийн энгийн утгаар, төрийн албан хаагчийн хувийн сонирхол /заавал мөнгөн хэлбэртэй байх албагүй/, төрийн албаны үүрэг хоёр хоорондоо харшилж байгаа нөхцөл байдлын ашиг сонирхлын зөрчил гэж ойлгож болно. Хүн бүр өөрийн гэсэн хувийн амьдрал, хувийн үзэл бодол байдаг тул үүнтэй уялдан өөрийн гэсэн хувийн сонирхол ч бас байдаг. Энэ нь төрийн албан хаагчийн хувьд ч адил юм. Аливаа хувийн сонирхол нь эдийн болон эдийн бус, ашгийн сонирхлыг хамтад нь багтаадаг өргөн ойлголт. Иймд тухайн хүний хувийн сонирхол нь эрхэлж буй албан тушаал, гүйцэтгэж буй ажил, үүрэгтэй нь зөрчилдөж болзошгүй нөхцөлд ашиг сонирхлын зөрчил үүснэ гэж үздэг. Нийтийн албан хаагч гагцхүү хувийн сонирхолдоо автаж албан үүргээ биелүүлэхгүй байх, эсвэл албан тушаалын эрх мэдлээ зүй бусаар хэрэгжүүлбэл түүний хувийн сонирхол албан үүрэгтэй нь харшилж ашиг сонирхлын зөрчил үүсгэдэг байна. Ашиг сонирхлын зөрчлийн тухай олон янзын тодорхойлолт бий. Тухайлбал:

1. Трансперенси интернейшнл байгууллагын тодорхойлсноор “Ашиг сонирхлын зөрчил гэдэг нь төрийн албан хаагч төрийн ашиг сонирхолд болон улсын ашиг сонирхолд үйлчлэхээсээ илүү төрийн нэрийн өмнөөс өөрт олгогдсон эрх мэдлээ ашиглаж өөрийн үзэмжээр хувийн ашиг сонирхолдоо үйлчлэх нөхцөл байдлыг ойлгоно” гэжээ.
2. Олон улсын эдийн засгийн

хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зүгээс “төрийн албан хаагчаас үүргээ гүйцэтгэхэд албаны болон хувийн сонирхол зөрчилдөх буюу төрийн албан хаагчийн хувийн сонирхол нь албаны үүргээ гүйцэтгэхэд нь харшаар нөлөөлөхийг хэлнэ” гэжээ<sup>3</sup>. Ашиг сонирхлын зөрчлийн аль ч тодорхойлолтод дараах үндсэн гурван агуулга байна.



Төрийн албан хаагч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ “Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэх” амлалт авдаг. Албан ч олон нийтийн итгэл дээр үндэслэн гүйцэтгэдэг. Иймд амлалтандаа үнэнч байж, ард түмнийхээ итгэлийг алдахгүйн тулд түүний хувь хүнийх нь сонирхол нийтийн төлөө үйлсэд нь аливаа нөлөө үзүүлж болохгүй юм. Хэрэв албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн сонирхлын үүднээс хандаж олон нийтийн итгэл найдварыг хөсөрдүүлбэл энэ нь нийгмийн шударга ёсыг ганхахад хүргэнэ. Түүнчлэн, тухайн төрийн албан тушаалтан өөрийн бөгөөд гэр бүлийн гишүүн, ойрын хамаатан, төрөл садны хүмүүсийн эрх ашигт бага ч гэсэн үйлчилсэн, тэр нь төр, нийтийн эрх ашигт өчүүхэн төдий хохирол учруулаагүй байсан ч өндөр ёс суртахуунтай зарим улсад үүнийг ашиг сонирхлын зөрчилд тооцдог байна. Нөгөө талаас ашиг сонирхлын зөрчил нь авлигын сүүдэр, шалтгаан болдгийн хувьд улс орны эдийн засгийн хөгжил, ядуурлыг бууруулах, сайн засаглалыг хөгжүүлж, ардчиллыг бэхжүүлэхэд томоохон бэрхшээл учруулдаг байна. Тиймээс ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголтын үндсэн гол агуулга,

<sup>3</sup> Авилгалтай тэмцэх газар, АНУ-ын Азийн сан. Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээн таниулах ажлын гарын авлага

зарчим нь “Төрийн албан тушаалтны шууд болон шууд бус хувийн болон санхүүгийн сонирхол нь үнэн зөв, бие даасан шийдвэр гаргахад нь нөлөөлөхөөр байвал тухайн асуудлаар албан байр сууриа илэрхийлж болохгүй” байх явдал юм.

**Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д тодорхойлсноор “Төрийн алба гэж төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг хэлнэ.**

Нийтийн алба гэдэгт төрийн албыг бүхэлд нь хамруулан ойлгож болно. Тиймээс нийтийн алба нь нийт иргэдийн эрх ашигт нийцсэн төрөөс хэрэгжүүлж буй ажил, үйлчилгээ, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Дээр өгүүлсэнчлэн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1996 оны 51/59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан тушаалтны олон улсын ёс зүйн дүрэм”-д төрийн байгууллага нь нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллах итгэл даасан байгууллага байхаар заасан. Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “төрийн албан хаагч” гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг ойлгохоор заасан байна. Нийтийн албан тушаалтан бол арай өргөн хүрээний ойлголт юм. Нийтийн албан тушаалтан гэдэгт олон улсын нийтлэг практикт төрийн алба болон татвар төлөгчдийн бий болгосон төсвийн хөрөнгөтэй их, бага ямар нэгэн хэмжээгээр харилцдаг этгээдийг хамааруулан ойлгодог. НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 2 дугаар зүйлд: (а) “Нийтийн албан тушаалтан” гэж:

1. Оролцогч улсын хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны буюу шүү-

хийн албан тушаалд томилогдон буюу сонгогдон, байнга буюу түр хугацаагаар, цалинтай буюу цалингүйгээр ажилладаг аливаа хүнийг албан тушаалын зэрэглэлээс нь үл хамааран;

2. Оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид тодорхойлсны дагуу бөгөөд тухайн оролцогч улсын эрх зүйн холбогдох салбарт хэрэглэж байгаагийн дагуу нийтийн чиг үүрэг гүйцэтгэдэг, түүний дотор нийтийн байгууллага буюу улсын үйлдвэрийн газарт зориулж нийтийн чиг үүрэг гүйцэтгэдэг буюу нийтийн үйлчилгээ үзүүлдэг аливаа бусад хүнийг;
3. Оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид “нийтийн албан тушаалтан” гэж тодорхойлсон аливаа бусад хүнийг тус тус хэлнэ. Харин энэхүү конвенцийн II бүлэгт заасан зарим тодорхой арга хэмжээний зорилгоор “нийтийн албан тушаалтан” гэж оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид тодорхойлсны дагуу бөгөөд тухайн оролцогч улсын эрх зүйн холбогдох салбарт хэрэглэж байгаагийн дагуу нийтийн чиг үүрэг гүйцэтгэдэг буюу нийтийн үйлчилгээ үзүүлдэг аливаа хүнийг хэлж болно; 4 гэж тусгасан байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “нийтийн албан тушаалтан” гэж уг хуулийн 4.1-д заасан этгээдийг хэлнэ хэмээн тодорхойлсон байна. Харин дээрх хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д энэ хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтныг хамааруулахаар тусгасан бөгөөд уг зүйлд зааснаар дараах албан тушаалтан “нийтийн албан тушаалтан”-д хамаарна

Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, төрийн үйлчилгээний албаны удирдах албан



тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогчоос гадна улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтнууд, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн удирдлага, нийтийн эрх ашгийг илэрхийлж байгаа буюу үр ашгийг нь нийтээрээ хүртэх гадаадын техникийн туслалцаатай хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд ажиллаж буй удирдах албан тушаалтнуудыг нийтийн албанд хамааруулдаг.

**Ашиг сонирхлын зөрчил.** Бодит байдал дээр ашиг сонирхлын зөрчил бол үйлдэл биш харин нөхцөл бөгөөд төрийн албан тушаалтан сонирхлын зөрчлийн нөхцөл тулгарсан ч авлигад автахгүйгээр асуудлыг шийдвэрлэх боломжтой. “Ашиг сонирхлын зөрчил гэдэг ойлголт бол заавал буруу үйлдлийг хэлдэггүй харин буруу үйлдэл хийж болзошгүй байдлыг хэлдэг.” гэж судлаач эрдэмтэн W.Speck өгүүлсэн байдаг. Албан тушаалтны албан үүргээ гүйцэтгэх явцад нийтийн ашиг сонирхол түүний бусад сонирхлуудтай зөрчилдөх нөхцөл байдал үүссэн, үүсэж болзошгүй тийм байдал тулгарч болно. Ашиг сонирхлын зөрчил нь нийтийн албан тушаалтны албан үүрэг ба хувийн ашиг сонирхол хоорондын зөрчил бөгөөд албан тушаалтны хувийн ашиг сонирхол нь албан үүргээ гүйцэтгэх, үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд нь зохисгүй нөлөөлж болно.

Ашиг сонирхлын зөрчил



Ашиг сонирхлын зөрчлийн үр дагавар



Албан үүргээ шударгаар хэрэгжүүлэхгүй байх

Ашиг сонирхлын зөрчил гэсэн ойлголт нь нэг талаас нийтийн албан тушаалтны ёс зүйн асуудал, нөгөө талаасаа авлигын урьдчилсан нөхцөл, шалтгаан бөгөөд албан тушаалтныг ажил үүргээ гүйцэтгэхэд хувийн сонирхол нь зүй бусаар нөлөөлсөн үед авлига үүсдэг. Ашиг сонирхлын зөрчил нь авлига биш, харин авлига бий болох хөрс суурь, шалтгаан болдог. Өөрөөр хэлбэл, авлига бол ашиг сонирхлын зөрчлийн төгсгөлийн шат юм. Түүнчлэн авлига нь гэмт хэрэг бол ашиг сонирхлын зөрчил нь авлигатай харьцуулахад албан тушаалаа зүй бусаар ашиглан хувьдаа санхүүгийн ашиг олохгүй ч албан үүргээ танил тал харсан, алагчилсан байдлаар гүйцэтгэхэд хүргэдэг ихэвчлэн гэмт хэрэг болж хуульчлагдаагүй олон төрлийн зан үйлийн хэлбэрүүдийг багтаадаг.

Иймээс төрийн албан тушаалтны хувийн сонирхол албан үүрэгтэй зөрчилдөхөд үүнийг зөв тодорхойлж, зөв удирдаж, оновчтой зохицуулахгүй бол сонирхлын зөрчил нь төрийн нөөцийг урвуулан ашигласан хууль бус үйлдэл, авлига болдог байна.

Авлигын гэмт хэрэг гэж Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт зааснаар авлигын гэмт хэрэгт эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах, улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт үйлдлүүдийг хамруулна.


Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 2021 оны эхний 5 сард авлигын 154 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 (6.1 хувь)-аар буурчээ. Авлигын гэмт хэрэг өмнөх оны мөн



үеэс буурахад хахууль өгөх гэмт хэрэг 10 (58.8 хувь)-аар, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг 7 (77.8 хувь)-гоор, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 4 (3.3 хувь)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ. Харин 2021 оны 5 дугаар сард 25 авлигын хэрэг бүртгэгдсэн нь өмнөх сараас 23 (47.9 хувь)-аар буурсан байна. Бүртгэгдсэн авлигын хэрэг өмнөх сараас буурахад эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 11 (35.5%)-ээр,

хахууль авах гэмт хэрэг 9 (75.0%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ.


Бүртгэгдсэн 154 авлигын хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилахад 117 (74.1хувь) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 27 (17.1 хувь) нь хахууль авах гэмт хэрэг, 7 (4.4 хувь) нь хахууль өгөх хэрэг, 2 (1.3 хувь) нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, 5 (3.2 хувь) хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг байна.



Эх сурвалж: Статистикийн үндэсний хороо 2021 он

**Авлигын гэмт хэргийг сүүлийн 10 жилээр харуулбал:**

2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
101	110	106	135	128	111	150	362	523	8



Эх сурвалж: Статистикийн үндэсний хороо. гэмт хэргийн статистик 2020 он

**Авлигын гэмт хэргийг улмаас учирсан хохирлын хэмжээ:**

Авлигын гэмт хэрэг	Учирсан хохирол сая/төгрөг	
	2019 он	2020 он
Авлигын улмаас учирсан хохирлын хэмжээ	166.7	58.5

Авлигын гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн байдлыг авч үзвэл:

Анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн		Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн		Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэн	
Хахууль авах					
2020 он	2021 он	2020 он	2021 он	2020 он	2021 он
35	25	17	22	6	9
Хахууль өгөх					
15	8	9	13	3	7

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах механизмын үндсэн зорилго нь шийдвэрүүдийг зохих журмын дагуу хууль зүйн үндэслэлтэй, алдаагүй гаргахыг баталгаажуулах явдал юм. улс орнууд дараах гурван үндсэн зохицуулалтыг түлхүү ашигладаг.

1. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргуулах буюу албан тушаалтанд өөрийн сонирхлоо ерөнхийд нь, эсхүл шаардлагатай үед тохиолдлын буюу цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан мэдүүлэг гаргах үүрэг хүлээлгэх; 2. хориг тавих буюу албан тушаалтныг тодорхой үйл ажиллагаа эрхлэх, албан тушаал давхар гүйцэтгэх, бусад сонирхолтой байх зэргийг хориглох; 3. шийдвэр гаргах үйл явцаас тусгаарлах буюу сонирхлын зөрчилтэй нөхцөлд тухайн төрийн албан тушаалтныг шийдвэр гаргах болон бусад холбогдох үйл ажиллагаанд оролцуулахгүй байх, эсхүл албан тушаалтан өөрийгөө тусгаарлах гэх мэт. Эдгээр зохицуулалтыг үндсэндээ Төрийн албаны хууль, Сонирхлын зөрчлийн хууль, Ёс зүйн дүрэм гэсэн гурван хэлбэрээр дамжуулан хэрэгжүүлдэг. Гадаадын улс орнууд ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх болон шийдвэрлэх механизмыг тусгасан тусгай хууль, дүрэм журмыг баталсан байдаг. Зарим улсууд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон шийдвэрлэх цогц тогтолцоог бүрдүүлсэн, тухайлбал, Канад Улс 2006 онд Ашиг сонирхлын зөрчлийн тусгай хуулийг батлан мөрдөж байна.

Ихэнх улс ёс зүйн дүрмийг баталсан ч төрийн байгууллага бүр ёс зүйн дүрмээ илүү нарийвчлан гаргах нь зөв гэж үздэг. Жишээ нь, 2003 онд батлагдсан Кенийн Төрийн албан тушаалтны ёс зүйн хуульд ерөнхий дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, түүний дотор зан үйлийн дүрмийг зохицуулсан байдаг ба үүнээс гадна төрийн байгууллага бүр өөрийн дотоод дүрмийг батлах үүргийг хүлээлгэсэн байдаг. Их британи улсын хувьд төрийн албан хаагчид, сонгуульт албан тушаалтны асуудлыг ихэнхдээ

дүрмээр зохицуулдаг. Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахын тулд ямар механизмыг хэрэглэх нь тийм ч чухал биш байж магад. Гэхдээ байгууллагын үйл ажиллагааны онцлогийг дүрэм журамд тусгахын тулд ёс зүйн/зан үйлийн дүрэм бий болгох аргыг хэрэглэх нь чухал. Ес зүйн дүрэмтэй байх үүргийг НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын 8 дугаар зүйлд “оролцогч улс бүр нийтийн чиг үүргийг зөв, нэр төртэй, зохих ёсоор биелүүлэх ёс зүйн дүрэм буюу стандартыг өөрийн институтийн болон эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд хэрэглэхийг чармайна. Оролцогч улс бүр тогтоосон ёс зүйн дүрэм буюу стандартыг зөрчсөн нийтийн албан тушаалтанд сахилгын буюу бусад арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авах асуудлыг авч үзнэ” гэж заасан байдаг. Ёс зүйн дүрмийг заавал хуульчлах шаардлагагүй. Төрийн албанд ёс зүйн дүрэм нь албан тушаалтны хүлээсэн үүрэг болдог. Тухайлбал: өнгөрөгч 2020, 2021 онуудад бүртгэгдсэн 154 авлигын хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилахад 117 буюу 74.1 хувь нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 27 буюу 17.1 хувь нь хахууль авах гэмт хэрэг, 7 буюу 4.4 хувь нь хахууль өгөх хэрэг, 2 буюу 1.3 хувь нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, 5 буюу 3.2 хувь хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэх мэт гэмт хэрэг үйлдэгдсэн байна. Мөн анхан шатны шүүхээр 2018 онд 34, 2019 онд 50, 2020 онд 118 хүн ял шийтгэл авсан байна. Иймд дээрх байдалд үндэслэн дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Сонирхлын зөрчилтэй холбоотой нөхцөл байдлыг тодорхойлох. Ямар нөхцөл байдал, харилцаа нь сонирхлын зөрчилд хүргэж болох талаар тодорхой, бодитойгоор тодорхойлно.
2. Сонирхлын зөрчилтэй нөхцөл байдлыг тодорхойлох, удирдан зохицуулах, шийдвэрлэх журмыг бий болгох. Төрийн албан



- тушаалтнууд тэдний сонирхлын зөрчилтэй нөхцөл байдлыг тодруулах, мэдэгдэхэд шаардагдах зүйлсийг мэдэж байх ёстой
3. Удирдлагын зүгээс хүнд суртал гаргахгүй байх. Засаглалыг нээлттэй болгож нийгэмдээ бүх талаар үйлчилдэг, иргэдэд тэнцүү нөхцөл боломжийг бий болгох
4. Төрийн байгууллагад зан суртахууны зөв уур амьсгалыг бүрдүүлэх. Байгууллагад нөхөрсөг шударга уур амьсгал бүрдүүлэх Албадын ажлын үр ашгийг дээшлүүлэх. Удирдлагын арга барилыг оновчтой болгох соёлыг дээшлүүлэх, хүнд суртлыг багасгах.

#### Ашигласан материал:

1. Монгол Улсын "Авилгын эсрэг хууль". УБ., 2006 он
2. Монгол Улсын "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр" хууль. УБ., 2007 он
3. Монгол Улсын зөрчлийн тухай хууль. УБ., 2017 он
4. Үндэсний статистикийн хороо. Гэмт хэргийг статистик. УБ., 2020
5. Авилгалтай тэмцэх газар. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь. Гарын авлага. УБ., 2019 он
6. Авилагтай тэмцэх газар, АНУ-ын Азийн сан. Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээн таниулах ажлын гарын авлага
7. Авлигын зарим гэмт хэргийн эрх зүй, криминологийн асуудал. УБ., 2007 он
8. Ш.Батсүх. Төрийн захиргаа засаглал. УБ., 2017 он
9. А.Нанжид. Төрийн захиргаа. УБ., 2009 он
10. Д.Тунгалаг. Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй. УБ., 2012 он
11. Д.Дэмбэрэл. Ёс зүйт төр. УБ., 2011 он



## СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

**Б.БАНЗРАГЧ** /УБХИС-ийн АБДС-ийн НХТ-ийн ахлах багш, магистр/

**Түлхүүр үг:** Үндсэн үзүүлэлт, судалгаа, манлайлал, эрх мэдэл

**Key words:** Basic indicator, research, leadership, authority

**Оршил.** Өнөөдөр сурах үйл ажиллагаанд гарч байгаа өөрчлөлтийн нөлөөгөөр дээд боловсролын салбарын өмнө багш, оюутан, их, дээд сургуулийн уламжлалт харилцааг өөрчлөх шаардлага тулгарч байна. Нэг талаас их сургуулиуд бол нийгмийн нэгдэл нягтрал, эдийн засгийн хөгжилд нөлөөлж байдаг соёлын байгууллага байдаг гэсэн үзэл баримтлал байдаг бол нөгөө талаас улс орны эдийн засаг, нийгэм, улс төрийн зорилгыг хэрэгжүүлэх олон нийтийн үйлчилгээний байгууллага гэсэн үзэл баримтлал байдаг. Тэгвэл бид өнөөдөр улс орны нийгэм эдийн засгийн зорилгыг хангасан судалгааны их сургуулиудтай юу?, Судалгааны их сургууль гэж ер нь юу болох талаар бид хэр мэддэг вэ?, Тийм сургуулиуд байдаг ч хөгжилд нэмэр болсон харилцан уялдаат үйл ажиллагаа явуулдаг уу?, Бид хийж буй судалгааныхаа зүйлсийг хэрхэн үнэлдэг болоод сургалт, судалгааны нэгдмэл байдал буюу сургалтад судалгааны ажлыг хэрхэн хэрэглэдэг вэ? гэх мэт асуудлуудад хариулт өгөх зорилгоор уг өгүүлээ бичсэн.

**Сэдвийн үндэслэл:** Судалгааны их сургуулийн үндсэн үзүүлэлт гэх ойлголтуудыг их сургууль танин мэдэж өөрийн зохион байгуулалт, хөгжлийн үйл явц, зөв манлайлал, үр өгөөжийг хүртэх зорилго тавих юм. Энэ зорилгодоо хүрэхийн тулд дараах үндсэн хоёр зорилтыг дэвшүүлэн авч үзэж байна.

1. Судалгааны их сургуулийн үндсэн үзүүлэлтүүдэд ямар ойлголтууд багтдаг талаар авч үзэж, анализ хийх

2. Судалгааны их сургуулийн үндсэн үзүүлэлт нь манлайлал, эрх мэдлийн асуудалтай холбогдсоноор тогтвортой хөгжилд хэрхэн эергээр нөлөөлж болох талаар авч үзэх

### Судалгааны их сургуулийн үндсэн үзүүлэлтүүд.

Өнөө үед дээд боловсролд тавигдаж байгаа нийгмийн шаардлага бол насан туршийн боловсрол, судалгааны ажлыг амьдралтай холбох, мэдлэгийн түвшин дэх дээд боловсролын шинэ гүйцэтгэх үүрэг гэсэн үндсэн чиглэлүүдтэй байна. Мэдлэгийн зуунд дээд боловсролд цоо шинэ сорилтууд тулгарч байгаагийн нэг бол их, дээд сургуулиар олж авсан боловсролын зэрэг бол насан туршдаа ажил эрхлэх паспорт байхаа больж, харин хөдөлмөрийн зах зээлд орох эрхийн бичиг болж хувирч байна. Өөрөөр хэлбэл судалгааны их сургуулийн үндсэн үзүүлэлт (СИСҮҮ) нь өнөөдөр хэрхэн өөрчлөгдөж, тэдгээр нь их сургуулийн хөгжил, цаашлаад нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд хэрхэн эерэг нөлөө үзүүлж болохоор байгааг харуулж байна. Дэлхий нийтээрээ СИСҮҮ-ийг дараах ойлголтууд дээр авч үзэж байна. Үүнд:

1. “Авьяс, оюун ухааны цөм байх”. Судалгааны их сургууль байгуулах хамгийн гол нөхцөл бол, авьяаслаг, оюуны өндөр чадамж бүхий оюутнуудыг шилж сонгон оюутнаар элсүүлж, эрдэм шинжилгээний бүтээл туурвилаараа дэлхийд танигдсан эрдэмтэн профессоруудыг урьж ажиллуулж, улс орны тархи, цөм болгох явдал юм”<sup>1</sup>.

<sup>1</sup> Д.Бадарч. Дээд боловсролын онол, арга зүй. УБ., 2020. 224 дэх тал



Тухайн сургалтын байгууллага нь шилдэг суралцагчдыг шударга өрсөлдөөнөөр сонгон элсүүлэх, шилдэг багш нарын бүрэлдэхүүнийг бий болгох нь тухайн байгууллагын нэр хүнд, чадамжийг бүрдүүлж гадаад, дотоодын байгууллагуудтай өрсөлдөх боломж нөхцөлийг нээж хөгжилд хөтөлнө гэж үзэж болохоор байна.

2. “Академик эрх чөлөө ба удирдлага”. Академик эрх чөлөө бол их, дээд сургуулиуд тэр тусмаа судалгааны их сургуулийн оршин тогтнох зайлшгүй нэг нөхцөл юм. Судалгааны их сургуулийн засаглалын ерөнхий дүр зургийг харвал удирдлагын тогтолцоо нь улс төрөөс хамааралгүй, бие даасан, академик эрх чөлөөг дээдэлсэн, удирдлагын амин судас нь профессоруудын гарт байдаг, гол шийдвэрүүдийг эрдэмтдийн санал бодолд тулгуурлаж гаргадаг, гагцхүү мерит зарчимд тулгуурласан сонгон шалгаруулалт, томилгоо хийдэг байна. Судалгааны их сургуулийн бие даасан байдлыг хангахын дээр их сургуулийн хамт олныг хөтлөн авч явж чадах алсын хараатай удирдагч манлайлагчтай байх, амжилтад хүрэх философитой, байнга сурч, өөрчлөгдөж байх орчин уур амьсгалыг бий болгох зэрэг нь чухал ач холбогдолтой болохыг олон улсын жишээ баримт харуулжээ”<sup>2</sup>.

Академик эрх чөлөө бол орчин үеийн их сургуулийн нэг үндсэн зарчим бөгөөд их сургуулийн багш нар судалгааны ажлаа чөлөөтэй хэвлэн нийтлүүлэх, үг хэлэх, бичих, сургалтын үйл ажиллагаагаа явуулахад сургалтын байгууллагын хяналт, цензурээс хамааралгүй байх нь их сургуулийн нэг үзүүлэлт болж багш, суралцагчдыг тогтвортой хөгжлийн үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг болох юм. Жишээ нь: Их сургуулийн багш ямар байдлаар судалгаа хийх үүрэгтэй вэ? Тэгэхлээр профессор багш судалгаа шинжилгээний ажилд тэргүүлэх чиглэлийн үүрэгтэй бөгөөд

тэр үүрэг нь академик байдлаар өөрт ухамсарлагдсан дотоод хөгжлөөр л илэрхийлэгддэг. “Судалгааны үйлд хувь нэмрээ оруулах нь шинэ мэдлэг бий болгон түгээн дэлгэрүүлж, өөрийн шинжлэх ухааны чиглэлд ахиц дэвшил бий болгохыг хэлнэ”<sup>3</sup> гэсэн нь академик эрх чөлөө, хамтын удирдлагыг бүтээн дэмжих нь ихээхэн ач холбогдолтой гэдгийг хэлээд байгаа юм.

3. “Хөрөнгө санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байх”. Судалгааны их сургуулийн үйл ажиллагааны санхүүжилтийг гол төлөв 4 эх үүсвэрээр хангадаг. Нэгд, төрийн санхүүжилт нь судалгааны их сургуулийн үндсэн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрэн хангасан байдаг. Тухайлбал, багш нарын цалин хөлс, тогтмол зардал, суурь судалгааны санхүүжилт энд хамрагдана. Хоёрт, эрдэм шинжилгээний сан, төрийн болон хувийн сектороос эрдэм шинжилгээ, судалгааны ажил, төслийг санхүүжүүлэх хөрөнгөөс бүрдэнэ. Гуравт, эндаумент тусгай зориулалттай хуримтлалын сан байдаг. Энэ нь их сургуулийн тодорхой үйл ажиллагаа, тухайлбал шилдэг багшийг урамшуулах шагналын фонд байгуулах, тодорхой судалгааны ажлыг дэмжих, их сургуульд номын сан барих, лаборатори байгуулах зэрэг зорилгоор ивээн тэтгэгчдийн хандивласан хөрөнгө, тэдгээр хөрөнгийн хүүгээс бүрддэг. Дөрөвт, суралцагчдын сургалтын төлбөрөөс бүрддэг. Хамгийн нэр хүндтэй, хамгийн сайн эрдэмтэн багштай, орчин үеийн лабораторийн баазтай их сургуульд суралцсанаар төгсөөд хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэн болох учраас судалгааны их сургуулийн сургалтын төлбөр бусдаас өндөр байсан ч түүнийг төлөх хүсэлтэй эцэг эхчүүд, оюутнууд олон гардаг”<sup>4</sup>.

Судалгааны их сургуулийн энэ үзүүлэлтэд их сургуулиуд анхаарал хандуулж хөгжлийнхөө төлөө хэрхэн өөрийн гэсэн санхүүжилттэй болсноор

<sup>2</sup> Мөн тэнд

<sup>3</sup> Тогтвортой хөгжил-Дээд боловсрол улсын хоёрдугаар зөвлөгөөн. УБ., 2018

<sup>4</sup> Д.Бадарч. Дээд боловсролын онол, арга зүй. УБ., 2020. 225 дахь тал

тухайн сургуулийн хөгжил бий болох талаар боломжийг эрэл хийж ажиллаваас судалгаа шинжилгээний ажлаа үйлдвэрлэлд нэвтрүүлж нэмэлт хөрөнгийн эх үүсвэрийг бий болгож санхүүжилтийн хувьд бие даасан чадамжтай болох ач холбогдолтой юм.

4. “Судалгаа сургалтын уялдаа холбоо”. Судалгааны их сургуулиуд нь судалгааны ажлыг сургалттай холбоход ихээхэн анхаарал хандуулдаг. Эрдэм шинжилгээний ажилд магистр, доктор оюутнуудыг оролцуулан, тэдний мэдлэг чадварыг гүнзгийрүүлж сургалт, эрдэм шинжилгээний ажлын уялдаа холбоог бататгахын дээр ахисан түвшний оюутнуудыг сурсан мэдсэнээ амьдрал дээр хэрэглэх боломжоор хангадаг байна. Түүнээс гадна доктор оюутнууд нь бакалаврын түвшний оюутнуудын семинарын хичээлийг удирдах замаар хүнтэй ажиллах дадлага олж авч, бүтээлч сэтгэхүйгээ хөгжүүлж байдаг байна. Судалгааны их сургуулийн нэг үзүүлэлт бол бэлтгэн гаргаж байгаа магистр, докторын зэрэгтэй мэргэжилтний тоо, тэдгээрийн бүтээл байхын зэрэгцээ төгсөгчдийн ажил эрхлэлт, бүтээл туурвил зэрэг нь чухал үзүүлэлт болж өгдөг<sup>5</sup>.

Судалгаа бага явуулдаг зөвхөн сургалтад төвлөрсөн их, дээд сургуулиуд Монгол Улсад олон байгаа нь сургалт, судалгааны уялдаа холбоог орхигдуулж судалгааны үнэ цэнийг үл ойлгохуйд хүрсэн байна. Судалгаан дээр суурилж сургалтын хөтөлбөрөө өөрчилж, тасралтгүй сайжруулж байж бид судалгаа, сургалтын уялдаат их сургуулийг бий болгох боломжтой гэсэн үзүүлэлт бол СИС-ийн нэг чухал үндсэн үзүүлэлт болдог байна.

5. “Шинжлэх ухааны хэл”. Дэлхий дахины хөгжлийн үе шат бүрд онцгой үүрэг гүйцэтгэж иржээ. Европын эртний их сургуулиудад шинжлэх ухааны гол хэл нь латин хэл байсан бол Наполеоны үеэс франц хэл ноёрхож эхэлсэн байна. Судалгааны сургуулийг үнэлэх нэг

үзүүлэлт бол дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд нийтлүүлсэн бүтээл, түүнээс эшлэл татсан тоо ордог. Иймээс шинжлэх ухааны орчин үеийн хэл болсон англи хэл дээр бүтээлээ туурвиж олон улсын тусгай шүүлттэй сэтгүүлүүдэд хэвлүүлэх нь судалгааны их сургуулийн нэг үндсэн ажил болох учиртай<sup>6</sup>.

“1.3.1.боловсролыг хөгжүүлэх бодлого, стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, мэргэжлийн холбоо, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, иргэний оролцоог хангах;”<sup>7</sup> хэмээн төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод заасан нь багш сургахуй болон судалгааны үйл ажиллагаандаа дэлхийн хэмжээний шинжлэх ухааны хэлийг эзэмшихэд өөрсдийн санаачилга болон ямар нэгэн хувийн болон төрийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр тэр хөгжлийн үзүүлэлтийг бий болгох юм. Жишээ нь: Гадаад хэл дээр сургахуйн үйл ажиллагаа явуулах боломжтой багшийн тоо манай орны хувьд бусад орны сургуультай харьцуулахад харьцангуй цөөн байгаа нь хувь хүний хөгжилд өөрсдөө анхаарах шаардлагатай болсныг илтгэж буй. Нийгмийн болон хувь хүний боловсрох хэрэгцээний хувьслыг цаг алдалгүй мэдэрч хандлага сэтгэлгээгээ өөрчлөх нь зохистой юм.

6. “Дэлхийн түвшний судалгааны их сургуулийн соёл, уур амьсгал бүрдүүлэх”. Судалгааны их сургууль бол дэлхийн хэмжээний аль ч судалгааны их сургуулиудтай “нэг хэл дээр төвөггүй ярьдаг”, “ижил төстэй орчин, уур амьсгал, соёл”-той их сургууль байх ёстой. Ийм соёлыг бүрдүүлэхэд их сургуулийн зүгээс, профессор багш нарын зүгээс ихээхэн хүч чармайлт гаргах ёстой. Их сургуулийн зүгээс судалгааны ажил явуулах нөхцөлийг бүрэн хангах, түүний үр дүнг тооцох,

<sup>5</sup> Д.Бадарч. Дээд боловсролын онол, арга зүй. УБ., 2020. 225 дахь тал

<sup>6</sup> Мөн тэнд

<sup>7</sup> Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он). УБ., 2014

эрдмийн ажлын туршлагатай ахмад эрдэмтэн профессоруудыг өөрсдийнх нь хүслийг харгалзан их сургуульдаа сургалт, судалгааны ажил эрхлэх боломжоор хангах, гадаадын эрдэмтдийг өөртөө татах нөхцөлийг бүрдүүлэх, зөвхөн тухайн хүний авьяас чадвар, туршлага мэдлэгийг үндэслэн ажилд авах, албан тушаалд дэвшүүлэх, шагнал урамшил олгох, профессор багш нарын болон оюутан сурагчдад авлига, аливаа дарамт шахалт үзүүлэхээс ангид байж, шударга өрсөлдөөн, оюун ухааны уралдааныг хөхүүлэн дэмждэг орчин, ёс зүйн хэм хэмжээ, соёлыг бий болгох үүрэгтэй.

### **Судалгааны их сургуулийн үндсэн үзүүлэлт нь манлайлал, эрх мэдлийн асуудалтай холбогдох нь**

Дээд боловсролын өөрчлөлт өөрөө хийгдэхгүй түүнийг хөтлөн манлайлж, эрх мэдлийн зохист хэлбэрээр бий болгоно. Өндөр мэдлэг, ур чадвар бол сайн манлайллын нэг чухал үзүүлэлт бөгөөд сайн манлайлагч бол судалгааны их сургуулийн үндсэн үзүүлэлтийг хөтөлж явахаас гадна шинэлэг зүйлсийг үргэлж сонсдог манлайлал байх ёстой.

Академик эрх чөлөө буюу бие даасан байдал, хүчтэй удирдлага, стратегийн болон системийн сэтгэлгээ, олон улсын хамтын ажиллагаа, өрсөлдөх соёл, шинэ санаа, төрийн болон хувийн санхүүжилт, судлаач багш зэрэг асуудлуудыг оновчтой, үр өгөөжтэй хэрэгжүүлэхийн тулд СИСҮҮ-үүдээр дамжуулж зөв манлайлж дэлхийн түвшний судалгааны их сургууль гэсэн статус дээр очих юм. Ингэхийн тулд бид эхлээд судалгаа, сургалтын байгууллага дахь эрх мэдэл, удирдлага гэдэг ойлголтыг зөвөөр ойлгож байж амжилтад хүрэх юм. Их дээд сургуульд эрх мэдлийн төлөө өрсөлдөх явдал их байдаг гэж судлаачид үздэг. Эрдмийн цол авч байр сууриа бэхжүүлэх, дор хаяж тэнхим нэгжийн эрхлэгч болж албан тушаалын шатлал ахих өрсөлдөөнд

өөрийгөө бэлтгэх зэргээр эрх мэдлийн төлөөх тэмцэлдээн их тохиолддог. Улс төр дээд боловсролд хөндлөнгөөс хутгалдсан үед эрх мэдлийн төлөөх тэмцэл шударга бус байдлаар ихэсдэг. Боловсрол судлаачид хэлэхдээ: хувийн сектор давамгайлсан ашгийн төлөөх хувийн байгууллагуудыг бодвол хүмүүнлэг шинж чанарыг эрхэмлэсэн, үнэний төлөө эрэл хайгуул хийж, эрдэм мэдлэгийг дээдэлсэн оюун эрдмийн төв байдаг их сургуулийн хувьд эрх мэдлийн төлөөх тэмцэлдээн бол их сургуулийн эрхэм нандин зүйлийг гутааж байдаг хэмээн үзээд байгаа юм.

“Их сургуулийн боловсрол гэдэг бол мөнгөөр худалдаж авахаас өөр буюу хувь хүний чадвар, судалгаа, хүсэл зориг дээр тулгуурлаж олж авч буй мэдлэг”<sup>8</sup> гэж Б.Рассел “On Education” хэмээх зохиолдоо бичсэн байна. Өөрөөр хэлбэл Б.Рассел зөв манлайлал, тэгш шударга эрх мэдлийн хуваарилалттай үед судалгаа, сургалт явуулагчид болон суралцагчид судалгааны их сургуулийн үндсэн үзүүлэлтүүдээс суралцах явцдаа үр ашгийг нь хүртэж үндсэн зорилгодоо хүрч байна хэмээн үзсэн.

### **Дүгнэлт**

Судалгааны их сургуулийн үндсэн үзүүлэлтүүдэд гэж ямар ойлголтууд байдаг, тэдгээр нь судалгааны сургуулийн суурь үндэс болох, мөн энэ үзүүлэлтүүд нь тухайн байгууллагын үр өгөөжтэй манлайлал, удирдлагын зөв эрх мэдэлтэй салшгүй холбоотой бөгөөд орчин үеийн их сургуулийн хөгжил нь судалгааны их сургуулийн үндсэн үзүүлэлтүүдийг баримталж сургалт, судалгаа, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулснаар илэрхийлэгдэх юм. Энэ илтгэлд авч үзсэн зургаан үндсэн үзүүлэлт бүр шинэ санаа, шинийг эрэлхийлсэн, мөн чанараараа сургуулийн цаашдын хөгжлийн асуудлуудыг агуулсан нь ач холбогдолтой юм.

Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлага байнга өсөж, мэргэжлийн чиглэл өөрчлөгдөж, цоо

<sup>8</sup> Bertrand Russell. On Education. 2010. India., P. 25



шинэ ур чадварын хэрэгцээ өсөж, шинэ технологи түүний дотор хиймэл оюун хүчтэй хөгжиж байгаа нөхцөлд одоо байгаа дээд сургуулийн зохион байгуулалтыг өөрчилж СИС-ийн үндсэн

үзүүлэлтүүдийг манлайллын түвшинд хэрэглэх, ойлгох, үйл ажиллагаандаа дадал хэлбэрт оруулснаар бид дэлхийн хэмжээний судалгааны их сургуулийн түвшинд дөхөж очих болно.

#### **Ашигласан материал:**

1. Bertrand Russell. On Education. 2010., India
2. Д.Бадарч. Дээд боловсролын онол, арга зүй. УБ., 2020
3. ШУА философийн хүрээлэн. Тогтвортой хөгжил ба оюуны соёлын өв (ЭШБХ-ын эмхэтгэл). УБ., 2019
4. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он). УБ., 2014



## ЦЭРГИЙН РАДИОСТАНЦЫГ СОНГОХОД АНХААРАХ ЗАРИМ ЧУХАЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**Т.ЭНХЗАЯА** /УБХИС, ЦНДС-ийн ЦХКАБТ-ийн багш, магистр, хошууч/  
**Г.НЯМХҮҮ** /УБХИС, ЦНДС-ийн ЦХКАБТ-ийн багш магистр, дэд хурандаа/

**Түлхүүр үг:** Радиостанц, холбоо, аналог, тоон  
**Key words:** Radio stants, communication, analogy, digital

**Оршил.** Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн холбооны үндсэн төрлийн нэг бол радио холбоо юм. Цахилгаан соронзон долгионы тусламжтайгаар мэдээллийг агаарын орон зайн нэг цэгээс мэдээний эх булгаас\ нөгөө рүү нь мэдээлэл гардан авагч руу тодорхой зайд дамжуулж солилцоо үйлдэхийг радио холбоо гэнэ. Түүнд ашиглагдаж байгаа хэрэгслийг радио холбооны хэрэгсэл юм. Радио холбоо нь захирагч нар, штабуудын хооронд байран дээр хөдөлгөөн дунд холбоогоор хангах, газар орон нь үл мэдэгдэх болон эсрэг талд бүслэгдсэн харилцагч, эсвэл нэвтэрч үл болох газар районыг алгасан холбоо тогтоох, нэгэн зэрэг олон харилцагчдад нэвтрүүлэг явуулах боломжуудыг олгодог ашигтай талтай учир цэргийн удирдлагын үндсэн хэрэгслүүдийн нэг болохоос гадна зарим онцгой тохиолдолд цорын ганц хэрэгсэл нь болдог<sup>1</sup>.

Ийм учраас цэргийн радио холбооны станцыг сонгохдоо түүний техник үзүүлэлтэд онцгой анхаарах хэрэгтэй.

**Үндсэн хэсэг:** Радио нэвтрүүлэгч болон хүлээн авагчийн хосломжийг радиостанц гэнэ.

Цэргийн радиостанцыг сонгохдоо

дараах техник үзүүлэлтэд онцгой анхаарал хандуулах ёстой.

1. Ажлын давтамжийн цараа
2. Гаралтын чадал
3. Холбоо барих зай
4. Мэдрэх чадвар
5. Сонгох чадвар
6. Антенний төрөл
7. Тасралтгүй ажиллах хугацаа
8. Жин

### 1. АЖЛЫН ДАВТАМЖИЙН ЦАРАА (FREQUENCY RANGE, АНГЛИ; ДИАПАЗОН ЧАСТОТ, ОРОС)

Радио нэвтрүүлэгч төхөөрөмж нь ажлын давтамж дээрх хувиргагдсан радио долгионыг ялгаруулах, хүлээн авах төхөөрөмж нь уг дохиог “таньж” тодорхой шинж чанар бүхий дохио болгон хувиргах боломжийг олгож өгдөг давтамжийн хүрээ юм. Давтамжийн цараа нь түүний зорилго, давтамжийн нарийвчлалд тавигдаж буй шаардлагаар тодорхойлогддог бөгөөд тухайн үйл ажиллагааны нөхцөлд тохируулан холбоо барих шаардлагатай зайг хангаж өгдөг.

Олон улсын цахилгаан холбооны байгууллагын журмын дагуу радио долгионыг дараах цараад хуваадаг.

#### Радио давтамжийн цараа,

#### долгионы урт

N	Давтамжийн төрөл	Давтамжийн цараа	Долгионы урт	Зориулалт
Хэт урт долгион				
1	Туйлын нам давтамж (Extremely low frequency, ELF)	3 – 30 Гц	10000-10000 км	Геофизик судалгаанууд, шумбагч онгоцтой холбоо тогтоох
2	Супер нам давтамж (Super low frequency, SLF)	30 – 300 Гц	10000-1000 км	

<sup>1</sup> Зэвсэгт Хүчний радио холбоо, компьютер мэдээлэл харилцааны заавар, Улаанбаатар хот 2018 он



3	Ультра нам давтамж (Ultra low frequency, BLF)	0.3 - 3 кГц	1000-100 км	Геологи хайгуулын эрдэм шинжилгээний ажил, соронзон мандал
4	Хэт нам давтамж (Very low frequency, VLF)	3-30 кГц	100 - 10 км	Газар доорх, усан болон агаарын холбоо
Урт долгион				
5	Нам давтамж (Low frequency, LF)	30 - 300 кГц	10 - 1 км	Цаг агаарын мэдээлэл дамжуулах, хол зайд холбоо барих, радио нэвтрүүлэг
Дунд долгион				
6	Дундаж давтамж (Medium frequency, MF)	300 - 3000 кГц	1000 – 100 м	Цаг агаарын мэдээлэл дамжуулах, хол зайд холбоо барих, радио нэвтрүүлэг
Богино долгион				
7	Өндөр давтамж (High frequency, HF)	3 - 30 МГц	100 - 10 м	Радио холбоо, иргэний агаарын тээвэр
Хэт богино долгион				
8	Хэт өндөр давтамж (Very high frequency, VHF)	30 - 300 МГц	10 - 1 м	Орчин үеийн радиостанц, иргэний агаарын тээвэр, телевиз
9	Ультра өндөр давтамж (Ultra high frequency, UHF)	300 - 3000 МГц	100 - 10 см	Орчин үеийн радиостанц, радиорелей, хиймэл дагуулын холбоо, телевиз, гар утас
10	Супер өндөр давтамж (Super high frequency (SHF)	3 - 30 ГГц	10 - 1 см	Радиорелей, хиймэл дагуул, сансрын холбоо, нисэх буудлын радиолокаци, Wi-Fi
11	Туйлын өндөр давтамж (Extremely high frequency, EHF)	30-300 ГГц	10-1мм	Радиоастрономи, цаг агаарын локатор, эрдэм шинжилгээний судалгаа
12	Гипер өндөр давтамж (Terahertz radiation)	0.3-3ТГц	1-0.1мм	Туршилтын терагерц камер, судалгааны ажлууд

Радиостанцууд ихэвчлэн дараах цараад ажилладаг.

### Өндөр давтамжийн цараа

Энэ цараад тархаж буй долгионууд ионосфер (тэнгэр)-ээс ойж, дэлхийг тойрон, олон мянган км-т тархах чадвартай. Бага чадал, богино антеннтай зөөврийн радиостанцуудын хувьд энэ цараа тохиромж муутай байдаг. Учир нь богино антенн нь богино долгионуудыг үр ашигтай хүлээж авах боломжгүй ба чадал бага байх нь ойсон дохиог газар руу буцаах хангалттай хүч үүсгэж чаддаггүй. Энэ цараа нь урт антеннтай суурин радиостанцад тохиромжтой. Радио долгионы тархалтын өвөрмөц онцлогоос шалтгаалан шигүү ой болон бартаат газар холбоо барих зай хангалттай сайн байдаг. Энэхүү царааг тээврийн хэрэгслийн жолооч нар хоорондоо харилцах, замын

хөдөлгөөний нөхцөл байдал, ослын болон саатлын талаар мэдээлэл солилцох, маршрут сонгох, бие биедээ туслах зорилгоор ихэвчлэн ашигладаг.

#### Давуу тал:

- Их хол зайд болон хүндрэлтэй орчинд (ой мод, уул, говь) холбоо барихад нэн тохиромжтой;

- Хямд үнэ өртөг.

#### Сул тал

- Овор хэмжээ харьцангуй том;

- Том антен.

Энэ цараад 26-30 МГц-ын цараанд ажилладаг тусгай зөвшөөрөл шаарддаггүй СВ (Citizen Band) цараа хамаардаг байна.

### Хэт өндөр давтамжийн цараа

Хөдөлгөөнт болон үүргэвчийн радиостанцад илүү тохиромжтой.

- VHF I - 136-174 МГц;

- VHF II - 200-250 МГц-ийн

давтамжийн цараанд ажиллана.

**Давуу тал:**

- Холбоо барих зай сайн, ялангуяа хотын гадна;

- Бартаатай газар болон ой модонд сайн холбоо хангана;

- UHF цараатай харьцуулахад холбоо барих зай 20 орчим хувиар илүү.

**Сул тал:**

- Энэ цараанд үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл шаардлагатай. Зөвшөөрөлгүй тохиолдолд тухайн царааг ашиглахыг хориглодог;

- Радио сонирхогчдод давтамжийн нарийн зурвас оногдоно (144-146 МГц);

- UHF цараа радиостанцтай харьцуулахад антенны хэмжээ том.

**Ультра өндөр давтамжийн цараа**

Богино антеннтай гар радиостанцад илүү тохиромжтой.

- UHF I - 350-400 МГц;

- UHF II - 400-450 МГц;

- UHF III - 450-470 МГц;

- UHF IV - 470-510 МГц-н

давтамжид ажиллана.

**Давуу тал:**

- Ус болон ууланд холбоо сайн барина;

- Антенн харьцангуй богино;

- Энэхүү цараад ажилладаг радиостанцуудын жин болон овор хэмжээ бага;

- LPD (Low Power Device. 433,075 – 434,775 МГц) ба PMR (Personal Mobile Radio, 446,00625–446,09375 МГц) тусгай зөвшөөрөлгүй давтамжийн зурвастай;

- Энэ цараад ажилладаг радиостанцууд илүү түгээмэл байдаг учраас олон тооны хэрэглэгчидтэй холбоо хангаж болно;

**Сул тал:**

- Ой модонд холбоо барих зай бага.

Одоогоор манай улсад VHF1–136-174 МГц, UHF2–400-450 МГц, UHF3–450-470 МГц давтамжууд ашиглагддаг.

Ямар цараа хамгийн тохиромжтой вэ? гэсэн асуулт гарч ирнэ. Нэг талыг баримталсан хариулт өгөх боломжгүй юм. Учир нь радио холбооны чанар, холбоо барих зай нь янз бүрийн нөхцөл

байдлаас шалтгаалан өөр өөр байж болно. Тусгай зөвшөөрөлтэй цараад холбооны чанар илүү сайн байдгийг олонтоо тогтоосон. Сүүлийн үед 2 цараад ажилладаг радиостанцууд илүү түгээмэл болж байгаа бөгөөд эдгээр радиостанцууд ямар ч нөхцөлд радио холбоогоор хангаж чадна. Хэрвээ 2 цараад ажилладаг радиостанцаар хангагдах боломжгүй бол UHF 400-520 МГц-ийн цараад ажилладаг радиостанц ашиглах нь зөв сонголт болж байна. Хэрвээ HF (136-174 МГц) –ийн радиостанцууд ой модонд илүү сайн холбоо барьдаг бол бусад газар (хээр тал, зам, уул, хот) UHF 400-520 МГц-ийн радиостанцууд илүү сайн холбоо хангана. Үүнээс гадна тусгай зөвшөөрөлгүй бүх давтамжууд UHF 430-450 МГц-ийн цараад байдаг.

Технологи хөгжихийн хирээр давтамжийн цараа мөн аажмаар өндөрсөж байна. Өндөр давтамжтай цахилгаан соронзон долгионы хэрэгцээ нэмэгдэж байгааг дараах 2 шалтгаанаар тайлбарлаж байна:

1. Цахилгаан соронзон хэлбэлзлийн давтамж өндөр байх тусам давтамжийн ажлын зурвас өргөн байх болно. Тухайлбал, дунд долгионы радио нэвтрүүлгийн цараа 0.3-3 МГц хооронд байрладаг бөгөөд царааны өргөн нь 2.7 МГц байдаг. Мэдээж, энэ цараад 6 МГц-ын ажлын зурвасын өргөнтэй телевизийн нэвтрүүлгийг дамжуулах боломжгүй. Харин өргөн ажлын зурвастай, телевизийн хэдэн арван суваг байрлуулах боломжтой супер өндөр давтамж илүү тохиромжтой.
2. Радио долгионы цацрагийн тарах өнцөг нь долгионы урттай пропорционал харин дамжуулагч антенны хэмжээтэй урвуу пропорционал байдаг. Антенны хэмжээ ижил байхад илүү нарийн цацраг олохын тулд хэлбэлзлийн долгионы уртыг багасгах хэрэгтэй болно.



## **2. ГАРАЛТЫН ЧАДАЛ (OUTPUT POWER, АНГЛИ; ВЫХОДНАЯ МОЩНОСТЬ, ОРОС)**

Радиостанцын холбоо барих зай, тэжээлийн төрөл, хүлээн авагчийн овор хэмжээ, болон найдвартай байдалд нөлөөлдөг чухал үзүүлэлтүүдийн нэг юм. Гаралтын чадлыг ваттаар (Вт) хэмждэг. Зарчмын хувьд радиостанц илүү их чадалтай байх тусмаа сайн байх болно гэж ойлгогдож болох юм. Гэхдээ радиостанцыг чадлын хувьд сонгохдоо дараах нэмэлт зүйлсийг анхаарч үзэх хэрэгтэй:

-Зарим тусгай зөвшөөрөлгүй давтамжийн цараад (зурвас) радиостанцын чадлыг хязгаарладаг. Тухайлбал, СВ-4 Вт, LPD - 10 Вт, PMR - 0.5 Вт гэх мэт;

- Чадал их байх тусам радиостанцын хэмжээ, жин ихсэж, зайны цэнэг төдий чинээ их зарцуулагдана;

- Радиостанцад шаардагдах чадал нь түүнийг ашиглаж байгаа газрын нөхцөлөөс хамаарна. Тухайлбал шилмүүст ойд 6 ваттын чадалтай радиостанц 10км хүртэлх зайд холбоог хангаж чаддаг бол навчит ойд энэ радиостанц 6-7км-ээс хэтрэхгүй байх магадлалтай.

## **3. ХОЛБОО БАРИХ ЗАЙ (DISTANCE RANGE, АНГЛИ; ДАЛЬНОСТЬ СВЯЗИ, ОРОС).**

Хүлээн авагч ба нэвтрүүлэгчийн хооронд мэдээлэл солилцох хамгийн хол зайг хэлнэ. Холбоо барих зай нь нэвтрүүлэгчийн чадал ба хүлээн авагчийн мэдрэх чадвар, синтезаторын (өдөөгч, гетеродин) давтамжийн тогтвортой байдал, радио дохионы давтамж, антенны өндөр (антенны өндрөөс гадаргуу дэх радио дохионы шингээлт) зэргээс хамаарна. Антенн өндөр байх тусам радио долгион илүү чөлөөтэй зайд тархаж, дохионы сулрал багасна. Антенны чиглэл нь радио дохио тархаж буй нөхцөл байдлаас шалтгаална. Үүнээс гадна холбоо барих зай нь холбоо явагдаж буй газар нутгийн онцлог, тухайн үеийн нөхцөл байдлаас ихээхэн шалтгаална.

Тухайлбал шилмүүст ойд, 6-8 ваттын чадалтай, 430МГц-ийн цараад ажиллаж байгаа радиостанцын холбоо барих зай 7-10км хүрнэ. Шилмүүст ойд холбоо барих зай нь ойн нягтрал, өөрөөр хэлбэл мод хоорондын зай ба агаарын чийгшлээс ихээхэн хамаарна. Харин навчит эсвэл холимог ойд өвс ногоо өтгөн шигүү ургасан нөхцөлд энэхүү радиостанцын холбоо барих зай нь 5-7км болж буурна. Хэрэв толгод, жалга бүхий ой байвал холбоо барих зай улам багасах бөгөөд аль нэг харилцагч жалга руу буувал холбоо бүрэн тасрах магадлалтай. Хээр тал ялангуяа толгодоос толгодын хооронд холбоо барих зай 20-30км хүрдэг бол нэг нь толгод дээр нөгөө нь жалганд байрлаж байх үед холбоо барих зай 7-10км байдаг байна. Шулуун гол дагуу холбооны радиус 10км хүрдэг. Том нуурууд дээр радиог усны түвшингээс өндөр байлгах юм бол холбоо барих зай 30км хүрч чаддаг. Радиостанцын холбоо барих зайг нэмэгдүүлэхийн тулд нэмэлт антенн ашиглаж болно. Ихэвчлэн эдгээр антеннууд харьцангуй урт (36-48см) байх боловч холбооны чанар, холбоо барих зайг мэдэгдэхүйц сайжруулна.

Дүгнэн хэлэхэд холбоо барих зай дараах 3 хүчин зүйлээс шалтгаалдаг байна.

### **1. Дотоод хүчин зүйлс:**

- Аккумуляторын (батарей, зай) цэнэгийн байдал. Зайны цэнэг дуусаж байвал холбоо барих зай мэдэгдэхүйц буурдаг;

- Радиостанцын мэдрэх чадвар. Сул дохиог хүлээж авах чадвар сайн байх тусам холбоо барих зай их байх болно;

- Радио нэвтрүүлэгчийн чадал. Радиостанцын ялгаруулж байгаа дохио хүчтэй байх тусам холбоо барих зай их байна;

- Антенны төрөл. Чиглэлийн үйлчилгээтэй антеннууд хамгийн хол зайнд, штырь антеннууд хамгийн ойр зайнд холбоо хангадаг байна.

### **2. Гадаад хүчин зүйлс:**

- Газар нутгийн гадаргуун байдал

(уул, жалга, толгод);

- Саад бэрхшээл (барилга байгууламж, ой мод, аж үйлдвэрийн барилга, төмөр зам, цахилгаан дамжуулах шугам. (Зураг 1).



Зураг 1. Гадаад хүчин зүйлс

3. Долгионы дифракц болон интерференц.

#### 4. МЭДРЭХ ЧАДВАР (SENSITIVITY, АНГЛИ; ЧУВСТВИТЕЛЬНОСТЬ, ОРОС).

Сул дохио хүлээж авах чадвар юм. Дохио тархаж байгаа нөхцөл байдлаас шалтгаалан радио холбооны холбоо барих зай дохио хүлээж авах чанар өөр өөр байж болно. Үүнд нөлөөлдөг нэг шинж чанар бол мэдрэх чадвар юм. Мэдрэх чадварыг микровольтоор (мкВ) хэмждэг. Үзүүлэлт урвуу шинж чанартай байдаг ба өөрөөр хэлбэл мэдрэх чадвар бага байх тусам радиостанц илүү сайн ажилладаг. Хамгийн үзүүлэлт сайтай радиостанцуудын мэдрэх чадвар микровольтын аравны нэгний мэдрэмжтэй байдаг. Энэ төрлийн радиостанцууд нэлээд хол зайд ч дохиог амархан хүлээж авч чадна. Тухайлбал 0.12мкВ-ийн мэдрэмжтэй радио нь 0.5мкВ-н мэдрэмжтэй радионаас дор хаяж хоёр дахин их зайд мэдээлэл хүлээж авдаг.

#### 5. СОНГОХ ЧАДВАР (SELECTIVITY, АНГЛИ;

#### ИЗБИРАТЕЛЬНОСТЬ, ОРОС).

Оролтын хэлхээн дээр үйлчилж байгаа олон тооны дохио болон дуу чимээний дундаас ашигтай дохиог ялган авах чадвар юм. Сонгох чадварыг децибеллээр (дБ) хэмждэг. Тоон утга (дБ) өндөр байх тусам радиостанцын дуу чимээний хамгаалалт, цахилгаан соронзон саадын үед холбоо барих зай төдий чинээ сайн байдаг. Чанартай радиостанцуудын хувьд энэ үзүүлэлт 60дБ-ээс дээш бөгөөд 100дБ хүрдэг.

#### 6. АНТЕННЫ ТӨРӨЛ: (ANTENNA TYPE, АНГЛИ; ВИД АНТЕННЫ, ОРОС)

Антенн нь холбооны төхөөрөмжийн бүрэлдэхүүн хэсэгт багтдаг бөгөөд бүтцийн хувьд нэвтрүүлэгч болон диэлектрикийн нэгдэл юм. Орчин үеийн антенн нь цахилгаан соронзон долгионыг цацруулах болон хүлээн авахаас гадна радио системийн чиглэлийг хангах чухал үүргийг гүйцэтгэнэ.

##### Антенны ангилал:

Зориулалтаар: а) Нэвтрүүлэх-хүлээн авах, хүлээн авах- нэвтрүүлэх;

б) Радио холбоо, радиорелей.

Долгионы цараагаар:

- Богино долгионы;

- Хэт богино долгионы.

Чиглүүлэх шинж чанараар:

- Чиглэсэн;

- Чиглээгүй;

- дугуй хэлбэртэй: дэлхийн гадаргуун дагуу жигд цацрах;

- Эгц цацраг: (NVIS, Near Vertical Incidence Skywave, англ) эгц дээшээ тархдаг долгион;

- Хосолсон цацраг: Эгц цацраг болон гадаргуун дохиог ашиглах.

Ашиглах хэлбэрээр:

- Суурин;

- Хөдөлгөөнт;

- Хээрийн.

Антенны уртаар:

- Бүрэн хэмжээний;

- Уртасгасан;

- Богиносгосон.

Радио долгионы цараанаас антенны бүтэц ихээхэн шалтгаалдаг. Богино долгионы антеннууд нимгэн



утсан хэлбэртэй байдаг. Энэ долгион дээр антенны шугаман хэмжээ (L) ба долгионы уртын (X) харьцаа бараг тэнцүү байдаг,  $L/X \sim 1$ .

Хэт богино долгион дээр антенны шугаман хэмжээ (L) долгионы уртаас (X) хэд дахин их байдаг  $L/X \gg 1$ . Ингэснээр радио долгионы цацруулах болон хүлээн авах нь илүү чиглэсэн шинж чанартай болдог. Мөн энэ долгион дээр шугаман утсаар дамжин өнгөрөх шугаман гүйдлийн оронд том металл гадаргууг тойрон урсах гадаргуун гүйдлийг өргөнөөр ашигладаг (Зураг 2, 3, 4, 5, 6).

Бүрэн хэмжээтэй антенн нь долгионы дөрөвний нэгтэй тэнцүү байдаг. Тухайлбал 27 Мгц-ийн давтамж дээр 2.7 метр, 144 Мгц давтамж дээр 50 см, 433, 446 Мгц давтамж дээр 17 см орчим байдаг. Антенныг богиносгоход үр ашиг нь бүрэн хэмжээний антенны

уртыг богиносгосон урттай харьцуулсан квадратын хэмжээтэй пропорциональ буурдаг. Тиймээс, СВ цараад зөөврийн радиостанцыг өргөнөөр ашигладаггүй. Тухайлбал, 40 см урттай антенн нь LPD/PMR царааны хувьд урт, VHF- бага зэрэг богино, СВ – маш богинохон байх болно.

Антенны төрөл нь холбоо барих зайд нөлөөлдөг. Тухайлбал, бид нарын сайн мэддэг штыр антенн нь гадаргуун долгионы антенн бөгөөд цахилгаан соронзон энергийг дэлхийн гадаргуун бүх чиглэлд жигд цацруулдаг. Эдгээр антенны гол дутагдал бол түүний хязгаарлагдмал холбоо барих зайд оршдог. Учир нь хагас дамжуулагч шинж чанартай дэлхийн гадаргуу радио долгионыг өөртөө шингэхээс гадна түүний мурийлтын нөлөөлөл нь цахилгаан соронзон талбайн хүчдэлийг чөлөөт орон зайтай харьцуулахад илүү



Зураг 2. Чиглэлийн үйлчилгээтэй



Зураг 3. Штырь антенн



Зураг 4. Тэгш бус хэмт вибратор антенн




Зураг 5. Тэгш хэмт вибратор




Зураг 6. Лого-пердик антенн




Зураг 7. Куликовын антен



Зураг 8. Телескоп багана



Зураг 9. V 46/12 антенн



Зураг 10. Тэгш хэмт вибратор ВН 25/11

хурдан бууруулдаг. Штырь антенны төрөлд АШ-1,5 (Куликовын антенн), (Зураг 7). АШ-2,7 антеннууд багтдаг. АШ-1,5 антенны холбоо барих зай 10 км хүртэл, АШ-2,7 антенны холбоо барих зай 12-15 км байдаг. АШ-1,5, АШ-2,7 антеннуудын холбоо барих зайг 60-70 км хүртэл нэмэгдүүлэхийн тулд 11-18 м өндөртэй хагас телескоп болон телескоп багана дээр суурилуулдаг (Зураг 8). 350 км ба түүнээс дээш зайд огторгуйн долгионы ВН 25/11 (ВН 15/11), ВН 40/12 (ВН 13/9), V 46/12 антеннуудыг ашиглана. (Зураг 9, 10).

Эгц цацаргалттай антеннууд нь богино долгионы радиостанцуудад гадаргуун болон огторгуйн долгионыг ашиглан холбоо барихад зориулагдсан. 350 км хүртэл холбоо барих чадвартай. Тухайлбал, P-142H КШМ дээр суурилуулсан цацруулагч нь П хэлбэрийн 2 хүрээ элементээс бүрддэг бөгөөд цацруулж буй цахилгаан соронзон долгионы хамгийн их хэсэг нь машинаас урагшаа болон дээшээ чиглэсэн байдаг.

Цэргийн радиостанцуудын антенн нь жин, хэмжээ багатай, дэлгэх буюу хураахад хялбар байхаас гадна радиостанц болон удирдлагын байрыг илрүүлэхгүй байх ёстой. Радиостанцын төрөл бүрд өөрийн гэсэн оновчтой антенныг сонгох ёстой байдаг учраас цэргийн радиостанцуудын антеннууд олон янзын төрөл, хэлбэртэй байдаг. Хээрийн нөхцөлд антенныг зөв сонгож ашиглах нь холбоо барих холын зай болон найдвартай байдалд нөлөөлдөг чухал хүчин зүйлсийн нэг болдог.

Радиостанцыг ашиглаж байх явцад өөрчлөх боломжгүй бөгөөд зөвхөн антенн болон ажлын давтамжийг зөв сонгосноор тодорхой нөхцөл байдалд шаардлагатай үр дүнд хүрэх боломжтой.

### 7. ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАХ ХУГАЦАА /АККУМУЛЯТОРЫН ТӨРӨЛ (CONTINUOUS OPERATION TIME/BATTERY TYPE, АНГЛИ; ВРЕМЯ НЕПРЕРЫВНОЙ РАБОТЫ/ТИП АККУМУЛЯТОРОВ, ОРОС).

Радиостанцын ажиллах хугацаа нь түүний аккумуляторын багтаамж, төрлөөс хамаарна. Багтаамж их байх тусам (mAh) радиостанц удаан ажиллана.

Радиостанцын аккумулятор литион, никель-кадмий гэсэн 2 үндсэн төрөлтэй. Аккумуляторын төрөл тус бүр нь давуу болон сул талуудтай.

Давуу тал нь Лити-ион аккумуляторыг цэнэглэхийн тулд бүрэн цэнэггүй болтол хүлээх шаардлагагүй ба өөрөөр хэлбэл хүссэн үедээ цэнэглэх боломжтой. Олон дахин цэнэглэх литионий батарей нь залгаж, салгахад хялбархан бүтэцтэй.

Сул тал нь хасах температурт цэнэгээ хурдан алдах бөгөөд өвлийн улиралд болгоомжтой хэрэглэх шаардлага гарна.

Никель - кадмийн аккумулятор нь хасах температурт ч цэнэгээ сайн хадгалахаас гадна -50°C хэм хүртэл ажиллах чадвартай. Никель кадмий зайг бүрэн цэнэггүй болсон үед л цэнэглэх боломжтой.

Сүүлийн үед литий технологийн шинэ үе шат болох литий-полимер аккумуляторууд (Li-pol) бий болсон. Бусад аккумулятортой харьцуулж үзэхэд цэнэглэх давтамж болон ачааллын шууд гүйдэл арай бага байдаг. Загварын хувьд ердийн батарейтай харьцуулахад янз бүрийн геометрийн хэлбэр дүрстэй болон төхөөрөмж дотор их зай эзлэхгүй нимгэн хэмжээтэй үйлдвэрлэх боломжтой.

Радиостанцын ашиглаж буй гүйдэл нь ашиглалтын горимоос ихээхэн хамаардаг. Нэвтрүүлэх явцад 1 Ампер ба түүнээс дээш, хүлээн авах үед хэдэн зуун миллиампер, зогсолтын горимд хэдэн арван мА, унтах горимд МА-ын нэгжид хүрч болно. Унтах горимд төхөөрөмжийн бараг бүх зангилаа бүрэн унтарч улмаар нэг зайны цэнэгээс ажиллах хугацаа нэмэгддэг байна.

## 8. ЖИН

Орчин үед радиостанцуудад тавьж байгаа нэг шаардлага бол овор, жин багатай байх юм. Микропроцессор, интеграл схем дээр суурилсан тоон радиостанцууд бий болсноор радиостанцуудын овор, жин эрс багасаж чадсан. Тухайлбал, P-148 радиостанц 3 кг жинтэй бол түүнтэй техник үзүүлэлтүүдийн хувьд ойролцоо тоон радиостанц P-168-5-УН-1Е 0.5 кг жинтэй байна (Зураг 11).



Зураг 11. P-148 радиостанц, P-168-05-УМЕ радиостанц

### Дүгнэлт:

1. Радио холбоо нь цэргийн удирдлагын үндсэн хэрэгслүүдийн нэг болохоос гадна зарим онцгой тохиолдолд цорын ганц хэрэгсэл нь болдог. Ийм учраас цэргийн радио холбооны станцыг сонгохдоо түүний техник үзүүлэлтэд онцгой анхаарах хэрэгтэй.
2. Радио холбоог тасралтгүй, найдвартай хангах, радио хэрэгслийг ямагт бэлэн байлгах үндсэн нөхцөл бол холбоочид эзэмшсэн техник хэрэгсэл түүний бүрэлдэхүүн, ажиллах зарчим, ашиглах ба тээвэрлэх, хадгалах зааврыг ягштал биелүүлдэг байх явдал мөн.
3. Монгол Улсын Зэвсэгт хүчин дээрх шаардлагуудыг тооцон өөрийн тоон хөгжлийн арга замыг боловсруулах

### Ашигласан материал:

1. Дамдинсүрэн Б. "Тоон дохионы боловсруулалт" УБ, 2017 он
2. Дамдинсүрэн Б. "Радио холбооны тоон системийн үндэс" УБ, 2000 он
3. Довдон Б. "Дохио дамжуулах онолын үндэс" УБ, 2000 он
4. Дулич А.П., Брежнев М.С., Матвеев Д.Е. Сравнительный анализ УКВ радиостанций. Международный научный журнал "Символ науки", №7.2015
5. Voltacom.ru Как выбрать портативные радиостанции
6. Батсүх Ч, Долгоржав С. "Холбооны англи- монгол- орос толь" УБ, 1996 он
7. Монгол улсын хууль, Радио долгионы тухай, 1999 оны 6 дугаар сарын 4-ний өдөр УБ
8. Yandex.ru huntland.ru
9. <https://ru.wikipedia.org/>
10. <https://en.wikipedia.org/>



## БНМАУ-ЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ГАДААД ОРЧНЫ ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ (1920–ООД ОНЫ СҮҮЛЧ 1930–ААД ОН)

**Н.НАРАНХҮҮ** /БХЭШХ-ийн БХДШТ-ийн ЭША, докторант хошууч/

**Түлхүүр үг:** Гадаад бодлого, аюулгүй байдал, Зөвлөлт Холбоот Улс, Хятад, Япон, Монгол, Манжго Улс

**Key words:** Foreign policy, security, Soviet Union, China, Japan, Mongolia, and Manchuria.

**Оршил.** Дэлхийн I дайны төгсгөлөөр их гүрнүүд хүчний шинэ харилцааг тогтоож, дайн өдөөгч нарыг буулган авч дахин дайн өдөөхгүй байх, олон улсын маргаантай асуудлыг шийдвэрлэх\*-ийг оролдсон боловч төдийлөн үр дүнд хүрээгүй.

Мөн дайны нөлөөгөөр Орос, Герман, Австри-Унгар, Османы эзэнт гүрнүүд ээлж дараалан задарч, олон улс шинээр бий болсон<sup>1</sup>. Орос оронд өрнөсөн Октябрийн хувьсгал, иргэний дайн зэрэг үйл явдлын үр дүнд 1920-од оны сүүлч 1930-аад он гэхэд олон улсын харилцаанд томоохон өөрчлөлтүүд гарч эхэлсэн байдаг<sup>2</sup> нь энэ цаг үеийн түүхийн гол дүр зураг болсон байна.

Дээрх өөрчлөлтийн зэрэгцээ дэлхийн эдийн засаг гүн хямарсан явдал нь капиталист орнуудын дотоод улс төрд ноцтой өөрчлөлтийг авчирсан. Англи, Франц зэрэг улсад ардчилсан шинж чанартай дотоод өөрчлөлтийг хийх гэж оролдсон хүчийг засгийн эрхэнд авчирсан. Харин Герман, Итали улсад энэхүү хямрал нь улс төрийн терроризм, шовинизм, милитаризмыг албадан гаргахын зэрэгцээ дотоодын

улс төрд нийгмийн демагог\*\*-ийг ашигласан фашист дэглэмийг бий болгоход хувь нэмэр оруулсан.

Өөрөөр хэлбэл шинээр хүчирхэгжин гарч ирсэн их гүрнүүд дэлхийг дахин хуваах, өөрсдийн ашиг сонирхлыг хангахын тулд бүс нутгуудад өөрсдийн эдийн засаг, улс төрийн дэглэмийг тогтоох үүднээс эвсэлд хуваагдах, зөрчилдөх болсон байна.

Олон улсын хурцадмал байдлын голомт хурдацтай хөгжиж эхлэв. Фашист Герман, Италийн түрэмгий байдлаас болж Европт түгшүүртэй байдал бий болов.

1930-аад оны эхний хагаст ЗХУ олон улсын тавцанд байр сууриа улам бэхжүүлж чадсан. 1933 оны сүүлчээр АНУ нь ЗХУ-ыг хүлээн зөвшөөрч, хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоов. Хэвийн байдал улс төрийн харилцаа АНУ, ЗХУ-ын хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаанд эергээр нөлөөлсөн. Цаашид Зөвлөлт Холбоот Улс Үндэстнүүдийн Лигийн гишүүнээр элсэж, Зөвлөлийн байнгын гишүүн болжээ. Мөн Зөвлөлт-Франц, Зөвлөлт-Чехословакийн хооронд

\* 1920-оод оны эхэн үед Дэлхийн I дайнд ялагчид олон улсын харилцаанд шинэ дэг журам /1919 оны 6 дугаар сарын 28-ны өдөр гарын үсэг зурсан Версалийн энх тайвны гэрээ-Дэлхийн I дайн дууссан, Германыг засан тохиуулах, 1921 оны 11 дүгээр сарын 12-ны Вашингтоны бага хурал-Тэнгисийн цэргийн зэвсэглэлийг хязгаарлах, Номхон далай, Алс дорнодын асуудал, 1922 оны 4 дүгээр сарын 10-аас 5 дугаар сарын 19-ний хооронд явагдсан Итали-Генуягийн бага хурал-эдийн засаг, санхүү, Хаагийн бага хурал-хаант Оросын өр төлбөрийг төлүүлэх, 1923 оны 7 дугаар сарын 24-ний өдөр дууссан. Лозаннын бага хурал-Турктэй энх тайвы гэрээ байгуулах, Хар тэнгисээр зорчих дэглэмийн тухай, 1925 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хуралдсан Швейцар-Локарногийн хэлэлцээр-Өрнөд европод батлан хамгаалах гэрээ байгуулах тухай/ тогтоох асуудлууд бүрэн дүүрэн хэрэгжээгүй.

<sup>1</sup> <https://mn.eferrit.com/> 2022.05.10

<sup>2</sup> Улс төрийн боловсролын академи, "Олон улсын харилцаа XX зуунд" УБ., 1994.т.53-59

\*\* Демагог гэдэг үг грек хэлнээс гаралтай *dēmagōgos*, энэ нь "хүмүүсийн жолооч" гэж орчуулагддаг. Демагог гэдэг нь тэр төлөөлөгч буюу улс төрийн удирдагч болж төлөвшдөг хүн. Хүмүүсийн дэмжлэгийг авахыг эрмэлздэг сонсдог, дагадаг хүмүүс. Демагог бол ерөнхийдөө биелэгддэггүй ойлгомжгүй яриа, амлалтуудаар хэсэг бүлэг хүмүүсийг удирдах, таалагдах гэсэн улс төрийн үйл ажиллагааны нэг хэлбэрийг хэлдэг бөгөөд энэ нь демагогийг практикт хэрэгжүүлдэг хүн юм



Европт ямар нэгэн түрэмгийлэл үйлдсэн тохиолдолд харилцан туслах гэрээнд гарын үсэг зуржээ.

Гэсэн хэдий ч 1930-аад оны дундуур ЗХУ нь гадаад бодлогын үйл ажиллагаанд олон улсын мөргөлдөөнд оролцохгүй байх зарчмаас ухарсан.

ЗХУ Испанийн Ардын фронтын Засгийн газарт генерал Ф.Франкотой тулалдахад зэвсэг, цэргийн мэргэжилтнүүдээр тусламж үзүүлжээ. Тэрээр эргээд Герман, Италиас улс төр, цэргийн дэмжлэг авсан. Франц, Англи хоёр төвийг сахисан хэвээр байв. АНУ ижил байр суурьтай байсан бөгөөд Испанийн Засгийн газарт америк зэвсэг худалдаж авахыг хориглов.

Мөн Зүүн хойд Ази нь дэлхийн хамгийн халуун цэгүүдийн нэг болж хувирсан байв. Тус бүс нутагт Дорнод Хятадын төмөр зам /ДХТЗ/-ын мөргөлдөөн\*, Япон Улсын дэмжлэгтэйгээр 1932 онд Манжго Улс байгуулагдсан<sup>3</sup> зэрэг үйл явдлууд дараалан өрнөж, хил залгаа ЗХУ, БНМАУ-ын гадаад байдалд таагүй нөхцөл бүрдэж эхэлсэн билээ. ЗХУ 1935 онд ДХТЗ-ын өөрийн эзэмшлийн хэсгийг Манжго Улсад худалдсанаар хоёр орны хоорондын хурцадмал байдлыг зөөлрүүлжээ<sup>4</sup>.

Гэвч цаашид байдал хурцадсантай холбоотойгоор 1931 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр болсон Бүх Холбоотын Коммунист Большевик Нам (БХК(б)Н)-ын Улс Төрийн Товчоо (УТТ)-ны хуралдаан дээр Гадаад Харилцааны Ардын Комисариат (ГХАК)-ын дарга Л.М.Карахан, "БНМАУ-ын батлан



1 дүгээр зураг. Японы цэргийн хүч Зүүн хойд Хятадыг түрэмгийлж байгаа нь. 1930-аад оны эхэн үе

хамгаалах асуудлыг онцгойлон анхаарах цаг боллоо. Энэ нь Манжуурыг эзлэн авсан Япон Улсын зүгээс гарч буй бодит аюултай холбоотой юм" хэмээн мэдэгдсэн байдаг.

Мөн Коминтерний удирдагч И.А.Пятницкий, П.А.Мифнар 1932 оны 3 дугаар сард Монголын төлөөлөгчидтэй уулзахдаа, "Япон нь үнэн хэрэгтээ Манжуур, Өвөр Монголоос гадна БНМАУ-ыг ч эзлэн авахыг хүсэж байгаа нь гарцаагүй. Японы империализм нь Хятадын засаг захиргаанаас хамаагүй хүчтэй шахалт үзүүлэх болно" гэж анхааруулж байв. Бүр Дорнод Хятадын төмөр зам байгуулагдсанаар энэ бүс нутгийн геотсратегийн ач холбогдол өсөж их гүрнүүдийн өөрсдийн эрх ашиг, сонирхлоо хамгаалан тэмцэх сөргөлдөөний талбар болсон<sup>5</sup>.

1905 оны Орос, Японы дайны дараагаас эхлэн Хаант Орос, түүнийг залгамжлагч ЗХУ, Япон, Хятад зэрэг бүс нутгийн харилцаанд тэргүүлэх байр суурьтай оролцож байсан их гүрнүүд анхаарлаа хандуулж, өөрсдийн

<sup>3</sup> \*ЗХУ 1935 онд Манжго Улсын де-факто хүлээн зөвшөөрч, Манжго Улсын Консулын газар 1935 онд ЗХУ-ын Чита, Благовешенск хотод тус тус нээгджээ. Мягмарсамбуу.Г, "Бүс нутаг, монголын түүхэн дэх Барга" (Улс төрийн түүх 1900-1960 он) УБ., 2017. т.168. Государственная и квазигосударственная природа Маньчжоу-Го: Исторические очерки. Иркутск Оттиск 2016.Стр 29.

<sup>4</sup> Мөн тэнд. т.168.Батбаяр.Ц, Гомбосүрэн.Д, "Монгол Манжгогийн хилийн хэлэлцээ" (Цэрэг-дипломатын түүх) УБ., 2004. т.11

<sup>5</sup> Мягмарсамбуу.Г, "Бүс нутаг, Монголын түүхэн дэх Барга" (Улс төрийн түүх 1900-1960 он) УБ., 2017, т.301

\* 1916 онд "Геополитик" хэмээх нэр томъёог Шведийн эрдэмтэн Рудольф Чэллэн шинжлэх ухаанд оруулжээ. 1920-оод оны үед Германы цэргийн зүтгэлтэн К.Хаусхоферийн санаачилгаар геополитикийн хүрээлэн байгуулсан нь геополитикийн шинжлэх ухаан бүрэн төлөвшихөд чухал нөлөө үзүүлжээ. Наранхүү., Бакалаврын ажил., "Монгол Улсын гадаад аюулгүй байдалд геополитикийн орчин нөлөөлсөн нь (1990-2003 он)" УБ., 2004., т.12 ШУА., "90-ээд оны Олон улсын харилцааны хандлагууд, Монгол Улс, их гүрнүүдийн харилцаа" УБ., 125-130 дахь тал.

\*\*Геополитикийг цэрэг-дайны чиглэлээр задлан шинжлэхийг хэлнэ. Баярхүү.Д., "Евроазийн геополитик, олон улсын харилцаа" УБ., 2002., т.26.



нөлөөний хүрээнд оруулахын төлөө өөр хоорондоо өрсөлдөж байлаа.

Монгол орон хэдийгээр газар зүйн тохиромжгүй байрлалтай, бага буурай улс боловч том гүрнүүдийн хувьд геополитик\*, геостратеги\*\*-ийн амин чухал байршилтайгаараа тусгаар тогтнолоо авч үлдэж чадсан. Өөрөөр хэлбэл монголчуудын тусгаар тогтнолын төлөөх тэмцэл нь тэднийг түүхийн тавцан дээр ахин гаргаж ирэхэд гагцхүү түүхэнд гүйцэтгэх үүрэг нь ямархуу байхыг түүх-газарзүйн нөхцөл нь тодорхойлсон билээ.

**БНМАУ-ын аюулгүй байдал гадаад орчны зүгээс үзүүлсэн нөлөө.** 1920-оод онд БНМАУ-ын удирдагч нар нь төвийг сахисан Швейцар шиг улс байгуулах, өөрийн тусгаар тогтнолыг ЗХУ, Хятад төдийгүй европын улсуудаар хүлээн зөвшөөрүүлэх тэд нартай эдийн засаг, худалдааны харилцаа тогтоох оролдлогуудыг хийж байв. Үүний үр дүнд Герман, Францад 50 хүртэл тооны залуусыг сургахаар илгээсэн<sup>6</sup> төдийгүй Швед, Дани зэрэг улсуудтай худалдааны харилцаа тогтоож, мөн мэргэжилтнүүдийг урьж ажиллуулж байсан байна. Гэхдээ гадаад харилцаанд ЗХУ-ыг түшиглэн Хятадын болон Японы түрэмгийллийг эсэргүүцэх бодлого барьж байжээ.

Гэвч ЗХУ, Коминтерний зүгээс Монголын нам, төрийн дотоод хэрэгт шууд оролцох явдал улам өсөж, Монгол оронд хөрөнгөтний бус хөгжлийн замыг турших болсон явцад монголын нийгмийг хямралт байдалд хүргэсэн байна.

Үүний улмаас үймээн, хөдөлгөөн гарах болжээ<sup>7</sup>. 1920-оод оны сүүлч үеэс Коминтерний шууд оролцоотойгоор

нам, засгийн эрхэнд гарсан “Зүүнтэн”-ий төлөөлөгчид болох З.Шижээ, Ө.Бадрах нарын алдаатай бодлогын улмаас ноёд, шашин, баян лам нар, баячуудын хөрөнгийг хураан, малчдыг хүчээр хамтралжуулах зүүнтний хэт хувьсгалч бодлого баримталсны үр дүнд 1932 онд зэвсэгт бослого гарсан төдийгүй олон тооны хүн хилийн чанадад дүрвэн гарах хөдөлгөөнүүд гарчээ<sup>8</sup>.

БНМАУ-д удаа дараа гарч байсан эсэргүүцэл тэмцэл, бослого хөдөлгөөний зэрэгцээ Дотоод Монгол, Баргад өөрсдийн эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулж, улмаар БНМАУ-тай нэгдэх зорилго бүхий үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гарчээ. Энэ үед БНМАУ-ын баруун хойд хязгаарт Тагна Тувагийн цагдаа, цэргүүд Тагны нурууны өвөрт нутаглаж байсан айлуудыг албадан нүүлгэж, Монголын хил давуулан хагас өртөө хиртэй газар оруулжээ. Монголын талаас Тагна Тувад хандаж, эсэргүүцэл илэрхийлэн, цэргээ татаж авахыг шаардахад Зөвлөлтийн талаас Тагна Тувагийн нутагт оруулсан цэргээ татаж авах шаардлагыг Монголын эрх баригчдад сөргүүлэн тавьж байв.

МАХН-ын Төв хороо Гадаад, дотоод нөхцөл байдлын улмаас Баргын талд цэрэг, зэвсгийн тусламж үзүүлэхээс татгалзаж байв<sup>9</sup>. Энэ үед Баргын босогчдыг дарах зорилготой Хятад цэргүүд, амбан яамны монгол цэргүүд БНМАУ-ын хил хязгаарт хүртэл халдах болжээ. Тухайлбал; 1928 оны 9 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд хятад, монгол цэргүүд босогчдыг нэхэн хөөсөөр монголын хил давж орж ирснээс болж, Хил хязгаар сэргийлэн

<sup>6</sup> <http://ikhmongol.mn/show/397>, 2022.05.12

<sup>7</sup> Гомбосүрэн.Д. "Монгол Улсын өрлөг жанжин (маршал) Гэлэгдоржийн Дэмид" БХЭШХ., "Монгол Улсын төр, цэргийн зүтгэлтэн маршал Г.Дэмид" /Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл/ УБ., 1996.т.10

<sup>8</sup> "Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчлин хийд, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс" "Лам нар сүм хийдийн хэлмэгдэл ба цагаатгал" УБ, 2008. т.44

<sup>9</sup> Мягмарсамбуу.Г, "Бүс нутаг, монголын түүхэн дэх Барга" (Улс төрийн түүх 1900-1960 он) УБ., 2017. т.140-141

\* Баргын ардуудыг тус хязгаарын дотор түр нутаглах явдлыг ёсоор болгон явуулах ба басхүү тогтоосон дүрмийн ёсоор тэдний малаас бэлчээрийн гааль, түрээсийг зургаан сараар бодож, хураан авч мөн нутгийн ардуудыг урьд лугаа адил хавчуулагдан гачигдуулахгүй харилцан найрамдалтайгаар түр нутаглуулбаас зохих учрыг хойш явуулан гүйцэтгүүлэхээр тогтов. "Монгол Улсын гадаад бодлого: Хичээнгүй сайд Б.Цэрэндорж" УБ., 2011. т.133. МҮТА. Сан хөмрөг.26, хн.60, х.107-108

хамгаалах 15 дугаар тусгай морьт суман тэдгээр хятад, монгол цэргүүдэд цохилт өгч, хилээс хөөн гаргажээ. Гэвч зүүн хязгаарын байдал түгшүүртэй хэвээр байв. Дайны хөлөөс дүрвэсэн Баргын айл өрхүүд ар араасаа нүүдэллэн, хил даван орж ирсний улмаас хил дээр удаа дараа зэвсэгт тулгаралт болж байлаа. Бослого дарагдаж байдал тогтвортой болсны дараа дүрвэсэн айлуудын ихэнх нь барга руугаа буцаж, нэг хэсэг айл БНМАУ-д үлдсэн байна\*.

Хятадад өрнөсөн 1925-1927 оны хувьсгалд Коминтерн ба түүний холбоотнууд ялагдал хүлээснээр ЗХУ-БНМАУ гэх тэнхлэгийг буй болгох эхлэлийг тавьж энэ нь Хятадын салангид дэглэмээс илүү хүчтэй, аюултай дайсан японтой мөргөлдөхөд Монголыг "бамбай" (буфер) улсын үүрэгтэй болгов<sup>10</sup>. Энэ тухай Хаант Орос Улсын Ерөнхий сайд асан П.Столыпин, "...ХХ зууны эхэн хагаст Хаант Орос болон түүнийг залгамжлагч ЗХУ-ын зүгээс Төв, Зүүн хойд Ази дахь өөрийн нөлөөний хүрэн дэх аюулгүй байдлыг хангах гол зорилт бол Орос, Хятадын хооронд бамбай улсыг буй болгох явдал юм"<sup>11</sup> гэжээ. Тухайн үед БНМАУ руу чиглэсэн ЗХУ-ын бодлогод Хятадыг оролцуулахгүй, Хойд Хятадад гадаадын нөлөөг дэлгэрүүлэхгүй байхыг ЗХУ-ын эрх баригчид тулган хүлээлгэсэн байдаг.

БНМАУ нь Хятадад өрнөсөн хувьсгалд ЗХУ-ын хамт холбоотны хувиар оролцож байв. Монголын төлөөлөгчид нь Хятадын Гоминдан намынхантай удаа дараа уулзалт хийж, Зөвлөлтөөс Хятадад үзүүлэх зэвсэг, техникийн тусламжийг БНМАУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан зөөхөд гар бие оролцож байлаа.

**БНМАУ-ын улс төрийн гадаад бодлогод ЗХУ-ын зүгээс нөлөөлсөн нь.** БНМАУ-ын цаашдын зорилго нь Ар, Өвөр Монголыг нэгтгэх үзэл санаанд чиглэж байсан ч Москвагийн

дэмжлэгийг хүлээж чадаагүй<sup>12</sup>. Өмнөдөд ялагдал хүлээсэн, Чан Кайши төрийн эргэлт хийсэн болон бусад хэрэг явдлын улмаас Хятадын хувьсгал эцэслэснээр БНМАУ-ын оролцоо шахагдаж, МАХН-ын Дотоод Монгол дахь хувьсгалт үйл ажиллагаа хумигдсан байна<sup>13</sup>.

Ийнхүү Монгол орны дотоод, гадаад байдал хүндэрсэн явдал Коминтернээс ангийн тэмцлийн бодлогыг монголд идэвхтэй хэрэгжүүлэх хөрсийг бүрдүүлэх урьдач нөхцөл болсон юм.

Тухайн үеийн нөхцөл байдлаас үндэслэн 1932 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн БХК(б)Н-ын УТТ-ны хурлаас гаргасан 92 дугаар тогтоол ёсоор БНМАУ-ын талаарх Зөвлөлтийн бодлогын бүхий л бодлогыг шийдвэрлэх эрхтэй "Монголын комисс"-ийг байгуулсан<sup>14</sup>. Коминтерны төлөөлөгчид Монголын эрх баригчдыг хооронд нь сөргөлдүүлэх, улмаар өөрсдийн далд санаархал, бодлогоо хэрэгжүүлэх арга замаа эрээ цээргүй тодорхойлсон байдаг.

Тэдний оролцоотойгоор МАХН-ын удирдлагад "Баруунтан" хэмээх нэр хоч зүүж, тэднийг намын удирдлагаас зайлуулж, Монголын нам, төрийн удирдлагыг Зөвлөлтөд төгссөн "шинэ хүмүүс"-ээр сольсон байна. Гэсэн ч тэд "Нөөц хүч" болох "шинэ хүмүүс" нь "Засгийн эрхэнд гарсан ч бидний итгэл найдварыг бүрэн биелүүлж чадаагүй байж болно" хэмээн болгоомжилж байсан нь бодит байдлаас төдий л хол зөрөөгүй юм.

Монголын төр засаг, цэргийн удирдагчид болох А.Амар, Д.Догсом, Г.Дэмид нар Зөвлөлтийнхний итгэл найдварыг тэр бүр санасан хэмжээнд биелүүлэхгүй сургагч, мэргэжилтэн нартай нь сөргөлдөх, тэдний эрх мэдлийг хязгаарлах зэрэг сөрөг хандлага гаргах болсноос ЗХУ-ын эрх баригчид түүнийг улс төрийн тавцангаас шахан, нийгэмд эзлэх

<sup>10</sup> Гомбосүрэн.Д., "Түүвэр зохиол" I боть. (Монголын түүх судлалын өгүүллүүд) УБ., 2005. т.75

<sup>11</sup> Столыпин.А., "Москва-Бээжингийн завсар дахь монгол орон" УБ., 2000.

<sup>12</sup> Мөн тэнд. т.74

<sup>13</sup> Мөн тэнд. т.75

<sup>14</sup> <https://istmat.org/node/54703>, 2022.05.17



байр суурийг нь сулруулах оролдлого хийх болов. Үүний нэг жишээ нь 1934 оны 12 дугаар сард хуралдсан Улсын 19 дүгээр Бага хурлаас онцын учир шалтгаангүйгээр Г.Дэмидийг Ерөнхий сайдын нэгдүгээр дүгээр орлогчоос хоёрдугаар орлогч болгон, оронд нь Х.Чойбалсанг томилсон явдал юм.

Эл томилгоог ЗХУ-ын удирдагч И.В.Сталинтай зөвшилцсөний үндсэн дээр хийсэн байна. Х.Чойбалсан 1936 оны 2 дугаар сараас ДЯЯ-ны сайд болсноор аливаа асуудлыг гаднын заавар зөвлөгөө, өөрийн дур зоргоор явуулах болжээ. Тэрээр төр, засгийн эрх баригчдын талаар элдэв мэдээ, захидал сэлтийг ЗХУ-ын удирдлагад байнга бичих болсон бөгөөд түүний дотор Г.Дэмидийн талаар ч элдэв зүйл бичих болсон байдаг.

1930-аад оны дунд үеэс эхлэн ЗХУ ашиг сонирхлоо хэрэгжүүлэх зорилгоор Монголын эрх баригчдыг хооронд нь сөргөлдүүлэх, өөрийн талыг барьсан итгэл найдвартай хүнийг эрх баригчдын дунд бий болгох санаа бодол өвөрлөн ил, далд хэлбэрээр санаархлаа хэрэгжүүлэх болсон. ЗХУ-ын итгэл найдварыг хүлээсэн хүн нь Х.Чойбалсан болсон бөгөөд түүнийг төр засгийн өндөрлөг рүү алхам алхмаар өгсүүлж эхлэв. Учир нь Монголын эрх баригчид ЗХУ-ын удирдлагатай гучаад оны үед хэд хэдэн удаа уулзсан байдаг<sup>15</sup>. Тэрхүү уулзалт нь Сталин нараас Гэндэн тэргүүтэй Монголын төлөөлөгчдийг буруутган зэмлэсэн өнгө аясаар дүүрэн байсан бөгөөд Монголын батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх, лам нарыг устгах асуудлыг хөндөн ярьжээ. Эл ярианд Г.Дэмид ЦЯЯ-ны сайдын хувьд голлох байр суурьтай оролцсон байна.

Гэвч Монголын төлөөлөгчдийн ярианы агуулга зарчмын хувьд өөр байр суурьтай байсан нь Сталинд таалагдсангүй ажээ.

Эл уулзалт дээр монголчууд Зөвлөлтөөс авах цэргийн тусламжийг



2 дугаар зураг. Баруун гар талаас гурав дахь нь, БНМАУ-ын Ерөнхий сайд П.Гэндэн, ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжин, Улсын маршал, Өрлөг жанжин Г.Дэмид нар Москва хотод 1930-аад он.

тайван болон дайны үеийн гэж ангилан энгийн цагт бол байлдааны ба улс төрийн бэлтгэлийг дээшлүүлэхэд хөрөнгө мөнгө, сургагч мэргэжилтэн, техникийн тусламж байвал зохих, харин байлдааны үед хүч хүрэхгүй бол цэргийн тусламж байх нь чухал, түүнээс гадна олон улсын байдалд нийцвэл харилцан үл довтолох тухай гэрээ байгуулах тухай санал тавьсан байна.

И.В.Сталин энэ уулзалтаар Монгол оронд өөрийн цэргийг оруулах асуудлыг төвөггүй шийднэ гэж бодож байсан боловч Г.Дэмид харин дайны байдалтай болсон үед гэхдээ өөрийн хүч үл хүрэх тохиолдолд цэргийн тусламж авна өөрийн болзлыг тулгасан нь түүний хувьд санаанд оромгүй зүйл болсон. Сталины хувьд Монголд цэрэг оруулах явдлыг хойшлуулшгүй аминд нь тулсан явдал байв. Учир нь Алс Дорнодод Япон Улсын явуулж буй түрэмгийлэл нь шууд болон шууд бус байдлаар ЗХУ-ын аюулгүй байдалд заналхийлэх болсонтой холбоотой.

ЗХУ өөрийн хил хязгаараас Японы аюул заналыг холдуулахын тулд Монгол орныг бамбай улс болгох, улмаар Японтой сөргөлдөж буй Хятад Улсад тал бүрийн тусламж үзүүлэх зэргээр эл аюул заналаас сэргийлэх замыг эрэлхийлэх болсон юм.

Үүнийгээ хэрэгжүүлэх шаардлага тулгарахад Монголын удирдагчид

<sup>15</sup> ЗХУ-ын удирдагч И.В.Сталин Монголын нам төрийн удирдагчид болох П.Гэндэнг 5 удаа, А.Амарыг 1 удаа . . . тус тус хүлээн авч уулзаж байжээ. Отгонжаргал.С., "XX зууны монголын түүхийг шинээр эргэн харахуй" (1921-1990) УБ, 2003, т.73



саад тотгор болсон нь энэ ажээ. Гэсэн ч яриа хэлэлцээг Сталин тулган хүлээлгэх замаар үргэлжлүүлж Монголд хоёр моторжуулсан бригад оруулахаа мэдэгдээд,

“Энэхүү цэргийн ангиуд нь нэг талаар танай орны байдал лугаа танилцах нь чухал. Харин гагцхүү та нараас тусгай хамтарсан саналыг зөвшөөрвөөс танай манай хоёр улсын харилцан үл довтлох гэрээ нь чухам энэ болой” гэж байжээ.

Зөвлөлтийн удирдлага өөрсдийн санаагаа хэрэгжүүлээд удалгүй Монголд Зөвлөлтийн цэргийн ангиуд орж ирсэн юм. Тухайн үеийн нөхцөл байдал, ялангуяа Монгол Улсын хил хязгаарт Япон, Манжийн зүгээс удаа дараа өдөөн хатгалга үйлдэж байсан нь дээр дурдсан тулгалтыг хүлээн авахаас аргагүй байдалд хүргэжээ. Эл байдлыг харгалзан үзсэн Монголын удирдагчид Зөвлөлтийн цэргийн хүч Монголд орж ирсэн, улмаар ЗХУ-тай харилцан тусалж, хамтран ажиллах тухай гэрээ зэргийг тус улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд ач тустай хүчин зүйл боллоо гэж үзэх болсон.

ЗХУ нь 1924 онд Бээжинд БНХУ буюу Гоминданы Хятадын Засгийн газартай байгуулсан Зөвлөлт-Хятадын гэрээгээр БНМАУ-ыг Хятадын салшгүй нэгэн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн байсан ба үүнийгээ Монголын талд эсрэгээр тайлбарлан хоёр нүүр гаргасан бодлого баримталж байлаа. Үүний тод жишээ нь, 1946 он хүртэл БНМАУ-тай дипломат харилцаа тогтоогүй байсан бөгөөд БНМАУ-д Элчин-Консул л суулгаж байсан ба албан ёсны нэг ч гэрээг хоёр улсын хооронд байгуулаагүй байна.

1936 оны 3 дугаар сарын 12-ны өдөр ЗХУ, БНМАУ-ын хооронд “Харилцан тусалцах гэрээ” байгуулагдав<sup>16</sup>. Монголын талаас А.Амар, П.Гэндэн

нар, Зөвлөлтийн талаас бүрэн эрхт төлөөлөгч В.Х.Таиров нар гарын үсэг зуржээ. Уг гэрээний 1 ба 2 дугаар зүйлд, “... Хоёр этгээд нь хэрэв ямар нэг гурав дахь этгээдийн зүгээс ЗХУ болон БНМАУ-ын нутаг дэвсгэрт довтлох аюул тохиолдох аваас бие биедээ элдэв тусламж, түүний дотор цэрэг, зэвсгийн тусламж үзүүлэх явдлыг харилцан үүрэг болгон авч байна...”<sup>17</sup> гэж заажээ. Уг хэлэлцээрийг Гоминданы Засгийн газар 1936 оны 4 дүгээр сард ЗХУ-ын Засгийн газарт хүргүүлсэн нот бичигтээ, Гадаад Монгол\* бол БНХУ-ын салшгүй хэсэг тул гадаадын ямар ч улс орон түүнтэй ямар нэгэн хэлэлцээр байгуулах эрхгүй” гэж мэдэгдэв. Харин ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссариатын газраас БНХУ-ын Засгийн газарт өгсөн нот бичигтээ, “Энэхүү хэлэлцээр нь ... ЗХУ, БНМАУ нь гадны түрэмгийлэлд өртсөн тохиолдолд хэрэгжих учир гуравдагч орны ашиг сонирхлын эсрэг хандаагүй болно”<sup>17</sup> гэж мэдэгдсэн байдаг. Өөрөөр хэлбэл Алс дорнодод Японы эзэнт гүрний түрэмгий бодлогын үр дүнд Манжуур Японд эзлэгдэн ЗХУ-ын дорнод хил тайван бус болсонтой холбоотойгоор ЗХУ-ын удирдлага БНМАУ-ыг жийргэвч бамбай улс болгон ашиглах, стратегийн давуу байрлал эзэмших үүднээс дээрх харилцан тусалцах протоколыг л байгуулсан.

ЦЯЯ-ны сайд, Өрлөг жанжин, Улсын маршал Г.Дэмид тус хоёр орны хооронд 1936 онд байгуулсан гэрээг, “... Манай Монголын нэр сүр дэлхий дээр дуурсаж, тусгаар тогтносон эрх чөлөөт байдал нь улмаар батжих юм ...” гэж сайшаан үзэж байв. Өөрөөр хэлбэл ЗХУ-аас Монгол Улсын талаар баримталж байсан бодлого, мэргэжилтэн нарын үйл ажиллагааны сөрөг зохисгүй үйлдлийг ойлгон буруушааж байсан ч эцсийн эцэст Монгол Улсын тусгаар

<sup>16</sup> Даваадорж.Н, “Эх орны төлөө” УБ., 2018. т.27

<sup>17</sup> Мөн тэнд // Хайсандай.Л., “Монголын улс төрийн гадаад харилцааны түүх” (1911-1999) УБ., 2012, т.148

\* XVII зууны үед тусгаар тогтнолоо хадгалж байсан Ар Монголыг “Гадаад Монгол”, Ар Монголоос өмнө Манжид дагаар орсон Монголчуудыг “Дотоод Монгол” гэж нэрлэж байв. <https://mongoltoli.mn/history/h/372>

<sup>18</sup> Мөн тэнд. т.149



тогтнол, аюулгүй байдлыг эрх ашгийн үүднээс өөрөөр хэлбэл прагматик байдлаар түүнд хандаж байсан юм.

Тэрээр хоёр улсын харилцааг, ЗХУ-ын тусламж, дэмжлэгийг ямагт тус улсын хөгжин мандахын нэгэн нөхцөл гэж үзэж байсан бөгөөд “ер бид нар Зөвлөлийн засагт холбоот улсаас тусламж өгвөл хөл дээрээ тогтнож чадна. Хэрэв Холбоот улсаас тус нэмэр үзүүлэхгүй бөгөөс манай байдал туйлын хүнд болно” гэж хэлж байв.

Г.Дэмид 1934 онд Хувьсгалт цэргийн зөвлөлийг татан буулгаж улмаар МАХЦ-ийн Жанжин штабын дарга Я.В.Шеко<sup>19</sup> хэмээх орос хүнийг чөлөөлж, оронд нь Ж.Малжийг томилсноор Монголчуудын хувьд анхны монгол штабын дарга нь болсон юм. Энэ нь Г.Дэмидээс Зөвлөлтийн зарим сургагч мэргэжилтнүүдэд таагүй хандах болсны илрэл байв. Гэтэл Х.Чойбалсан, Я.В.Шеко нарын зүгээс эл явдлын талаар ЗХУ-ын талд мэдээлж байжээ. Тухайлбал, Ш.З.Элиава\*-д бичсэн захидалдаа: “ ... Дэмид нөхөр Шеког Монголд буцааж ирүүлэхийг эрс шийдвэртэй татгалзаж байна. Энэ тохиолдолд ЦЯЯ-ны сайдын тушаалаас чөлөөлөгдөнө гэж хэлсэн ...” гэж мэдэгдэж байв.

Зөвлөлтийн удирдлагаас Дэмид нарыг Зөвлөлтийн сургагч, мэргэжилтэн нартай зөрчилдөж буй байдлыг анзаарч мэдсэн ч түүнийг тийм ч аюултай зүйл гэж үзэж байгаагүй бололтой. Харин эл хандлага нь улам даамжирч тухайн үеийн монголын төр, засгийн удирдагчид Монгол Улсын эрх ашиг, тусгаар тогтнолын асуудлыг ямагт эрхэмлэж, тэр л үүднээс аливаа асуудалд хандах болсноос дээрх зөрчил улам даамжрах болсон.

Ерөөс Монголын төр засгийн

удирдагчдын үзэл бодол, үйл ажиллагаа нь ЗХУ-ын язгуур эрх ашиг, Алс Дорнодын талаарх төрийн бодлогод харшилж, саад болж эхэлсэн тул түүнийг улс төрийн тавцангаас бага багаар шахан зайлуулах алхамд шилжиж эцэстээ монголын төр засгийн удирдагчдыг хэлмэгдүүлж, амь насыг нь хорооход хүрсэн ажээ. БНМАУ-ын дотоод байдал ийнхүү хурцдаж эхэлж байхад гадаад аюулгүй байдал нэн ялангуяа Манжго Улсын зүгээс удаа дараагийн хил хязгаарын зурвасын асуудлаар маргаан үүсгэж эхэлсэн. Манжуурт түрэмгийлсэн Японы Квантуны армийн Зүүн хойд Хятадад явуулсан түрэмгий ажиллагаа, баруун хил хязгаараар хил зөрчсөн хасгийн зэвсэгт дээрэмчдийн халдлага зэрэг нь нэн ялангуяа БНМАУ-ын гадаад нөхцөл байдлыг улам бүр хүндрүүлэв.

Япон-Манжгогийн тал 1935-1937 онд бүрэн бус мэдээгээр 300 гаруй удаа хил орчим болон БНМАУ-ын хил зөрчиж, тагнуул хийсэн байна. Улмаар 1935-1936 онд БНМАУ-ын Халхын сүм, Булан дэрс, Адаг дулаан зэрэг нутгийг цэргийн хүчээр эзлэн авчээ. БНМАУ-ын Засгийн газраас эсэргүүцлээ илэрхийлэхэд, Япон-Манжгогийн тал хилийн мөргөлдөөнийг хилийн шугам тодорхой бус байгаагаас үүдэлтэй учир “хил тогтоох” нь чухал хэмээн тайлбарлаж байв. Монголын тал ч саналыг хүлээн авч, 1935-1937 онд Манжуур хотноо Монгол-Манжго Улсын хэлэлцээрийг гурван удаа хийсэн боловч удаа дараа амжилтгүй болж байжээ.

Учир нь 1937 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн төр, засаг, цэргийн дээд удирдлагыг “Гэндэн, Дэмидийн эсэргүү байгууллага”-ын гишүүн, “Японы тагнуул, төлөөлөгч” хэмээх улс төрийн

<sup>19</sup> 1927 оны 3-р сараас 1930 оны 7-р сар хүртэл МАХЦ-ийн жанжин штабын даргаар ажиллаж байсан. <http://1937god.info/node/913>, 2022.05.17

\* “1923-1927 онд Зөвлөлт Гүржийн Ардын комиссаруудын Зөвлөлийн дарга, 1927 оноос Кавказын чанад дахь Зөвлөлт Социалист Холбооны Бүгд Найрамдах Улсын Ардын комиссаруудын Зөвлөлийн дарга, 1931 онд ЗХУ-ын Гадаад худалдааны ардын комиссарын орлогч, 1936 онд ЗХУ-ын Хөнгөн аж үйлдвэрийн ардын комиссарын орлогчоор тус тус ажиллаж байгаад 1937 оны 12 дугаар сарын 3-ны өдөр улс төрийн хилс хэргийн улмаас цаазаар авахуулжээ. Ш.Элиава нь “Монголын комисс”-ын бүрэлдэхүүнд орж, Коминтерн, БХК(б)Н-ын даалгавраар Монголд ирж ажиллаж байжээ” Дашдаваа.Ч., “Коминтерний төлөөлөгчид” УБ, 2019, х.18-23



3 дугаар зураг. Өвөр эгнээнд баруун гар талаас: Монголын талын төлөөлөгч МАХЦ-ийн II корпусын дарга Г.Дамба, Улсын бага хурлын дарга Д.Догсом, Бүх цэргийн жанжны II орлогч Г.Самбуу, Манжгогийн талын төлөөлөгчдийн тэргүүн Хойд Хянганы мужийн захирагч Ли Шинь, Хянганы морьт хорооны захирагч Гармын Үржин, Японы ГЯЯ-ны хэрэг эрхлэх газрын ажилтан Канки

хилс хэрэгт хоморголон баривчилсан байна. Энэ хэрэгт холбогдуулан дээр дурдсан хилийн хэлэлцээрийг удирдаж байсан Г.Самбуу, Л.Дарьзав болон бусад төлөөлөгчдийн гишүүдийг толгой дараалан баривчилсан байна. Үүнээс болж уг хэлэлцээр тасалджээ. Улмаар 1936 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Герман, Япон улсууд “Коминтерны эсрэг гэрээ” байгуулсантай уялдан Зөвлөлт болон Японы харилцаа муудсанаар Манжуурын хэлэлцээр төдийлөн үр дүнд хүрэлгүй дууссан<sup>20</sup>.

Энэ үес П.Гэндэнг албан тушаалаас нь огцруулж улмаар амрах нэрийдлээр ЗХУ-д аваачсаны дараа Ерөнхий сайд бөгөөд ДЯЯ-ны сайд Х.Чойбалсан сүм хийд, лам нарыг хэлмэгдүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлжээ.

1937 оны 7 дугаар сарын 17-ны БНМАУ-ын Ерөнхий сайд асан П.Гэндэнийг хувьсгалын эсэргүү хэрэгт холбогдуулж, ЗХУ-д баривчлав.

БНМАУ-ын СнЗ-ийн 2 дугаар орлогч сайд, ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжин, маршал Г.Дэмид, ЦЯЯ-ны их бууны газрын дарга, дивиз командлан захирагч Г.Жанцанхорлоогийн хамт ЗХУ-ын Ардын комиссар К.Е.Ворошиловын урилгаар Зөвлөлтийн цэргийн хээрийн сургуульд оролцохоор явж

байгаад 1937 оны 8 дугаар сарын 22-ны өдөр Сибирийн төмөр замын “Тайга” хэмээх өртөөний ойролцоо “сэжиг” бүхий байдлаар нас барсан юм<sup>21</sup>.

Удалгүй мөн оны 8 дугаар сарын 24-ны өдөр ЗХУ-ын ДХАК нарын газрын орлогч дарга М.П.Фриновскийн авчирсан “хуйвалдаан” гэж нэрлэсэн 115 хүний нэрсийн жагсаалтад нэр дурдагдсан 65 хүнийг мөн оны 9 дүгээр сарын 10-ны шөнө баривчилснаар “Их хэлмэгдүүлэлт”-ийн үйл ажиллагаа эхэлсэн түүхтэй.

Улмаар “Гэндэн, Дэмидийн хувьсгалын эсэргүү байгууллага” гэгч зохиомол хэргийг лам нарын “төв” хэмээх хувьсгалын эсэргүү тагнуулын байгууллага гэгч зохиомол хэрэгтэй холбож нэгтгэснээр монголын үндэсний үзэлтнүүд, сурвалжит угсаатнууд, сэхээтнүүд болон лам нарыг монгол орон даяар дайчлан баривчилж, хилс хэрэгт хэлмэгдүүлэн алан хядах үйл ажиллагааг өрнүүлэх нөхцөл бүрдсэн.

Ийнхүү хэлмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэхдээ Сталины зөвлөсөн ёсоор олон нийтэд ухуулан сурталчлах зорилготой үзүүлэх шүүх хурлыг хоёр удаа хийсэн. 1937 оны 10 дугаар сарын эхээр улсын төв театрын байранд олны өмнө нээлттэй шүүх хуралдаанаар “Ёнзонхамба, Лувсан хаймчиг, дэд хамба Дамдин нарын толгойлсон хувьсгалын эсэргүү төв хэмээх байгууллагын хэргийг мөн сарын 20-доор Гэндэн, Дэмидийн хувьсгалын эсэргүү байгууллагын идэвхтэй гишүүн гэгдсэн цэргийн ба төрийн алба хаагч 14 хүний хэргийг таслан шийдвэрлэсэн юм.

Ийнхүү их хэлмэгдүүлэлтийн үйл ажиллагаа нь Зөвлөлтийн удирдагч Сталины өгсөн зөвлөгөө, Монголд ажиллаж байсан зөвлөлтийн сургагч зөвлөх чекистүүдийн удирдамж, зааврын дагуу хэрэгжиж эхэлсэн байна<sup>22</sup>.

Үүнтэй зэрэгцэн Гадаад Монголын

<sup>20</sup> Гомбосүрэн,Д., "Түүвэр зохиол" УБ., 2005., х.108-125

<sup>21</sup> "Маршал Г.Дэмид" УБ, 1994, х.18-71

<sup>22</sup> \* " ... Төрийн эсрэг гэмт хэрэгт хилсээр баривчлагдсан хүмүүсийн хэргийг 1937 оны 10 дугаар сараас 1938 оны 4 дүгээр сарын 15-ыг хүртэлх хугацаанд ДЯЯ-ны дэргэд байгуулсан "Онцгой бүрэн эрхт



геополитикийн байршлын ачхолбогдол их гүрнүүдийн сонирхлыг ихээр татах болов. Тухайлбал, "... Хятад дахь японы цэргийн атташе Озака Хидезане 1937 оны 7 дугаар сард "Тао" сэтгүүлд нийтлүүлсэн "Гадаад Монголын хөгжил ба түүний стратегийн ач холбогдол" нэртэй өгүүлэлдээ, "Дорнод Ази дахь одоогийн улс төрийн байдалд Гадаад Монгол нь цэрэг-дайн талар чухал ач холбогдолтой байгаа юм. Япон умард Хятад руу хөдөлж ... Цахар, Суйюань мужуудад нөлөөгөө өргөтгөх нь ЗХУ-д үлэмж заналхийлэл болох ёстой. Цэргийн зөвлөх мэргэжилтнүүдийн нэгдсэн саналаар бол Гадаад Монголоор дамжин ЗХУ руу орох нь Манжуураар дамжин Зөвлөлтийн хил рүү шууд орсноос илүү ашигтай болно ..."<sup>23</sup> гэсэн байдаг.

Нөгөө талаар Япон Улс Герман, Зөвлөлт хоёр Европт нөлөөнийхөө бүсийг хуваасан шиг Зөвлөлт, Япон улсууд ч гэсэн Хятадад ижил агуулгатай тохиролцоо хийж болох юм гэж үзэж байжээ. Квантуны армийнхны саналаар ЗХУ нь Гоминданы Хятадын зүгээс Японы эсрэг явуулж буй дайнд тусламж үзүүлэхээ зогсоох ёстой. Үүний хариуд Япон Улс Гадаад Монгол, Шинжаан дахь Зөвлөлтийн нөлөөг хүлээн зөвшөөрч болох юм гэсэн асуудал яригдаж байв<sup>24</sup>.

ЗХУ, БНМАУ-ын дорнод хил хязгаарт Япон, Манжго Улсын зүгээс удаа дараагийн өдүүлсэн хилийн зөрчил будилаан нь даамжирсаар 1937 онд ЗХУ-ын Хасан нуур, 1939 онд БНМАУ-ын Халхын голын районд орчин үеийн цэрэг техникийн бүх ололтыг ашигласан дэлхийн 2 дугаар дайны өмнөх томоохон хэмжээний байлдааны ажиллагаа явагджээ.

Эдгээр байлдааны ажиллагаанд ЗХУ, БНМАУ-ын хамтарсан арми ялсан нь хүчний харьцааг ЗХУ, БНМАУ-ын талд ашигтайгаар өөрчилжээ. Гэхдээ БНМАУ-ын нутаг Мана уул, түүний ойр орчмын газар нутаг хилийн гадна үлджээ. Хилийн цэргийн дэслэгч генерал Б.Цэдэн-Ишийн бичсэнээр Мана уулын тулалдааны үр дүнд ... Нөмрөгийн голын чанадад 62,700 га нутаг Манжгогийн нутагт орсон байна. Халхын голын байлдааны гол үр дүн нь Япон Улсыг төвийг сахих гэрээнд гарын үсэг зурахад хүргэсэн билээ.



4 дүгээр зураг. Японы олзлогдсон цэргүүд.  
Халхын гол 1939 он.

Халхын голын цэрэг стратегийн гол бодлого ЗХУ ба Япон Улсын хооронд явагдсан ч төв азийн стратегийн гол байрлалтай БНМАУ-ын хувьд тусгаар тогтнолоо хамгаалах чухал шаардлага тулгарсан юм. Уг дайны Дэлхийн II дайн эхлэхэд шууд нөлөө үзүүлсэн. Өөрөөр хэлбэл, байлдааны ажиллагаа Алс Дорнодын театраас Европын театр руу шилжихэд хүргэсэн гэж үзэж болно.

Мөн 1905 оны Орос-Японы дайн нь Орос Улсад Гадаад Монголын жийргэвч бүсийн үүргийг илүү өндөр түвшинд гаргаж иржээ. Хожим энэ үүрэг Хаант Оросын залгамжлагч ЗХУ-д ноогджээ. ЗХУ-ын зүгээс БНМАУ

комисс"-оор эчнээ оруулан таслан шийдвэрлэх болжээ. 1937 оны 10 дугаар сараас 1939 оны 4 дүгээр сарын 15-ыг хүртэлх хугацаанд энэ комисс бүгд 51 удаа хуралдаж, 25800 шахам хүний хэргийг таслан шийдвэрлэж ял оногдуулжээ. Эдгээрийн 19000 орчим нь лам нар байсан бөгөөд 17000 орчмыг нь буудан алах ялаар шийтгэсэн байдаг. Түүнчлэн Монгол орон даяар байсан 700 гаруй сүм хийд эзгүйрч урлагийн олон мянган бүтээл оюуны асар их өв сан устгагджээ" Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийд, Цагаатгах ажлыг удирдан зохион байуулах комисс. "Лам нар сүм хийдийн хэлмэгдэл ба цагаатгал" УБ., 2008. т.32-34

<sup>23</sup> Урангуа.Ж, "XX зууны 30-аад оны Монголын геополитикийн орчин ба Халх гол". "Ардчилал таймс" сонин. 2019.5.30. №101 (163)

<sup>24</sup> Даваадорж.Н, "Эх орны төлөө" (Цэрэг-Улс төр, түүхийн судалгаа 1930-1952 он) УБ., 2018. т.63



нь Алс дорнодын бодлого явуулах плацдарм, Зөвлөлтийн Өвөр байгалийг хамгаалах бүс, Японы түрэмгийллийг тогтоох газар, Манжготой сэргүүлж хүчний тэнцвэрийг барих цэг, Хятадтай харилцах ойр бүс гэж ач холбогдлыг нь тодорхойлсон байдаг.

### **Дүгнэлт**

Дэлхийн I дайны дараа үүссэн нөхцөл байдлын үр дүнд дэлхий дахины цэрэг, улс төрийн байдалд ихээхэн өөрчлөлт гарсан билээ. Ялангуяа энэ үед их гүрнүүдийн хоорондын зөрчилдөөний үр дүнд олон улсын харилцаа хурцдаж, түрэмгий дайн ази, европ тивд удаа дараа гарах болсон.

Энэ цаг үед тусгаар тогтноод удаагүй байсан монгол орон нийгэм-эдийн засгийн болон улс төрийн гүнзгий хямралд автсан нь ЗХУ-ын шууд оролцоо, бодлого, үйл ажиллагаанаас шалтгаалсан юм. Учир нь Монгол Улсын баримталж байсан гол чиг шугам нь сэргээн мандуулсан үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо бататгах, бие даасан гадаад бодлого явуулах, өөрийн газар нутаг, шашин соёл, ёс заншил зэрэг үнэт зүйлээ хадгалж хамгаалах үзэл санаанд оршиж байв.

Гэвч их гүрнүүдийн бодлогын золиос болж, тэдгээр гүрнүүд нь өөрийн эрх ашгийн бүс, нөлөөндөө оруулахын тулд нийт монголчуудыг оролцуулалгүйгээр хувь заяаг нь хэлэлцэн шийдвэрлэж, тэдэнд түрэмгий бодлогоо тулган хүлээлгэсэн.

Өөрөөр хэлбэл БНМАУ, Хятадын харьяаны Дотоод Монгол, Барга нь өөрсдийн бие даасан бодлого, үйл ажиллагаа явуулж, Коминтерн болон ЗХУ-ын тусламж дэмжлэг төдийгөөр

хязгаарлаж, тэдний бүрэн хяналтаас гарах гэсэн бодлогыг мэдэрсэн ЗХУ-ын удирдлага Монголын удирдагч нарын хооронд яс хаясан бодлого явуулсны үр дүнд ЗХУ-д түр хугацаагаар сургасан хөдөөгийн залуу хэт хувьсгалч нарын гараар “баруунтан”, “зүүнтэн” гэсэн нэр томъёоллыг гаргаж үндэсний удирдагч нарт оноон төрийн удирдлагаас ээлж дараалан зайлуулсан түүхтэй.

Ийнхүү XX зууны 20, 30-аад оны үед нийт монголчуудын нэгдэн нийлж нэгэн улс гэр болох үзэл санаа нь, 1.ЗХУ, Хятад, Япон улсын зүгээс монголын талаар баримталж байсан бодлого, 2.Монголын нам, төрийн баримт бичигт “хөтөлбөр” хэлбэрээр тусгагдаж байснаас хэтрээгүй. БНМАУ нь газар нутгийн байршлын хувьд 1930-аад оноос Дэлхийн 2 дугаар дайн дуусах хүртэл хугацаанд ЗХУ, Хятадын гэхээсээ илүүтэй ЗХУ-Японы хоорондын жийргэвч бүс болж байсан гэж үзэж болно.

Ийм ч учраас тухайн үеийн Монголын Төр засгийн удирдагчдын дотор нэгдсэн Монгол Улс байгуулах үзэл санаа өчүүхэн төдий цухалзсаныг Коминтерн, ЗХУ-ын К(б)Нам овжин ашиглаж, Зөвлөлтийн нөлөөний хүрээнд түүний дагуул улс (буфер улс) болгох бодлогоо улам бүр идэвхжүүлэх, Монголд улс төрийн хилс хэрэгт олон мянган хүнийг хэлмэгдүүлэх гол шалтгааны эхлэлийг тавьсан.

Нөгөө талаар 1939 онд Монгол-Зөвлөлтийн цэрэг Халхын голд Япон, Манжгогийн цэргийн хүчийг ялсан нь БНМАУ-ын гадаад аюулгүй байдлыг тодорхой хэмжээгээр бэхжүүлсэн гэж дүгнэж болно.

**Ашигласан материал:**

1. Мягмарсамбуу.Г., "Бүс нутаг, монголын түүхэн дэх Барга" (Улс төрийн түүх 1900-1960 он) УБ., 2017.,
2. Батбаяр.Ц, Гомбосүрэн.Д, "Монгол Манжгогийн хилийн хэлэлцээ" (Цэрэг-дипломатын түүх) УБ., 2004.
3. "Монгол Улсын төр, цэргийн зүтгэлтэн маршал Г.Дэмид" /Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл/ УБ., 1996.
4. Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийд, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс, "Лам нар сүм хийдийн хэлмэгдэл ба цагаатгал" УБ, 2008.
5. "Хичээнгүй сайд" сан, "Монгол Улсын гадаад бодлого: Хичээнгүй сайд Балингийн Цэрэндорж" УБ., 2011.
6. Гомбосүрэн.Д, "Түүвэр зохиол" I боть. (Монголын түүх судлалын өгүүллүүд) УБ., 2005.
7. Наранхүү.Н, Бакалаврын ажил, "Монгол Улсын гадаад аюулгүй байдалд геополитикийн орчин нөлөөлсөн нь (1990-2003 он)" УБ., 2004.
8. ШУА, "90-ээд оны Олон улсын харилцааны хандлагууд, Монгол Улс, их гүрнүүдийн харилцаа" УБ.
9. Баярхүү.Д, "Евроазийн геополитик, олон улсын харилцаа" УБ., 2002. 10.Столыпин.А, "Москва-Бээжингийн завсар дахь монгол орон" УБ., 2000.
11. Отгонжаргал.С, "XX зууны монголын түүхийг шинээр эргэн харахуй" (1921-1990) УБ., 2003.
12. Даваадорж.Н, "Эх орны төлөө" (Цэрэг-Улс төр, түүхийн судалгаа 1930-1952 он) УБ., 2018.
13. Дашдаваа.Ч, "Коминтерний төлөөлөгчид" УБ., 2019.
14. Гомбосүрэн.Д, "Түүвэр зохиол" УБ., 2005.
15. "Маршал Г.Дэмид" УБ, 1994.
16. "Ардчилал таймс" сонин. 2019.5.30, №101 (163)
17. <https://istmat.org/node/54703>, 2022.05.17
18. <https://mn.eferrit.com/> 2022.05.10
19. <http://1937god.info/node/913>, 2022.05.17
20. <https://mn.warbletoncouncil.org/demagogo-1108>, 2022.05.10
21. <http://ikhmongol.mn/show/397>, 2022.05.12



## УЙГУРЫН АРХИТЕКТУР БА УРАН БАРИЛГЫН ЧИМЭГЛЭЛ

**Ц.БЯМБА-ЭРДЭНЭ** /БХЭШХ-ийн ЦТССТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр, ахлах дэслэгч/

**Э.ТҮВШИН** /БХЭШХ-ийн ЦТССТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр/

**Түлхүүр үг:** Уйгар хот, Хар балгас, Уйгурын архитектурын байгууламжууд

**Key words:** Uighur city, Khar Balgas, architectural structures of Uighur

**Оршил.** Манай орны нутаг дэвсгэрт хадгалагдан үлдсэн эртний түүх соёлын арвин дурсгалын дотор эртний хот суурин, уран барилгын дурсгал нэн өвөрмөц байр суурийг эзэлдэг. Учир нь, монголчууд болон тэдний өвөг дээдэс ерөөсөө л цэвэр нүүдэлчин байж, цаг үргэлж нүүж сууж явснаас бус, хот орон байгуулж суурьшин сууж байсан нь огт үгүй хэмээх үзэл ихэд газар аван ноёрхсон байжээ. Гэвч Төв Азийн нүүдэлчидтэй эртнээс хөрш зэргэлдээ сууж, тэдний амьдрал ахуйн талаар олон зүйлийг тэмдэглэж үлдээсэн нангиад сурвалж түүхийн тэмдэглэлд умардын нүүдэлчид нь өөрийн орон нутагт цөөн ч атугай хот сууриныг үүсгэн байгуулж тодорхой хэмжээгээр суурин амьдралыг эрхэлж байсан талаар мэр сэр мэдээ баримт тохиолддог.

Монгол нутаг дахь археологийн дурсгалыг шинжлэх ухааны үүднээс тандан судалж эхэлсэн XIX зууны сүүл үеэс эртний хот суурины ор үлдэгдлийг илрүүлэн олж тодорхойлон бичиж, нийтэд мэдээлэх ажил эхэлсэн байна. Монгол нутагт археологийн судалгаа өргөн зохиох болсноор олон үеийн нүүдэлчдийн барьж байгуулсан, цаг хугацааны хувьд МЭӨ II зуунаас дундад зууны сүүл буюу ХVII зууныг хүртэлх үед холбогдох 300 орчим хот суурин газрын ор үлдцийг олж тогтоосон нь дээр өгүүлсэн ташаа үзэлд няцаалт өгөх жинхэнэ биет баримт хэрэглэгдэхүүн болжээ.

**Үндсэн хэсэг.** Монгол нутаг хэмээх түүхэн ойлголт нь ганцхан өнөөгийн Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаар төдийхний хүрээнд яригдах

асуудал бус, харин монгол хэмээх угсаатан анх мандан гарч, улмаар тархан сууж, өөрийн өвөрмөц түүх соёлоо мандуулан бадрааж, олон үеийн биет хөшөө дурсгалаа цогцолж үлдээсэн өлгий нутаг, тодруулж хэлбэл умрын Байгал нуур, өмнөш Түмэн газрын их цагаан хэрэм, дорно Хянганы уулс, өрнө Алтайн уулс, Зүүн гарын говийг хүртэлх байгаль цаг агаарын эрс тэс нөхцөл бүхий Монголын өндөрлөг хэмээн нэрлэгдсэн уудам газар орон болно. Энэхүү газар нутагт оршин суусан нүүдэлч овог аймгууд нь байгаль цаг агаар, хүрээлэн буй орчны онцлогоос хамааран нүүдлийн мал аж ахуйг амь зуулгын гол хэлбэр болгон эрхэлсээр ирсэн бөгөөд үүнийхээ зэрэгцээ аль нэгэн хэмжээгээр суурьшин сууж түүхэнд нэрээ мөнхөлсөн хот суурины дурсгалыг ч цогцлон бүтээж байсан нь эрдэмтэн судлаачдын анхаарлыг татсаар байдаг. Ийнхүү эрт цагаас хот сууринтай байсны эш баримт нь монгол хэлэнд хот байгуулалт, уран барилгын холбогдолт нэр томьёо арвин байдгаар ч давхар батлагддаг билээ.

Түрэгийн дараа Монгол нутагт төр улсаа байгуулж мандан гарсан Уйгурууд нь хот балгад барьж суурьшин суух талаар бусад нүүдэлчдээс нэлээд онцлог байв. Тэд манихейн шашныг дэлгэрүүлж, согдын гар урчуудын туслалцаатайгаар энэхүү шашны сүм дуган барьдаг байжээ.

Уйгурууд дөрвөлжин шавар хэрэмт бэхлэлт хотуудыг их барьдаг ба хил хязгаарыг сэргийлэн хамгаалах бэхлэлт хотын бүхэл бүтэн сүлжээ бүрэлдэн



тогтсон байжээ. Эдгээр суурин газар нь суурьшмал амьдралын төв болж, газар тариалан, гар урлал, худалдаа наймаа цэцэглэн хөгжиж байв. Манай улсын нутагт Уйгур улсын сүр жавхлантай нийслэл Ордубалык буюу Хар балгас, мөн шашин номын томхон төв болж байсан Сэлэнгэ мөрний хөвөөн дэх Бийбулагийн балгас зэрэг хотыг археологийн талаар шинжин судалж байжээ<sup>1</sup>.

Энэ удаад бид Уйгурын Хар балгас хотын малтлага судалгаагаар илэрсэн олдворын цогц байдлыг одоогоор малтан судалсан Уйгурын үеийн булш оршуулгын дурсгалаас илэрсэн олдворын цогц байдалтай харьцуулан судалсан судалгааны үр дүнгээ танилцуулж байна. Уйгурын нийслэл Ордубалык буюу Хар балгасыг (Зураг 1) Монгол, Германы хамтарсан экспедиц 2009 оноос эхлэн тасралтгүй судалж байгаа бөгөөд энэхүү шинжилгээний дүнд хэд хэдэн барилга архитектурын зохион байгуулалт илэрсэн юм.

Ордон /Сүм/-ийн хотоос урагш, түүнтэй өөрийн барилгын шугамаар зэрэгцээ байрлалтай, төв хэсэгтээ нэгэн их гол барилгатай, цогцолборынхоо баруун хойд хэсэгт жижиг жижиг туслах барилгуудтай, гадуураа давхар хэрмээр хүрээлэгдсэн байгууламж (НВ1) бий. Энэхүү байгууламжийн гол тэнхлэгийн харалдаа хоёр дахь хаалганы архан талд Хар Балгасын гурван хэлээр бичсэн гэрэлт хөшөөний үлдэгдэл байдаг.

832 онд босгосон хэмээн он цагийг нь тогтоосон уг хөшөөний хятад, эртний түрэг, согд гурван хэлээрх бичээст Манихейн шашны их ялалтыг магтан дуулжээ. Энэ учраас Финийн түрэг судлаач эрдэмтэн Г.И.Рамстедт гурван хэлээрх бичээстэй хөшөөний чулуу байгаа тэр цогцолборыг хотын Манихейн шүтээний төв байсан болов уу гэж таамагласан байдаг. Харин XIII зууны үеийн перс хүн

Жүвейнигийн мэдээлснээр бол, гэрэлт хөшөө ордны өмнө оршиж байсан аж. Өөрийнх нь хүрээ хэмжээ, бүтэц зохион байгуулалт, байрлалынх нь хувьд авч үзвэл, ямартай ч гэсэн, ордон, сүм эсвэл уйгур бичээст, Эзэнт гүрний харш” хэмээн нэрлэгдсэн төв засаг захиргааны цогцолбор, олон нийтэд зориулагдсан, онцгой ач холбогдолтой, нэгэн чухал барилгын цогцолбор энд оршин байжээ<sup>2</sup>.

Эндхийн хамгийн том барилгын суурийг үзэхэд, хойноос урагш чиглэлтэй, 50х30 метр хэмжээтэй, тэгш өнцөгт хэлбэртэй, бараг 3 метр өндөр шороон тавцан байх бөгөөд хойд талын ханаараа арынхаа барилгатай хүзүүвчээр холбоотой байжээ. 2009 оны зун хийсэн малталтыг цаг хугацааны байдлаас шалтгаалж хойд талын гадаад хэрмийн дэргэд байгаа нэгэн туслах барилгын судалгаагаар хязгаарласан бөгөөд хэрмийн дээр хийсэн зүсэлтээр энд тоосгоор өнгөлөөгүй, шавар дэлдэж хийсэн зузаан хэрмэн хана байгааг олж тогтоосон юм. Туслах барилгаас олдсон керамик олдворууд Киданы үед (X / XI зуун) дахин ашиглаж байсан байж болзошгүйг зааж өгч байна. Харин барилга нь өөрөө VIII юм уу IX зууны үед хамаарахыг тэндээс гарсан Тангийн үеийн дээврийн ваар хийгээд Уйгурын керамик харуулж байгаа юм.

Барилгыг дүнз мод ба түүхий тоосгоор барьж, ханыг нь шавардаж байсан бөгөөд 2009 онд малтан судалсан туслах барилгын баруун өмнөд хэсэгт, байшин хаягдаж орхигдсоноос хожим хойно аваачиж тавьсан нэгэн залуу хүний оршуулга илэрсэн юм. Булшийг оршуулгын зан үйл, зүг чиг, хойлгын эд зүйл ба булшны хэлбэрийн онцлог шинжээр нь дундад эртний Монголын үеийнх (XIII-XVI зуун) хэмээн он цагийг нь тогтоож байна. Энэ нь Монголын үеийн хөмөгт булш болох нь илэрхий

<sup>1</sup> Цэвээндорж Д, Баяр Д, Эрдэнэбат У. Монголын эртний хот суурины судалгаа. Монголын археологийн шинжлэх ухаан. Боть №32. Ботийн редактор Д.Цэвээндорж, У.Эрдэнэбат. УБ., 2007 т.96-103

<sup>2</sup> Ханс-Георг Хюттель, Эрдэнэбат У. Хар балгас ба Хархорум Орхоны хөндий дэх хожуу нүүдэлчдийн суурьшмал хоёр хот. УБ., 2010 62-63-р тал



байсан бөгөөд хүүрийн толгойг хойд зүг чиглүүлэн биеийг нь байшингийн баруун хана дагуу зэрэгцүүлэн тэнэгэр байдлаар тавьжээ. Булшны хөмгийг байшингийн хатуу шавар ханыг хөндийлөн ухаж хийжээ. Уйгурын үеэс (VIII/IX зуун) гаралтай уг барилга оршуулга үйлдсэний дараачаас яах аргагүй бүрмөсөн хаягдсан ажээ.

Хар Балгасын гэрэлт хөшөөний хойно орших том барилгын (НВ1) зүүн ханыг бүтэн талбайгаар, хойд, урд, баруун талын хана болон барилгын танхимын гол төв хэсгийг хэсэгчилсэн байдлаар 2010-2011 оны хээрийн шинжилгээний явцад малтан судалсан билээ. Судалгааны дүнд, уг байгууламж нь 48 х 24 метр хэмжээтэй, сайтар шатаасан хөх тоосгоор өнгөлсөн, 2 метр өндөр шаталсан довжоотой, гурван талдаа хаалгатай, боржин чулуун суурьтай олон багана бүхий нэгэн их танхимаас бүрдсэн, хийц хэлбэрийн хувьд нэлээд гоёмсог барилга байсан гэж урьдчилан тогтоосон юм. Барилгын үндсэн материал нь мод, шавар, түүхий тоосго байсан бөгөөд ханыг нь шавардаж дээр нь элдэв зураг хуар зурж чимэглэдэг байжээ. Барилгын зүүн ханын хойд хэсэгт өгсүүр шатны ором илэрсэн ба түүний суурийг хийхдээ шавар дэлдэн дагтаршуулж, гадаргууг өнгөлөн, гишгүүр гаргалгүй налуулан тэгшилж шатаасан тоосго, засмал боржин чулуу холилдуулан өрж зассан байв.

Барилгын дээврийг ваараар хучиж нүүрэн талыг элдэв чимэглэлээр гоёж байсан агаад модон хашлагатай, вааран хавтангуудаар угсарч хийсэн бороо цасны ус зайлуулах хоолойн үлдэгдэл бас олджээ. Малтлагаас барилгын түүхий тоосгон ханын үлдэгдэл, ханын шаваасан дээр улаан, ногоон, хар, хөх өнгийн будгаар хээлж зурсан ханын зургийн жижиг хэсгүүд, сайтар шатааж үйлдсэн дээврийн тосгуур, нөмрөг, нүүр ваарууд, бадамлянхуа цэцгийн дүрстэй шавар чимэглэл, төмөр хадаас, харвуулын сумны зэв, тээрмийн чулуу, ногоон

паалантай бүтэн вааран сав, Тан улсын (618-907) үеийн хятад зоос зэрэг онцлог олдворууд олдсон байна.

Хар Балгасын ордны буюу сүмийн хотын цайзат их хэрмээс баруун урд зүгт, хотын хойш урагш чиглэлтэй төв их гудамжнаас баруунш чиглэсэн нэгэн туслах гудамжны төгсгөлд орших гадуураа тусгай шороон хэрэм бүхий нэгэн байгууламжийг (НВ3) 2010 онд сорилтын журмаар малтан судлав. Уг барилгын шороон хэрэм 90 х 45 метр хэмжээтэй, зүүн талдаа нэг хаалгатай юм. Малтлагын явцад барилгын дээврийг тулж байсан баганын суурь чулуу 13 олдсон.

Airborne Laserscan дэвсгэр зурагт тодорхой харагдаж байгаа хотын энэхүү дүүрэг нь орчин тойрноосоо 900 х 1000 м хэмжээтэй, тодорхой мэдэгдэм өргөгдсөн хэрмээр тусгаарлагдсан байдаг. Их хотын хойноос урагшаа үргэлжилсэн өргөн чөлөө маягийн их гудамжны дагуу, энэхүү НВ3 хэмээн нэрлэсэн дүүрэг рүү орох хэсэгт уг хэрэм хэсэг газраа тасарсан маягтай үзэгдэнэ. Энэхүү тасархайг ямар нэгэн хаалга байсан газар уу, эсвэл хуучин малтлага хийгээд шороог нь буцааж тавиагүй үлдээсэн сорви уу гэдгийг одоо болтол хэн ч тогтоогоогүй юм. 2012 оны хээрийн шинжилгээний явцад 130 м<sup>2</sup> орчим талбайд малтлага хийсний дүнд хэрмийн энэхүү орон зай нь хуучин тэнд хаалга байсантай холбоотой болохыг тогтоосон юм. НВ3 хэсгийг хүрээлж буй шавар дэлдэж хийсэн зохион байгуулалттай хэрэм нэлээд бүдгэрч элэгдсэн боловч одоогийн хадгалагдсан өндөр нь зарим газраа 0,8м хүрэх бөгөөд хэрмийн зарим хэсэгт түүхий тоосгоор өнгөлж байсан ханын ул мөр мэдэгдэнэ. Түүний зэрэгцээ зэрэгцээ шавар хэрмийг бат бөх болгохын тулд голд нь модон шургаагуудыг хөндлөнгөөр нь зэрэгцүүлэн бэхэлгээ хийсэн ажээ. Өнгөн хөрсөн дээр шууд байгуулсан энэхүү хэрмийн дотор талаар ус зайлуулах суваг маягийн зүйл байжээ. Нурж унасан ханын одоо мэдэгдэж буй үлдэгдлээс үзэхэд уг



хэрэм дор хаяж 3-3,50 м өндөр байсан бололтой.

Энэхүү хэрмийн зүүн этгээдэд байгаа тасархай буюу 5м орчим өргөн хоосон орон зайд VIII-IX зууны үеийн хотын дүүрэг рүү орох модоор хийсэн хаалганы байгууламж оршиж байжээ. Хоорондоо тогтмол зайтай байрлаж буй дөрвөн баганын боржин чулуун суурь бол өдгөө түүний зохион байгуулалтаас үлдэж хоцорсон зүйл болох юм. Дээврийн ваарын хагархай олноогүйгээс үзэхэд хаалганы байгууламж нь ваарласан дээврээс өөр зохион байгуулалттай байжээ. Их гудамжны хэсэгт буй хаалганаас зүүн тийших томоохон талбайгаас болон мөн хаалганы асрын дотор талын хэсгээс ч гэсэн явган замын төвшинд хайрга дэвссэн гудамжны зохион байгуулалт илэрч мэдэгдсэн юм. Малтлагаас хээтэй ваарын хагархай, төмөр хадаас, их хэмжээний малын яс зэрэг олдсон болно. C<sub>14</sub>-ийн лабораторийн шинжилгээний дүнд тогтоосон он цаг нь (688-771 cal AD) хот байгуулан суурьшиж эхэлсэн цаг үетэй холбогдож байна<sup>3</sup>.

Хар Балгасын их хэрмийн доторх өндөр суваргын хажууд буй хоёр барилгын үлдэгдлийг 2010-2011 онд үргэлжлүүлэн малтаж сонирхолтой үр дүнд хүрсэн билээ. Хоорондоо нарийхан хүзүүвчээр холбоотой энэ хоёр барилга зохион байгуулалтын хувьд маш өвөрмөц бөгөөд энэхүү барилгын дотроос тоосгон хавтан дээр зурсан жиргээ тоглоомын хөлөг ба ногоон, шар өнгөтэй шилэн хасаа нэлээд хэд илэрсэн байна.

Баруун барилга буюу их суваргын өмнөх байгууламж нь зузаан ханатай, хөх өнгийн дагтаршуулсан шавар шалтай бөгөөд нүүрэн талдаа хоорондоо 2 метр орчим зайтай цувран байрласан хүчирхэг 9 баганатай байжээ. Баганын суурийг хийхдээ 18–20см орчим зузаан, 96х97см хэмжээтэй дөрвөлжлөн засаж

бэлтгэсэн, бүдүүн ширхэгтэй боржин чулуун дээр 7 см товгор, 75 см орчим голчтой дугуй хүрээ гаргаж, тэр хүрээний зах ирмэгийг бадамлянхуа цэцгийн 16 дэлбээ болгон маш уртай сайхан сийлбэрлэсэн байна. Эндээс түүхий болон шатаасан тоосго, дээврийн нүүр ваар, нөмрөг ваарын хагархай, ханын шаваасны хэсгүүд, бог болон бод малын яс, хүрэл болон төмөр эдлэлийн үлдэгдэл зэрэг олдвор илэрсэн юм. Мөн уг барилгыг ашиглагдахаа больсны дараа тавьсан бололтой хүний оршуулга хөх шалны зүүн захаас олдсон бөгөөд барилгын хуучин нуранги тоосгыг булшны дараас болгон хэрэглэсэн байв. Оршуулгын зан үйл, дагалдуулсан эд өлгийн онцлогоос үзэхэд XIII-XVI зууны үеийн булш бололтой. 2011 оны малталтаар уг барилгын ерөнхий зохион байгуулалт, өрөө тасалгааны байдал улам тодорхой болсон бөгөөд эндээс дундуураа халуун утаа гүйх хоолой бүхий зузаан шавар ханын үлдэгдэл, хөх өнгөтэй дагтаршуулсан шал, луун арслангийн толгойн дүрстэй шатны чулуун тулгуур, үзэмжит сайхан хээ чимэгтэй ханын чимэглэл, нүүр ваар, тамга тэмдэг бүхий дээврийн ваар зэрэг онцлог олдвор олон гарсан байна.

Үүнээс гадна Хар Балгасын цайзат их хэрмийн баруун урд өнцөгт орших цитадель дээрх хуучин малтлагын нүхийг 2010-2018 онуудын малтлага судалгааны үр дүнд цитадель гэж нэрлэдэг хотын энэхүү хэсгийн архитектурыг судлах цоо шинэ эх хэрэглэгдэхүүнийг бүрдүүлж байна. Цитадель нь HB2 буюу сүм/ордон хотын яг зүүн урд буланд шавар, хайрга, элс шороо үелүүлэн дэлдэж хийсэн бараг 7м өндөр 60х70м орчим аварга том тавцан дээр байрлах бөгөөд зүүн болон урд талаасаа дор хаяж 12м өндөр хадгалагдсан ордон хотын хэрмээр хамгаалагджээ.

Цитадель дээрх байгууламж нь

<sup>3</sup> У.Эрдэнэбат Архангай аймгийн Хотонт сумын нутаг Хар балгас болон Олон довын дурсгалт газар явуулж буй малтлага судалгаа. Илтгэл. УБ., 2011



баруун болон хойд талдаа хаалга үүдтэй байсан нь мэдэгдэх бөгөөд үүгээр үзэхэд зөвхөн ордон хотын хэрмийн дотор талаас л орж гарах боломжтой байсан аж. 2013-2014 онд уг байгууламжийн баруун талын ханын зохион байгуулалтыг дайруулан малтаж хаалганы байгууламжийг илрүүлэн олсон юм. Энэ малтлагын явцад уг байгууламж руу орж гарах хаалга үүдний ор үлдэгдэл илэрч мэдэгдсэн төдийгүй элс, шавар үелүүлэн дэлдэж хийгээд шургааг модоор бэхлэн гадуур нь тоосго өрж гадарласан 5м өргөн ханатай байсан нь илрэн гарч байна. Эндээс газар суулгасан хаалганы самбарын бэхэлгээ ба хаалга руу очдог замын хэсгийг модон банзаар шалласны үлдэгдэл ч олдсон билээ. Харин хаалганы байгууламжийн дотор талыг шатаасан тоосго дэвсэн шалласан бөгөөд бороо цасны ус тогтохгүй урсаж гарахаар тооцоолж гадаргууг нь хийсэн ажээ.

Хаалга үүдний эдгээр зохион байгуулалтаас гадна эндээс өгсөж гарах тусгай шат бүхий тоосгоор өнгөлсөн тавцанг малтаж гаргав. Энд илэрсэн олдворын цогц байдлаас үзэхэд, хэрмийн баруун хаалгаар ороод цааш тусгай тоосгон замаар явж 0,7м өндөр тавцан дээр байрлуулсан гурван гишгүүртэй жижгэвтэр шатанд тулж улмаар түүгээр дээш өгсөж цитадель хэмээх энэхүү байгууламж руу нэвтрэн орж гардаг байсан бололтой. Эдгээр олдворын цогц байдалтүүнийг хүрээлж байгаад дээрээс нь нурж унасан асар том шавар ханын нуранги дор байлаа. Эндээс модон банзаар шалласан шатны гишгүүр, модон жаазны хүрээнд ердийн шатаасан тоосгыг дээр дээрээс нь давхарлан өрөх маягаар хатавчийг нь өнгөлсөн хаалганы үлдэгдэл, бороо цасны ус зайлуулах суваг бүхий тоосгон зам зэрэг уг байгууламжийн зохион байгуулалтыг судлахад чухал ач холбогдолтой хэрэглэгдэхүүн олдсон юм.

Хаалганы зохион байгуулалтаас гадна цитаделийн зүүн өмнөд хэсэгт явуулсан малтлагаас монументаль

архитектурын олон тооны үлдэгдэл илрэн гарсан юм. Энэхүү барилгын зарим хэсгийг бүр ХХ зууны эхээр оросын археологичид малтсан байлаа. Хүрээлэн буй хэрмийн зузаан ба үүрэг харьцааны тухай асуудлыг судлах зорилгоор оросуудын малтлагын хуучин нүхийг зүүн тийш нь өргөтгөн тэлж малтлагыг үргэлжлүүлэв. Хүчтэй галд шатсан тоосго, дээврийн ваар голдуу бараг 4м зузаан үнс нурангийг зайлуулан малтсаны дараа барилгын өрөө тасалгааны хэсгүүд илрэн гарч эхэлсэн. барилгын тасалгааны зөвхөн баруун болон зүүн ханыг баримтжуулсан бөгөөд 2014 онд үргэлжлүүлэн малтан судалж барилгын зүүн, баруун, хойд ханыг бүрэн гаргасан юм. Өрөөний дотор талыг барилгын дээврийг тулж байсан гурван эгнээ баганын суурь чулуу зааглан хувааж байна. Эдгээрийн онцлог байдал гэвэл, төвийн хэсэгт байрласан бөгөөд дээвэр нурууны хамгийн их даралтыг тулах хүнд даацын баганын сууриудыг маш зузаан бат бөх чулуугаар ихээхэн ур гарган хийж, харин зах хөвөөгөөр байрлах баганын сууриудыг нимгэвтэр чулуугаар хийсэн нь цөм анхны байрандаа хадгалагдаж үлдсэн байлаа. Баганын суурь бүрийг тусгайлан зассан байх бөгөөд үндсэндээ хоёр янзын хийц загвар голлоно. Тухайлбал, хоёр захын зургаан суурь (65x70смx25см) нь ямар нэгэн хээ чимэг үгүй, тэг дөрвөлжин хэлбэрийн энгийн хийцтэй бол дунд эгнээнд буй баганын гурван суурь (115x118x28см) нь дөрвөн тал бүхий хавтгай оройтой, дөрвөлжин суурьтай, орой дээрээ баганын мод суулгах тусгай ховил гаргаж зассан уран хийцтэй байна.

Баганын суурь чулууны хооронд илэрсэн шалны түвшинд хөх саарал өнгийн шавар зуурмаг мэдэгдэх бөгөөд барилгын дотор талын өрөө тасалгаануудыг шатаасан хөх тоосгоор хоёр давхарлаж шалласан байжээ. Барилгын шавар ханыг хоёр талаас нь хашсан дүнзэн баганын үлдэгдэл малтлагын үед биет байдлаар



цөөн тоотой гарсан ч гэсэн, модон багана нь шатахад үлдэж хоцорсон хоосон ормууд нь шавар ханан дээр тун сайн хадгалагдаж үлдсэн байв. Энд хадгалагдсан олдворын цогц байдлыг үзэхэд, шавар ханыг бэхэлсэн багануудыг гурав болон таваар нь хэсэгчлэн эгнүүлж хооронд нь тодорхой зайнд нарийн эрэмбэ дараатай байрлуулсан байжээ. Барилгын өрөөг заагласан ханын зохион байгуулалтаас 1-3м өндөр хадгалагдсан бөгөөд хийсэн байдлаараа өөр хоорондоо ялгаатай байна. Шавар үелүүлэн дэлдэж хийсэн зузаан ханын дотор ба гадна талыг модон баганаар бэхэлж дээрээс нь шавраар шавж чимэглэл зурж байсан ором мэдэгдэж байв. Ханыг ингэж хосолмол байдлаар хийснээр томоохон барилгын дээвэр нурууны эд ангиудыг холбож тогтоох ба нүсэр хүнд дээврийг тулах даацыг сайжруулахад чухал нөлөөтэй болжээ. Энэхүү барилгын ханын зузаан, хадгалагдаж үлдсэн өндөр, баганын суурийг хийж урласан байдал, өрөө тасалгааны хэмжээ зэрэг уран барилгын бүрдэл хэсгүүд нь бүхэлдээ Хар Балгаст одоо хүртэл мэдэгдсэн барилгуудынхаас нэн онцлог юм. Ялангуяа сүрлэг том байдал, барилгын бүрдэл хэсгүүдийн өвөрмөц байдал нь энэ барилга ямар нэгэн онцгой үүрэгтэй байсныг илтгэн харуулна.

Хар Балгасын цитадельд 2018 оны малтлага судалгааны үр дүнд Уйгурын нийслэлийн Ордон хотын худгийг (Зураг 2), бүтэн талбайгаар малтаж баримтжуулсан нь манай оронд судалсан эртний хот балгадын туриас ийм төрлийн дурсгалыг илрүүлэн олж малтсан анхны тохиолдол<sup>4</sup> болсон юм.

Энэхүү эртний худаг нь өвөрмөц хийц, инженерийн маш нарийн шийдэл бүхий бүтэцтэй. Барилгын шалнаас худгийн амсар хүртэл модон банзаар жаазалж хийсэн 7м орчим гүн доторлогоо, үүнээс доош ёроол хүртэл 5м үргэлжилсэн засмал боржингоор

үйлдсэн доторлогооны чулуун өрлөг ба ус хуримтлагдах модон тасалгаа гэсэн хэд хэдээс бүрдэж байжээ. Худаг дотроос олон төрөл зүйлийн эд өлгийн зүйлийн эд өлгийн зүйлс илэрч олдсоны дотор зарим нь Уйгурын хот суурины дурсгалаас урьд өмнө илэрч байгаагүй шинэ хэрэглэгдэхүүн байв. Тухайлбал, хоёр талдаа тус бүр дөрвөн нангиад үсэгтэй хүрэл хонх (Зураг 3), барилгын дээврийг тулж байсан нүсэр том модон багана, гантиг чулуун арслангийн хугархай, алтадсан төмөр цоож, ургамлын дүрсээр хээлсэн чий будагтай хос модон баганын хугархай, төмөр сөрөгө зэрэг олджээ.

### Дүгнэлт

Хар Балгасын цитадельд хийсэн малтлагын явцад хүчтэй гал түймэрт эрсдэн шатаж устсан сүрлэг том барилга болоод шороо дэлдэж хийсэн хүчирхэг их хэрмийн бүтэц зохион байгуулалтыг хадгалсан зузаан үе давхаргууд, харьцангуй өндөр бөгөөд сайн хадгалагдсан барилгын зузаан хана туурганы үлдэц, барилгын дээвэр нурууг тулж байсан баганын чулуун сууриуд, шавар ба тоосгон шалны үлдэгдэл зэрэг VIII-IX зууны Уйгурын нийслэл хотын барилга архитектурын бүтэц зохион байгуулалтыг судлах шинэ эх хэрэглэгдэхүүнийг илрүүлэн олсон билээ. Үүний хамт барилгын хэрэглэгдэхүүн болох шатаасан болон түүхий тоосго, модон хийцийн үлдэгдэл, янз бүрийн төмөр хадаас, дээврийн нөмрөг ба тосгуур ваар, шавар сав суулганы хагархай, дээврийн чимэглэл болох хэдэн төрлийн хээтэй нүүр ваар, нэн ялангуяа байшин барилгын нуруу, дээврийн хэсэгт муу муухай бүхнээс хамгаалахыг бэлгэдэн байрлуулдаг домгийн амьтны шавар баримал дүрсийн үлдэгдэл, өнгийн будаг бүхий ханын шаваас, сийлбэртэй ясан чимэглэлийн хугархай, төмөр сөргөө, харвуулын сумны зэв, гантиг чулуун самбар дээр алт суулган сийлж бичсэн хятад бичээстэй сүмийн сүнсэн

<sup>4</sup> Эрдэнэбат У, Франкен К, Батбаяр Т, Рооланд Х. Уйгурын нийслэл Хар балгасанд 2018 онд Монгол-Германы Орхон экспедицийн хийсэн малтлага судалгаа. Монголын археологи-2018 УБ., 2019 т.254



тахилын үлдэгдэл, элдэв янзын тамга тэмдэгтэй дээврийн ваарын хагархай, цэцгэн толгой бүхий алтан шармал зэс хадаас, цэцгэн зэс чимэглэл, маш гоёмсог хээ чимэгтэй жижигхэн чулуун тулгуур зэрэг онцлох эд өлгийн

зүйлс олдсон юм. Эдгээр олдворууд нь Уйгурын бунхант булш буюу дөрвөлжин, ОХУ-ын нутагт орших Пор-Бажийн зэрэг газруудаас олдсон байна.

### Ашигласан материал:

1. Ханс-Георг Хюттель, Эрдэнэбат У. Хар балгас ба Хархорум Орхоны хөндий дэх хожуу нүүдэлчдийн суурьшмал хоёр хот. УБ., 2010.т. 62-63
2. Цэвээндорж Д, Баяр Д, Эрдэнэбат У. Монголын эртний хот суурины судалгаа. Монголын археологийн шинжлэх ухаан. Боть №32. Ботийн редактор Д.Цэвээндорж, У.Эрдэнэбат. УБ., 2007 т.96-103
3. У.Эрдэнэбат Архангай аймгийн Хотонт сумын нутаг Хар балгас болон Олон довын дурсгалт газар явуулж буй малтлага судалгаа. Архангай аймгийн Хотонт сумын нутаг Хар балгас болон Олон довын дурсгалт газар ажилласан хээрийн судалгааны ангийн тайлан.
4. Эрдэнэбат У, Франкен К, Батбаяр Т, Рооланд Х. Уйгурын нийслэл Хар балгасанд 2018 онд Монгол-Германы Орхон экспедицийн хийсэн малтлага судалгаа. Монголын археологи-2018 УБ., 2019 т.254



Зураг 1. Уйгурын эзэнт гүрний нийслэл Ордубалык буюу Хар балгасын турь, Архангай, Хотонт



Зураг 2. Хар балгасын Ордон хотын худгийн чулуугаар доторлосон хэсгийн байдал



Зураг 3. Хар балгасын  
худгийн ёроолоос  
гарсан хүрэл хонх



1,3. Өвөх хавцлын ам 3-р дөрвөлжин  
5,6,7. Хар балгасны олдворууд

2,4. Пор-Бажын, Тува Орос  
8. Тан улсын нийслэл Чаньянь, Хятад

Зураг 4. Зарим олдворын харьцуулсан зураг



## ХҮННҮ ГҮРНИЙ ТҮҮХЭН НУТАГ ДЭВСГЭР

**Т.ЭРДЭНЭХИШИГ** /БХЭШХ-ийн ЦТССТ-ийн ЭШТА, доктор (Ph.D), профессор/

**Түлхүүр үг:** Хүннү гүрэн, Модун шаньюй, Дунху, Хан улс, Цагаан хэрэм

**Key words:** Xion nu empire, Maodun chanyu, Dunhu, Khan guo, Great wall

**Оршил.** Хүннү улс аливаа улсын нэгэн адилаар тусгаар тогтнолын баталгаа болсон газар нутаг, хил хязгаартай, түүнийг хариуцсан сахин суух вантай, хилийн хамгаалалтын цэрэгтэй байжээ.

Модун шаньюйн үед хөрш Дунху нар Хүннүгийн хил орчмын хүн нутагладаггүй хэсэг газрыг нь гуйхад “Газар бол улсын үндэс” хэмээгээд, газраа өгөхийг зөвшөөрсөн түшмэдийн толгойг авч байсан явдал нь Хүннүгийн газар нь улсын өмч байсныг харуулж байгаа төдийгүй Модун шаньюй газрыг төр улсын оршин тогтнох үндэс суурь мөн хэмээн үзэж, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг юу юунаас илүү чухалчилж байсныг гэрчилнэ. Ийнхүү Хүннү улсын нийт газар нутаг, ус бэлчээр нь улсын өмч байсан учир эрх мэдэлтэй хэн ч бай газраа бусдад худалдах, бэлэглэх, дураар нутаг солин сэлгэн нүүх эрх мэдэлгүй байжээ.

**Үндсэн хэсэг.** Хүннүгийн шаньюй-гаас зарим нэг тодорхой газар нутгийг тэнд оршин суух хүмүүсийн хамт түмтийн дарга нарт өгч захируулдаг байсан ба тийм газар нутгийг “Фэньди” гэж нэрлэдэг байжээ. Ийм “Фэньди” буюу хувь газар захиран суудаг түмтийн дарга нар болон вангууд нь албан тушаал өөрчлөгдөх болбол уг тушаалд томилогдон ирсэн дараагийн хүнд захирч байсан нутгаа шилжүүлэн өгдөг байжээ.

Модун Шаньюй газар нутгаа зүүн, баруун, төв гэсэн гурван хэсэгт хуваан, төв хэсгийг өөрөө удирдаж, зүүн, баруун хэсгийг ойрын итгэлт төрөл төргөгсдөөсөө томилон удирдуулдаг

байв. Хүннү нар зүүн зүгийг эрхэмлэн үздэг учир зүүн хэсгийн (жигүүрийн) албан тушаалтнууд нь баруун хэсгийнхнээсээ эрх мэдлээр илүү байжээ. Хүннүгийн энэхүү гурван жигүүрийн тогтолцоо нь асар өргөн уудам нутагт мал даган нүүдэллэж, тархай бутархай аж төрдөг овог аймгуудыг нэгэн захиргаанд барих, нөгөө талаар гаднын халдлага довтолгооноос сэрэмжлэн хамгаалах зэрэг улс төр, цэрэг стратеги, газар зүйн чухал ач холбогдолтой зохион байгуулалт байв. Чухам тийм учраас Төв Азид хожим нь удаа дараалан оршин тогтнож байсан нүүдэлчдийн төр улсууд энэхүү тогтолцоог шууд авч хэрэглэж байжээ<sup>1</sup>.

Хүннүгийн зүүн гарын бүх ван жанжин нь Шангу муж (одоогийн Хэбэй мужийн Хуай Лай хошууны хэсэг газар)-ийн өөдөөс харан дорно зүгт Хуйхэ, Чаосянтай (эртний Солонгос) хил залгаж зүүн гарт нутаглана. Баруун гарын ван, жанжин нар Шанцзюнь муж (одоогийн Шэнси мужийн И лин хошууны хэсэг газар)-ийн өөдөөс харан, цааш Юэчжи, Ди, Цян нартай хил залган, баруун гарт нутаглана. Шаньюйн өргөө нь Дай муж (Өнөөгийн Хэбэй мужийн хошууны баруун өмнөд хэсэг), Юньчжун муж (өнөөгийн ӨМӨЗО-ны Тугат хошууны зүүн хойд хэсэг)-ийн өөдөөс харан байрладаг. Ван, ноёд тус бүр өвс, ус даган нүүх хувь газартай (шаньюйн хуваарилан өгсөн) бөгөөд тэдгээрээс зүүн, баруун сэцэн ван, зүүн, баруун гули вангууд нь хамгийн том эзэмшил газартай байв<sup>2</sup>.

Хүннүгийн шаньюйн шууд захиргаанд Хангайн нуруу, Хэнтийн

<sup>1</sup> Батсайхан Э. Хүннү. УБ., 2003. 152 дахь тал

<sup>2</sup> 史记. 卷. 110. 中华民国六十三年. 台北. 第2879页, 林 杆. 中国古代北方民族通论. 呼和浩特., 1999. 第150页, Сүхбаатар Г. Монголын эртний түүх судлал. Үү боть. (Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн эмхэтгэл) УБ., 2005. 146 дахь тал



уулсын баруун хэсэг, түүний өмнөх, хойтох нутаг харьяалагдаж байжээ. Зүүн этгээдийн Чжүки ноёны мэдэлд Хэнтийн нурууны зүүн хэсэг, түүнээс дорно зүгт Хянганы нуруу хүртэлх газар харьяалагдаж байжээ. Баруун этгээдийн Чжуки ноён Хангай, Алтайн хоорондох газар нутгийг харьяалж байв. Хүннү улс их гүрэн болсны дараа зүүн этгээдийн Чжүки ноёны харьяанд одоогийн Манжуур, Зүүнгар, Дорнод Туркестан орж ирсэн байна<sup>3</sup>. Хүннүгийн арван эвэрт ван зэрэг том том албан тушаалтны эзэмшин суух газрыг шаньюй тогтоон өгч байв. Дээрх том тушаалын түшмэд шаньюйн хуваарилан өгсөн нутаг дэвсгэртээ дахин хуваарилалт хийх замаар доод тушаалын хүмүүсийн суух газар нутгийг нь заан өгдөг байжээ.

Хүннүгийн хилийн хамгаалалтын талаар Шицзи-д: “Дунху Хүннүгийн хоорондох хүн нутагладаггүй орхигдсон эзэнгүй нутаг 1000 гаруй ли газар үргэлжилнэ, тус бүр хоёр захаар оуто болон нутаглана”<sup>4</sup> гэсэн мэдээ байдгаас харахад дээрх оуто гэгч нь хүннү, дунху хоёрт хоёуланд нь байжээ. Оуто гэх үгийн утганд хилийн хамгаалалттай холбоотой бүхий л асуудлууд багтаж байсан бололтой. Шицзи-д мөн “Оуто болон сууцгаана” хэмээн олон тоогоор бичсэнээс үзэхэд хүннүгийн хилийн цэрэг цөөн бус тоотой байсан<sup>5</sup> ба хилийг хариуцан захирсан ванг “Оуто ван” хэмээн нэрлэж байжээ. Сурвалжийн мэдээнээс харахад Модун шаньюйгаас бүр өмнө Хүннү, Дунху хоёр улсын хооронд ч хилийн ийм зурвас нутаг байсан байна.

Шаньюй хилийн асуудлыг том тушаалын ван, ноёдод хариуцуулж байжээ. “Хуханье шаньюйд (НТӨ 58-31) Учжулю жоти (НТӨ 8-НТ 13) хүү, Би гэх ач буй. Түүнийг өнгөрсний хойно дарааллын дагуу ахмад хөвгүүн ор

залгаж, НТ18 онд Хэдурши даогао жоти (19-46) шаньюйд өргөмжлөгдөн Би-г баруун юцянь жичжу вангаар томилж, өмнөд хил болон Ухуанийг түүнд хариуцуулжээ<sup>6</sup> гэсэн мэдээ байгаа нь нотолж байна.

“Хоу Хань шу”-д “Эзэн хаан харуулын албаны дарга, бие хамгаалагч Ли маог илгээх үеэр (шаньюй руу) Би нууцаар Го Хен гэгч Хятадад Хүннүгийн газрын зургийг нууцаар дамжуулж эзэн хаанд хүргэж өг хэмээжээ”<sup>7</sup> гэсэн байгаа нь Хүннү улс газрын зураг үйлддэг байсны баримт болно. Хүннүгийн газар нутгийн хэмжээ Модун шаньюй болон түүний дараах Лаошан шаньюйн үед ихэд өргөжин тэлжээ. Хүннү гүрэн хүчирхэгжин мандсан үед Хүннү улсын өмнөд хил нь НТӨ 198 онд Хан улстай байгуулсан гэрээ ёсоор Цагаан хэрмийн дагуу Ляодун мужаас эхлэн зүүн тийш одоогийн БНХАУ-ын Ганьсу мужийн Ланьчжоу хот хүртэл үргэлжлээд улмаар Нань шань уулыг дамнан Тэнгэр уул хүрч байжээ. Умард хил хязгаарын тухайд гэвэл Эрчис мөрнөөс эхлэн Оросын Алтайн умард бэл, зүүн баруун Саяны нурууны ар бэлээр дамнан улмаар Ангар, Ока голын бэлчир хүрч зүүн тийшээ Лена, Витим голуудын эхийг хамран Шилка, Амар мөрний бэлчир хүрч байв.

Хүннүгийн дорнод хил нь Хар мөрөн, Шилка голуудын бэлчрээс урагшлан Их Хянганы нурууны зүүн биеэр Нон, Сунгари мөрний бэлчирт тулан улмаар өмнө зүг Хан улсын Ляодун муж хүрч байжээ. Өрнө этгээдэд Хүннүгийн нутгийн хил нь Тэнгэр уулаас хойшлон Или Тарвагатайн нуруу, Эмээл голын хөндийгөөр Эрчис мөрөнд тулж байсан бололтой<sup>8</sup>. Энд нэг зүйлийг онцлон хэлэхэд хятадын цагаан хэрэм нь түүхэнд хил хязгаар гэдэг ойлголтыг хамгийн тод бодитой илэрхийлсэн зүйл бөгөөд “Азийн

<sup>3</sup> Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ., 2003. 234-235

<sup>4</sup> 史记. 卷. 110. 中华民国六十三年. 台北. 第2889页

<sup>5</sup> Саруул И. Хүннү гүрний хилийн харуул ба хамгаалалт. // Археологийн судлал. Т. XVI, F.1-11, УБ., 1996. 105 дахь тал

<sup>6</sup> Таскин В.С. Материалы по истории кочевых народов в Китае III-Y в. Вып.3. М., 1989. с.210

<sup>7</sup> 后汉书. 卷89. 中华民国六十三年. 第2942页

<sup>8</sup> Гэрэлбадрах Ж. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх (МЭӨ III-XIX зуун) УБ., 2002. 24 дэх тал



нүүдэлчид суурин аж ахуйт аймаг улсуудын дунд эртнээс (шинэ чулууны эцэс-хүрлийн үеэс) аяндаа бий болсон хилийн зааг<sup>9</sup>, “Дэлхийн түүхэнд байсан хамгийн үнэмлэхүй хил хязгаарын нэг” байсан гэдгийг эдүгээ ч бидэнд харуулж байгаа билээ. Цагаан хэрмийг хятадын түүхэнд умард зүгийн нүүдэлчдийн довтолгооноос хамгаалан барьсан хэмээн бичсээр ирсэн боловч НТӨ 369-290 оны үед буюу Хятадын “Байлдаант улсуудын үе” гэгдэх Чи, Янь, Чжао, Вэй, Цинь ванлиг улсуудын үед угаас хана хэрэм босгон суух дадал заншилтай хятад хүмүүс барьсан хэрэм билээ. Гэхдээ хятадын нутагт оршин тогтож байсан улсууд умардын нүүдэлчдийг эх нутгаас нь хөөн гаргаж тариалангийн шинэ газар эзэмшихээс гадна тухайн нутагт морь мал үржүүлэн морьт цэрэгтэй болох бодлогыг ямагт баримталж ирсэнтэй холбоотой байв.

Энэхүү булаан эзлэх бодлого нь “Байлдаант улсуудын үе”-д хятадын нутаг дэвсгэр дээр оршин суух олон жижиг вант улсууд төмрийг амьдралдаа өргөн хэрэглэх болсноор улам идэвхжсэн юм. Хятадад байгуулагдсан анхны нэгдсэн улс болох Цин улсын Цинши хуанди НТӨ 215 онд Мень Тень тэргүүтэй цэрэг илгээн Хүннүгийн үржил шимт Ордос нутгийг нь булаан авч, улмаар НТӨ 214 онд урьдын улсуудын барьсан хэрмийг шинэтгэн залган барьснаар өнөөгийн хятадын

цагаан хэрэм бий болсон байна. Өнөөгийн цагаан хэрэм нь баруун зүгт Ганьсу мужийн Жя И гуаниас эхлэн Нинься, Шэньси, Шаньси, Өвөрмонгол, Бээжингээр дайрч зүүн зүгт Хэбэй мужийн Шанхайгуан хүрч төгсдөг. Хэрмийн нийт урт нь 13400 ли.

Хүннү улсын засаг захиргааны төв нь тус улсын Орхон-Туулын сав газарт байсан<sup>10</sup> ба Хүннү улсын шаньюй хэмээх хаад гол төлөв орд харш байгуулж суудаг байжээ. Шаньюйн орд нь: Хааны орд, харш, тахилгын сүм зэргээр бүрэлдсэн нийслэл хотын шинжтэй байсан ажээ. Тэгэхдээ шаньюйн орд ганц биш өмнөд, умард орд бас зуслан, өвөлжөөний орд гэж ялгаатай байжээ.

**Дүгнэлт.** Хүннү нар өргөн удам газар нутагтай байсан бөгөөд хүчирхэгжин их гүрэн болсон үед газар нутгийн хэмжээ нь ихэд тэлэн томорч харин хүчин буурсан үед багасаж байжээ. Хүннүчүүд хил хязгаараа сахин суух тусгай цэрэгтэй хил хариуцсан вантай байсан нь хүчирхэг төр улс байгуулсны нэг илэрхийлэл юм.

Эдүгээ Хүннүг монгол угсаатан мөн эсэх талаар эрдэмтэн судлаачдын санал зөрүүтэй байдаг боловч өнөөгийн монголчуудын оршин сууж буй орон зай нь монголчууд, түүний өвөг дээдэс болох хүннү нарын уугуул нутаг байсан нь үндсэндээ нотлогдоод байна. Чухам энэ л нутагт тэд төр улсаа байгуулан, хүчирхэгжиж явжээ.

### Ашигласан материал:

1. Батсайхан З. Хүннү. УБ., 2003. 152 дахь тал
2. БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ., 1966
3. Гэрэлбадрах Ж. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх (МЭӨ III-XIX зуун) УБ., 2002
4. Саруул И. Хүннү гүрний хилийн харуул ба хамгаалалт. // Археологийн судлал. Т. XVI, F.1-11, УБ., 1996
5. Сүхбаатар Г. Монголын эртний түүх судлал. IY боть. (Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлийн эмхэтгэл) УБ., 2005
6. Таскин В.С. Материалы по истории кочевых народов в Китае III-V в. Вып.3. М., 1989
7. 史记. 卷. 110. 中华民国六十三年. 台北.
8. 林 杆. 中国古代北方民族通论. 呼和浩特., 1999
9. 后汉书. 卷 89. 中华民国六十三年. 第2942 页

<sup>9</sup> Мөн тэнд. 77 дахь тал

<sup>10</sup> БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ., 1966. 84 дэх тал

